

Ш.Оюунцэцэг, Л.Цэрэнчимэд,
Б.Оюунцэцэг, Ц.Туул

МОНГОЛ ХЭЛ VIII

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн
8 дугаар ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны
зөвшөөрлөөр хэвлэв.

Хоёр дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот
2019 он

ННА 74.2
ДАА 373
М-692

Монгол хэл VIII: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 8 дугаар ангийн сурах бичиг. /Ш.Оюунцэцэг, Л.Цэрэнчимэд, Б.Оюунцэцэг, Ц.Туул/
Ред. Д.Эрдэнэсан. Тех.ред. Н.Даваасүрэн- УБ.2017. - 148х

Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

Энэхүү сурах бичиг нь "Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай" хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр бүтнээр эсвэл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ textbook@mecs.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN 978-99978-61-06-1

ГАРЧИГ

ӨМНӨХ АНГИД ҮЗСЭНИЙГ ДАВТАХ	6
I. ДҮРСЛЭЛИЙГ ОЙЛГОЖ УНШИХ	11
1. Дүрслэн тайлбарласан эхийг задлан шинжилж, сэдэв гол санааг тодорхойлох	12
2. Хэлц, уран дүрслэл ашиглан, мэдрэмж сэтгэгдлээ тусган найруулж бичих	19
3. Утга ялган, зөв бичих	24
II. МЭДРЭМЖ, СЭТГЭГДЛЭЭ ИЛЭРХИЙЛЖ БИЧИХ	25
1. Эхээс зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлийг ялган, учрыг тайлбарлах	26
3. Мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлж бичих	29
2. Нутгийн аялгууны үгийг таних, найруулгын үүргийн тодорхойлох	34
III. МЭДЭЭЛЭЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ	39
1. Эхэд зохиогчийн ашигласан баримт, мэдээллийг ялгаж дүгнэлт гаргах	40
2. Тоочин тайлбарласан эхийг дэлгэрүүлж бичих	49
3. Угсарсан нийлмэл үгийг таньж, найруулгын үүргийг тодорхойлох	54
4. Балархай эгшгийн дүрмийг давтах	57
IV. МЭДЭЭЛЭН ТАЙЛБАРЛАЖ БИЧИХ	61
1. Тоочин тайлбарласан эхийг задлан шинжилж, сэдэв гол санааг тодорхойлох	62
2. Жишээ баримтаар баталж, тоочин тайлбарлаж бичих	67
3. Жишээ баримтаар баталж, тоочин тайлбарлаж ярих	73
4. Гадаад үг, хэллэгийн найруулгын үүргийг тодорхойлох	75
V. ШАЛТГААН, ҮР ДАГАВРЫН ХОЛБОО ХАМААРЛЫГ ГАРГАЖ БИЧИХ	77
1. Албан бичгийн эхийг задлан шинжилж, бүтэц үгийн сан, найруулгын онцлогийг тодорхойлох	78
2. Өгүүлбэрийг шалтгааны утгаар холбон найруулах	86
3. Албан бичгийн тогтсон бүтэц загварын дагуу учир шалтгааны холбоо хамаарлыг гаргаж бичих	87
4. Хатуу, зөөлний тэмдгийн дүрмийг давтах	97
VI. БАРИМТ БА ДҮРСЛЭЛИЙГ ХАРЬЦУУЛЖ, ДҮГНЭХ	99
1. Эхэд зохиогчийн ашигласан баримт, мэдээллийг ялгаж, дүгнэх	100
2. Шалтгааны утгатай угсарсан нийлмэл өгүүлбэрийн бүтсэн аргыг тодорхойлох	109
3. Жишээ баримт ашиглаж, дүрслэн тайлбарлаж бичих	113
VII. ИЛТГЭЛ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ	119
1. Баримт мэдээлэл ашиглан, үр дүнтэй илтгэх	120
2. Асуудал дэвшүүлэн баталж, нотолж тайлбарлаж ярих	128
VIII. АСУУДЛЫГ ТАЙЛБАРЛАЖ БИЧИХ	131
1. Эхэд дэвшүүлсэн асуудал, шалтгаан, үр дагаврын холбоо хамаарлыг тодорхойлж загварчлах	132
2. Жишээ баримтаар баталж уялдаа холбоотой тайлбарлаж бичих	136
3. Өгүүлбэр зүйд холбогдох дүрмийг зөв хэрэглэх	138
БАТАТГАЛ	140
Өөрийгөө шалгах хуудас	147
Нутгийн аялгууны үгийн толь	148


Нэгж хичээл	Унших - задлан шинжлэх эх
I. Дүрслэлийг ойлгож унших	<p>Дүрслэн тайлбарласан эхийг задлан шинжилж, сэдэв гол санааг тодорхойлох</p> <ul style="list-style-type: none"> • Хүн сайтыг олж нөхөрлө “Титэм үг” зохиолоос (<i>Н.Багабанди</i>) • Яарсан ч явган бүү суу, ядарсан ч ташуур бүү тул (<i>Монгол хэлний хэвшимэл хэлцийн толь</i>)
II. Мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлж бичих	<p>Эхээс зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлийг ялган, учрыг тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> • “Зун” шүлэг (<i>Д.Нацагдорж</i>) • Д.Нацагдорж “Дөрвөн цаг” шүлгийн тухай (<i>О.Дашибалбар</i>)
III. Мэдээлэлд дүн шинжилгээ хийх	<p>Эхэд зохиогчийн ашигласан баримт, мэдээллийг ялгаж дүгнэлт гаргах</p> <ul style="list-style-type: none"> • Гурван Цэнхэрийн агуйн зураг (<i>шинжлэх ухаан, танин мэдэхүйн эх</i>)
IV. Тоочин тайлбарлаж бичих	<p>Тоочин тайлбарласан эхийг задлан шинжилж, сэдэв гол санааг тодорхойлох</p> <ul style="list-style-type: none"> • Монгол гэр (<i>танин мэдэхүйн эх</i>)
V. Шалтгаан, үр дагаврын холбоо, хамаарлыг гаргаж бичих	<p>Албан бичгийн эхийг задлан шинжилж, бүтэц үгийн сан, найруулгын онцлогийг тодорхойлох</p> <ul style="list-style-type: none"> • Өглөө эрт босохын ач тус • Яаж эртэч хүн болох вэ? (<i>Зөвлөгөө</i>)
VI. Баримт ба дүрслэлийг харьцуулж, дүгнэх	<p>Эхэд зохиогчийн ашигласан баримт, мэдээллийг ялгаж, дүгнэх</p> <ul style="list-style-type: none"> • Мазаалайн тухай баримтууд (<i>судалгааны баримт</i>) • Халамцуухан мазаалай (<i>Ж.Мягмарсүрэн, Амьтдын тухай өгүүллээс</i>)
VII. Илтгэл хэлэлцүүлэх	<p>Баримт мэдээлэл ашиглан, үр дүнтэй илтгэх</p> <ul style="list-style-type: none"> • “Бид өсвөр үеийнхэн” цахим санал асуулгын үр дүнгээс (http://child.gov.mn/wp-content/uploads/2017/01/)
VIII. Асуудлыг тайлбарлаж бичих	<p>Эхэд дэвшүүлсэн асуудал, шалтгаан, үр дагаврын холбоо хамаарлыг тодорхойлж загварчлах</p> <ul style="list-style-type: none"> • Агаарын бохирдол ба эрүүл мэнд (<i>нийтлэлийн эх</i>)

Илэрхийлэх (бичих - ярих)	Хэл зүй	Сэргээн бататгах зөв бичих дүрэм
<p>Хэлц, уран дүрслэл ашиглан, мэдрэмж сэтгэгдлээ тусган найруулж бичих</p> <ul style="list-style-type: none"> • Сонгосон хэлцийн утгыг дэлгэрүүлэн тайлбарлаж бичих 	Хэлцийн онцлог шинжийг мэдэх	Утга ялган, зөв бичих
<p>Мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлж бичих, ярих</p> <ul style="list-style-type: none"> • Номоос төрсөн сэтгэгдлээ бичих • Зургаас төрсөн сэтгэгдлээ бичих 	Нутгийн аялгууны үгийг таних, найруулгын үүргийн тодорхойлох	
<p>Тоочин тайлбарласан эхийг дэлгэрүүлж бичих</p> <ul style="list-style-type: none"> • Эхэд шинэ баримт мэдээлэл, тайлбар оруулан бичих • Хоёр эхийг харьцуулан, дэлгэрүүлж бичих 	Угсарсан нийлмэл үгийг таньж, найруулгын үүргийг тодорхойлох	Балархай эгшгийн дүрмийг давтах
<p>Жишээ баримтаар баталж, тоочин тайлбарлаж бичих, ярих</p> <ul style="list-style-type: none"> • Сэдэв сонгон мэдээ, танилцуулга бичих 	Гадаад үг, хэллэгийн найруулгын үүргийг тодорхойлох	Гадаад үгийг зөв бичих
<p>Албан бичгийн тогтсон бүтэц загварын дагуу учир шалтгааны холбоо хамаарлыг гаргаж бичих</p> <ul style="list-style-type: none"> • Зөвлөгөө өгсөн захиа бичих • Тогтсон загвараар өргөдөл бичих 	Өгүүлбэрийг шалтгааны утгаар холбон найруулах	Хатуу, зөөлний тэмдгийн дүрмийг давтах
<p>Жишээ баримт ашиглаж, дүрслэн тайлбарлаж бичих</p> <ul style="list-style-type: none"> • Ховордсон ан амьтны тухай эх зохиож бичих 	Шалтгааны утгатай угсарсан нийлмэл өгүүлбэрийн бүтээн аргыг тодорхойлох	
<p>Асуудал дэвшүүлэн баталж, нотолж тайлбарлаж ярих</p>		
<p>Жишээ баримтаар баталж уялдаа холбоотой тайлбарлаж бичих</p> <ul style="list-style-type: none"> • Сэдвээс сонгон, асуудал дэвшүүлсэн эх зохиож бичих 		Өгүүлбэр зүйд холбогдох дүрмийг зөв хэрэглэх

ӨМНӨХ АНГИД ҮЗСЭНИЙГ ДАВТАХ

1. Тэмдэг нэр, дуурайх үг, зэрэгцсэн нийлмэл үгийг ялгаж.

а. Загварыг дэлгэрүүлж ярилцахдаа “А, Б, В” эхүүдээс тохирох жишээг олж батлаарай.



А. Үүрийн жавар уурын чимээ

Умард уулын оройгоор бараан манан оргин буцалж, шамарга цас бөөн бөөнөөр хаялаад, эргэн тойрон харанхуйлж, дөрвөн зүгийг олохуйяа бэрх, хөндий талыг цасан хунгар бүрхээд, хязгааргүй мөсөн далай болж, түүний дунд хүн мал орших байтугай зэрлэг араатан зугтан зайлмаар байв. Тэгж байтал, тэртээ давааны үзүүрт хоёр хар гэр, овоолсон аргал мэт бүрэг бараг үзэгдэх бөгөөд ар талыг нь цас хэдийнээ хөрзөнтөн хучиж, өмнө этгээдээс хаалга үүд нь харанхуй будангийн дундуур нэг нүх адил харагдана. Улам ойртвол, хотон дотор нь хоёр гурван туранхай үнээ хөндлөн гулд унаж, хошуугаа газар шаан хэвтээд, хаяанд нь нэг халтар нохой зогсон, баруун умард зүг тийш нэг үе ульж, нэг үе хуцна... (Д.Нацагдорж)

Б. Борооны араншин

Шиврээ бороо шивнэн
 шиврэн шившинэ.
Азарган бороо аархан
 сайрхан шаагина.
Аадар бороо агсран
 цутган аархана.
Цагаан бороо аяглан
 маяглан цайрна.
Зүсэр бороо зөөлөн аядуу зүсэрнэ.
Дуутай бороо цахилан
 доргиулан нүргэлнэ.
(Г.Дагва)

В. ...Тавхийтэл мориноосоо бууж,
тасхийтэл жолоогоо сойгоод, тоосонд
дарагдсан урд хормойгоороо наранд
шарагдсан нүүрийнхээ хөлсийг
арчиж, нусаа хүрхийтэл нийгээд гэрт
оров. (Д.Нацагдорж)

Тарган хээрийн алхаа нь
Товор товор товор гэнэ ээ хө
Таван хэлхээ шигшрэг нь
Шигэр шигэр, шигэр шигэр гэнэ ээ хө
(Шигшрээгийн ай)

Суг суг гүйдэлтэй
Сухай улаан дээлтэй (үнэг)

- Эдгээр эхийн найруулга тэгш хэмтэй, сонсголонтой байгаа нь юунаас шалтгаалж байна вэ? Ярилцаарай.
- “шивнэн шиврэн, аядуу зөөлөн, бөөн бөөн, шигэр шигэр” гэсэнтэй адил үгсийг ялган бичээрэй.
- Эдгээр нь ямар аймгийн үгс байна вэ?
- Ялгасан үгсэд дүрслэлийн үүрэгтэй үг байна уу? Ярилцаарай.
- “А” эхийг дүрсэлсэн юмс, үйл хөдлөлийн утгаар нь цогцолборт хувааж болох уу? Саналаа солилцоорой.

2. Шинж байдлыг тоочин дүрсэлсэн зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийг танья.

а. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж, морины цолыг гүйцээн бичээрэй.

Ашиглах үг: хотолз, гялалз, холбилз, эрмэлз, яралз, солбилз, эргэлд, сагсалз, суна, шаширла

Заан дөрвөн соёог

Заамал зургаан хүзүүг

Төө сайхан чихийг

Төгрөг сайхан нүдийг

Сагсгар сайхан дэлийг

Шанам сайхан сүүлийг

Туулай сайхан зоог

Тураг сайхан биеийг

Эрчит дөрвөн хөлийг

Эрдэнэт дөрвөн туурайг

Дайрч гарсан даяны хүлэг

Давхиж гарсан хангайн буга

(МАЗ)

б. Хурдан морины цолд юуны шинжийг дүрсэлсэн байна вэ? Ярилцаарай.

в. Гадаад ба дотоод шинж, үйл хөдлөлийн хувирал ба үйлийн дүр байдлын алийг дүрсэлснийг тайлбарлана уу.

г. Эхэд тэмдэг нэрийг ямар үүрэгтэй ашигласан бэ?

д. Морины цолны гурван бадагт өгүүлбэрүүд нь ямар онцлогтой байна вэ? Холбогдсон аргыг ажиглаж, тайлбарлаарай.

3. Дүрслэн бичсэн эхийг уншъя.


а. Сонирхолтой дүрслэл бүхий хэсгийг тэмдэглэж уншаарай.

...Би өглөө гэрээс гаруутаа хаяандаа суниан сатаарч, наран улайрах зүүнтээ хөвчийн хөх сэрвэнг саравчиллаа. Нар хөвчийн оройгоос хөөрөөд, огторгуйн цээлийг илчээн хөвлөө. Цас хөлрөх бор уулсын энгэр нарны илчинд намжааран*, хөвчийн хаяагаар зэрэглээ жирвэгнэж, тэртээ хөндийд ч, энэтээ бэлд ч чихнээ торох авиа чимээ огтоос үл дуулдах мэт атлаа толгодын элгээр урин сэвшээ салхи бут, боргийн орой исгэрүүлж, бор шувууд босон суун дэрхийлдэж, айсуу цагийн зар тархааж буй болов уу гэж бодогдоно. Хот айлуудын яндангаар аргалын утаа бургилан, хот хороондоо хивж хэвтсэн үнээ мал бууцнаас босон, нуруу хондлойгоо хотолзуулан шилгээгээд, тошин* шимэхээр гол руу цувлаа. Сүрэг жунгаа* далавчаа наранд гилтгэнүүлэн үхэр даган нисэлдээд, голын захын бут, довуулд бууж, бараа тасарлаа. Хөндий талын хярхгаар* нар тэнгэрийн гүнд улайран өнхөрч, уул толгодын сүүдэр хормой бэлээсээ зугуу зугуухнаар огшин хуйлагдана. Болжмор хадны орой, элгээр сүлжин нисэлдэх нь агаа жөтөө асмаар дур зоргоороо, хүслэн мэт чөлөөтэй, “Иш чааваас, хүн бид шувуу байсан ч байгаасай! Дуртай зүгтээ нисэж, дуртай газраа бууж, дуртай бүхэнтэйгээ дуртай цагтаа цугтаа байх сан!...” гэж бодогдон, юунд ч юм жигтэй адгах* сэтгэл цээж сэрвэлзүүлээ. Үхэр сүрэг голын тошин* шимээд, борогт* хөндийн эх өөд бэлчин гэлдэрцгээнэ...

(Д.Урианхай)

- б. Тэмдэглэсэн хэсгээсээ өгүүлэгчийн мэдрэмж илэрхийлсэн үг, холбоо үг, өгүүлбэрийг ялган бичнэ үү.

Дүрслэл сайтай аливаа эхийг уншихад тухайн юм, үзэгдэл, газар орны байдлынсайхныг таван мэдрэхүйгээр хүртсэн мэт мэдрэмжийг уншигч, сонсогчдод төрүүлнэ.



- в. Бичсэн хэсгээсээ “харах” мэдрэмжийн илэрхийлэл, түүнээс төрсөн сэтгэгдлийг хүснэгтийн дагуу задлан тэмдэглээрэй. Үлгэрлэвэл:

Дүрсэлсэн юм	Мэдрэмж, сэтгэгдэл
- Хөдөө нутаг	- Болжмор хадны орой, элгээр сүлжин нисэлдэх нь агаа жөтөө асмаар дур зоргоороо, хүслэн мэт чөлөөтэй. - ?

- г. Эхэд байгаа уран дүрслэл бүхий үг, өгүүлбэрээс гурван жишээ сонгон аваад, тайлбарлана уу. Үлгэрлэвэл:

Жишээ:	Уран дүрслэл:
...нар огторгуйн цээлд хөвөх...	Дэлхий, нарны хөдөлгөөнийг усны шувууны хөвөхтэй, тэнгэр огторгуйг ус далайтай адилтган дүрсэлсэн.
...	

- д. Эхэд хаана байгаа юм, үзэгдлийг тоочин дүрсэлсэн байна вэ? Ярилцаарай.

Уран сайхнаар дүрслэн бичсэн эх нь зохиогчийн уран сэтгэмж, сэтгэл хөдлөл, авьяасын илэрхийлэл байдаг. Дүрслэхийн тулд юуг сонгох нь өгүүлэгчийн чөлөөт сэтгэлгээний илрэл болдог байна.

- е. Од (*)-оор тэмдэглэсэн үгсийн утгыг хам сэдвийн хүрээнд тайлбарлаж ярилцаарай. Дараах алхмын дагуу үгийн тайлбарыг олж үзээрэй.

Үгийн утга тодруулах алхам

1. Утгыг нь ойлгохгүй байгаа үгсийг тэмдэглэх
2. Тэмдэглэсэн үгсийг толь бичгээс хайх
3. Монгол хэлний тайлбар толь бичгээс үгсээ олох
4. Утгын бүх тайлбарыг унших

5. Уншиж буй эхийн утгад тохирох тайлбарыг ялгаж, дахин унших
6. Утгын бусад тайлбарыг дахин нягталж унших. Мэдэхэд илүүдэхгүй шүү!

7. Уншиж байгаад орхисон хэсгийг үргэлжлүүлэн унших. Хэрэв унших хүсэл төрөхгүй бол утга тодорхойгүй үг байна гэсэн үг. Ийм нөхцөлд тухайн үгийн утгыг толь бичгээс дахин лавлаж хараарай.

- Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь”, Уб., 1966 (2013)
- “Монсудар”-аас эрхлэн гаргасан “Монгол хэлний тайлбар толь”, Уб., 2011
- “Монсудар”-аас эрхлэн гаргасан “Монгол хэлний сурагчийн тайлбар толь”, Уб., 2015


4. Загварт найруулгаар бичсэн эхийн онцлогийг ойлгож уншъя.

Сургуулийн захиргаанаас хүрээлэн буй орчныг хамгаалах зорилгоор 8 дугаар ангийн сурагчдын оролцоотой “Эко бүлэг” байгуулахаар шийдвэрлэж, ажиллах журмыг дараах байдлаар баталжээ.

а. “Эко бүлэг”-ийн ажиллах журамтай танилцаарай.

Нэг. “Эко бүлэг” болон сургуулийн хамтын ажиллагааны талаар

Сургуулийн захиргаа, бүлгийн хоорондын албан харилцааг зохицуулах үүднээс “Эко зөвлөл”-тэй байна.



Хоёр. Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааны талаар

- *Итгэл үнэмшилтэй байх* - Тухайн ажлыг өөрийн болон бусдын сайн сайхны төлөө хийж байгаагаа ухамсарласны эцэст тодорхой үр дүнд хүрнэ гэдгийг бусад гишүүн, олон нийтэд ойлгуулан итгүүлнэ.
- *Сонирхолтой байх* - Бүлгийн гишүүд, бусад оролцогч явуулж буй үйл ажиллагаанаас баяр баясгалан, сайн сайхныг мэдрэх нь хамгийн чухал. Аливаа ажлыг “сонирхолтой, идэвхтэй оролцохуйц” байдлаар зохион байгуулахад анхаарна.
- *Оролцоог нэмэгдүүлэх* - Багш, сурагчид, эцэг эх, ард иргэдийн ажил мэргэжил, ур чадварт нь тулгуурлан, үйл ажиллагаандаа урьж оролцуулах

- нь олон нийтэд хүрэх үндсэн арга болно.
- *Үр дүнгээ тайлагнах* - Зохиосон ажлынхаа талаар ханын сонин, үзэсгэлэн гаргах, идэвхтэн оролцогч шалгаруулах зэргээр нийтэд байнга мэдээлж байна.

б. 8 дугаар ангийн сурагч бүр бүлгийн гишүүн болох тул “Эко зөвлөл”-өө журамд заасны дагуу нийтийн хурлаар байгуулаарай.

5. Илтгэх хуудас бичье.

Сургуулийн удирдлагад хандаж, “Эко зөвлөл” байгуулсан тухай “Илтгэх хуудас” бичээрэй.

Бичихдээ:

Эхлэл хэсэгт: - Юунд үндэслэн, хэзээ, ямар зорилгоор юу хийснийг;

Гол хэсэгт: - Зорилгоо биелүүлсэн тухайг;

Төгсгөл хэсэгт: - Ямар үр дүнд хүрснийг тусгах бөгөөд дараах загварыг баримтлаарай.

Сурагчдын эко бүлэг

ИЛТГЭХ ХУУДАС

“Эко зөвлөл” байгуулсан тухай

20..... оны.....сарын..... (хот, дүүрэг, сум)

.....

.....

.....

.....

.....

Хянасан:

“Эко бүлэг”-ийн ахлагч: (.....)

Бичсэн:

“Эко бүлэг”-ийн гишүүн..... (.....)

I ДҮРСЛЭЛИЙГ ОЙЛГОЖ УНШИХ



Эзэмших мэдлэг, чадвар

Дүрслэн тайлбарласан эхийг задлан шинжилж, сэдэв гол санааг тодорхойлох

Хэлц, уран дүрслэл ашиглан, мэдрэмж сэтгэгдлээ тусган найруулж бичих

Утга ялган, зөв бичих

Дүрслэн тайлбарласан эхийг задлан шинжилж, сэдэв гол санааг готорхойлох

1. Дүрслэн тайлбарласан эхийн утгыг ойлгож уншъя.

- а. Дүрслэн бичсэн эхийн онцлог ямар байдгийг сэргээн санаж ярилцаарай.
- б. Дараах эхийг уншихдаа “Өмнөх ангид үзэснийг давтах хэсэг”-т байгаа эхүүд (Тухайлбал: “Борооны араншин”)-тэй дараах асуултын дагуу харьцуулаарай.
Үүнд:

- Бичсэн аргын хувьд дүрсэлсэн үү?, Тайлбарласан уу?
- Дүрсэлсэн юмс нь ижил байна уу?
- Хэмжээ нь ямар байна вэ?
- Эхэд дэвшүүлсэн асуудал нь юу вэ?
- Зохиогчийн бичсэн зорилго нь ямар байна вэ?
- Зохиогчийн чухалчилсан санаа нь юу вэ?
- Чухал хэсгээр дамжуулж, юу хэлэхийг зорьсон бэ?

Хүн сайтыг олж нөхөрлө

“Сайн шувуу модоо шилж сууна.

Сайн хүмүүн хүнээ олж нөхөрлөнө.” гэх хуучны үг сургамжтай. Хүнийг нөхөрлөж буй хүнээр нь шинждэг нь аль ч үндэстэнд байдаг нийтлэг зүйл. Үүнийг монголчууд “хүнийг нөхрөөр нь шинж” гэж хэлдэг. Хүнээ олж нөхөрлөх нь энэ яваа насны ээнэгшин ижилдэх эрхэм үйлсийн оргил билээ. Нэгэн биеийн нөхөр, нимгэн хувцасны нөмөр болох хүнээ таньж олох нь залуу хүн чиний хувьд амьдралдаа хийх амжилттай сонголтын нэг яах аргагүй мөн. Яагаад гэвэл, нөхрийн сайнаар хүн өөдөлж, нуурын сайнаар загас жаргаж явдаг гэдэг. Хүн хүнийхээ хүчинд, загас усныхаа хүчинд байдаг болохоор ийм байх нь аргагүй ээ. Нөмөр сайтай гэр дулаан байдгийн адил нөхөр сайтай хүн нөмөр нөөлөгтэй байна.

Алаг хорвоогийн амьдрал баян болохоор аян замын уртад ачлах сайн нөхөр таарахын зэрэгцээ аман дээрээ сүрхий, ачир дээрээ базаахгүй нь ч уулзана. Тус болох нөхөр гурав, ус болох нөхөр гурав байдаг тухай дорнын нэгэн сэтгэгчийн сургаал бий. “Тус болох нь шулуун нөхөр, шударга нөхөр, ихийг дуулсан нөхөр болно. Ус болох нөхөр нь нүүр тал засагч, зусар бялангач, цуурхай задгай амт нөхөр болой” гэжээ. Тус болох нөхөртэй үй зайгүй найзалж, ус болох нөхрөөс үүдэн хоймрын зай барьж яв. Өгөө аваан дээр суурилсан нөхөрлөл өнө удаан тогтохгүй. “Өөрийн үйлийг бүтээх төдий нөхөрлөл аминч хүнтэй өнө сайтар ханилан явахад ер бэрх” гэж бидний өвөг дээдэс анхааруулж хэлснийг өнөө цаг үед бүр ч илүү санууштай. Тэнэг нөхөр тээг садаа болно. “Тэнэг нөхрөөс ухаантай дайсан дээр” гэсэн үнэн үг бий. Тэнэг хүн харагдах гэж урд нь бултганана. Ухаантай хүн харах гэж ард нь үлдэнэ.

Сайн нөхрөө харж, саар талаа зас. Дотно нөхрөө урмаар тэтгэж, сэтгэлийн тэнхээ хайрлаж сурах нь нөхөрлөл батжих нэг үндэс. Хүн гар татуу, сэтгэл дутуу байхыг алийг тэр гэх вэ. Гэхдээ нөхрөө дэмнэн, сэтгэлийг засах урам магтаалын үгэндээ татуу, дутуу байж яавч болохгүй. Нөхдийн ололтыг

дэмжиж, магтан сайшаахын хамт дутууг гүйцээж, дутагдлыг хэлж өгөх чухал.
 “Гаргасан алдааг минь хэн зөвөөр хэлнэ, тэр миний багш
 Хэрэг явдлын минь үнэнийг хэн шударгаар тэмдэглэнэ, тэр миний нөхөр
 Надад хэн зусардана, тэр миний дайсан” (Сюнь Цзы) гэсэн дорнын
 мэргэн үг хэн нөхөр, хэн дайсан болохыг ялгаж танихад тусална. Хүн сайтыг
 олж нөхөрлөвөл хүний хорвоод магнай тэнэгэр, магад жаргалтай амьдарна.
 t (Н.Багабанди “Тутэм үг”)

2. Эхийн утга, санааг ойлгосноо ярилцъя.

- Эхийн цогцолборуудыг холбож буй ямар үг, өгүүлбэр байна вэ? Ярилцаарай.
- Эхээс хэлийг түүж бичээд, ямар учиртай байгааг нь ярилцаарай.
- Түүж бичсэн хэлийг дараах загварын дагуу товч тайлбарлаж болно. Үлгэрлэвэл:

1 Сайн шувуу модоо
шилж сууна
Сайн хүмүүн хүнээ олж нөхөрлөнө

2 “шил-ол”, “суу-нөхөрлө” зэрэг ойролцоо
үгийг зэрэгцүүлж, шувуу-хүн хоёрыг
адилтган дүрсэлжээ. Иймээс адилтгал
болно.

3 Үүнийг монголчууд хүнийг нөхрөөр нь
шинж гэж хэлдэг.

- Нэг ба гуравдугаар баганад байгаа хэсгүүд ямар хамааралтай байна вэ? Тайлбарлаж бичээрэй.
- Хүснэгтэд тэмдэглэсэн хэцүүдэд загварын дагуу товч тайлбар бичээрэй. Үлгэрлэвэл:

1	Хэлц	2	Уран дүрсэлэл	3	Гол санаа буюу тайлбарласан хэсэг
	Нэгэн биеийн нөхөр Нимгэн хувцасны нөмөр		Адилтгал, тойруулал		Яагаад гэвэл, нөхрийн сайнаар хүн өөдөлж, нуурын сайнаар загас жаргаж явдаг гэдэг.
	Нөхрийн сайнаар хүн өөдөлнө Нуурын сайнаар загас жаргана		Адилтгал		Нөмөр сайтай гэр дулаан байдгийн адил нөхөр сайтай хүн нөмөр нөөлөгтэй байна.
	Хүн хүнийхээ хүчинд Загас усныхаа хүчинд		?		?
	Аман дээрээ сүрхий Ачир дээрээ базаахгүй	
	Тэнэг нөхөр тээг садаа болох	
	Тэнэг хүн харагдах гэж урд нь бултганана Ухаантай хүн харах гэж ард нь үлдэнэ	

- Тайлбарласан хэлийн утгыг ажиглаж, дугаарлаад, хүснэгтийн баганад тэмдэглээрэй.

Ойролцоо утгатай үг, өгүүлбэрээс бүтсэн	Эсрэг утгатай үг, өгүүлбэрээс бүтсэн
1; 3...	2; 5... гэх мэт

3. Хэлцийн онцлог шинжтэй танилцъя.

- а. "Хүн сайтыг олж нөхөрлө" эхэд сургаж хүмүүжүүлсэн утга байсан уу? Байсан бол энгийн үг, өгүүлбэр, хэлцийн алинаар илэрсэн бэ? Яагаад?
- б. Уг эхийг өөрөөр нэрлэж болох уу? 1-2 хувилбар олж бичээрэй.

Хэлц нь тухайн хэлээр хэлэлцэгч ард түмний үндэсний онцлог, ахуй амьдралтай гүн холбоотой байдаг учир утга нь тэр бүр тодорхой ойлгогдохгүй байж болно. Хэлцийг бүрдүүлж байгаа үгс утга хэрэглээний талаас нэг цогц болж, уран дүрслэлээр бүтсэн байдаг нь түүний чухал шинж мөн. Монгол хэлэнд таван хошуу мал, цаг улирлын байдалтай холбоотой хэлц түгээмэл байдаг. Жишээ нь:

- “хорголоо тоолсон”, “шар нар бор хоногийг өнгөрөөх...”
- “хаврын тэнгэр шиг”, “хэвтээ хонь босгохгүй...”
- “тэмээ ямаа хоёр шиг”, “усны дусал мэт...”

Хэлцийн онцлог шинж нь:

- ✓ Хоёр ба түүнээс дээш үг нийлж бүтсэн байна.
- ✓ Уран дүрслэлээр бүтэх тул утга шилжсэн байна.
- ✓ Бүрэлдэхүүн дэх үгсийг өөр үгээр сольж болохооргүй хэвшсэн байна.
- ✓ Утга зүй, хэл зүйн холбооноос шалтгаалан нарийн ялгаатай байх нь бий.

Хэлцийн бүрэлдэхүүнд байгаа үг, өгүүлбэр утгын хувьд эсрэг, эсвэл ойролцоо байж болно. Жишээ нь:

“Хүний эрээн дотроо

Могойн эрээн гаднаа”

“Хүний хүү зорьсондоо хүрнэ

Хүлэг морь харайсандаа хүрнэ” гэх мэт.

- в. Дараах эхийг уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй. Тэгэхдээ:

- Г.Аким., *Өвөрмөц хэлцийн тайлбар толь*, Уб., 1999
- "Монсудар", *Монгол хэлний өвөрмөц хэлцийн толь*, Уб., 2011 зэрэг толиос утга бүрхэг үгсийн тайлбарыг хараарай.

Яарсан ч явган бүү суу Ядсан (ядарсан) ч ташуур бүү тул

Монголчууд явган суухыг нохой суудал хэмээн цээрлэнэ. Нохой суудлаар суух нь хүн атал нохой адил “нохой явган, гахай нүцгэн болох” гэсэн ёр цөв гэж үзнэ. Ер нь таагүй зүйлийг хэлэхдээ “нохой зан”, “муу нохойн гэдсэнд шар тос тогтохгүй”, “нохойн толгойг шороон дээр тавьсан ч шороон дээр унах”, “нохой гахайдаа хүрэх” зэргээр нохойтой зүйрлэдэг. Гагцхүү тэнгэр болоочийг нутаглуулах газар шинжихдээ нохой явган суудлаар хагас сууж, хардаг байснаас ийнхүү цээрлүүлжээ.

Ташуур тулах гэдэг нь унаанаасаа салж явгарч, ташуураа таягчлан тулах гэсэн санаа юм. Монголчууд эр хүн хөдөө хээр мориноосоо салах хийморь золбоонд муу хэмээн үл таашаана. Адаглаад эмээлтэй морь ижилдээ ирвэл сүргээ үргээн жигшээх, зэл авхуулах, туйлуулах сүргийн буян хишигт цөвтэй, намар цаг бол үргээж хайлуулах гээд үүдэх уршиг олон. Ийнхүү явгарахын ёр бэлгэ гэхийн зэрэгцээ “модоо барих”- гуйлгачлахын ёр гэж цээрлэнэ.

(Монгол хэлний хэвшмэл хэлцийн толь, 76-р тал)

- Эхэд байгаа наймаас доошгүй хэлцийг ялган бичээрэй.
- Эхийг бичихдээ ийм олон хэлц ашигласны учир юу вэ? Ярилцаарай.
- Утгыг нь мэдэхгүй хэлц байна уу?
- Бичсэн хэлцээсээ хоёрыг сонгож, хүснэгтийн дагуу товч тайлбарлаарай. Багаараа хамтарч гүйцэтгээд, бусдадаа танилцуулж, саналыг нь сонсоорой.

1	Хэлц	2	Уран дүрслэл	3	Гол санаа
.....		


4. Хэлц үгийн утга, уран дүрслэлийг тайлбарлая.

а. “Яарсан ч явган бүү суу

Ядсан (ядарсан) ч ташуур бүү тул” эхийн даалгаврыг гүйцэтгэхэд ямар бэрхшээл тулгарав? Харилцан ярилцаарай.

-
-

Хэлцийн утга санааг тайлбарлах алхмыг загварчлан харууллаа. Ярилцаарай.




б. Загварт үзүүлсэн алхмаар хэлцийн утгыг тайлбарлах аргад суралцаарай.

Алхам 1. Уг хэлцээр илэрхийлдэг гол санааг мэдэх, утга бүрхэг бол бусдаас асуух эсвэл хэлцийн тайлбар толь бичгээс харна. Үлгэрлэвэл:

“Нохой явган, гахай нүцгэн”	“Нохой хамартаа хүрэхээр усч”
Гол санаа буюу толь бичгийн тайлбар:	
Ядуурах, үгүйрэх	Цагаа тулахаар чадахгүй зүйлээ ч хийх

Алхам 2. Тухайн хэлцийн гол санаа нь ямар нэг үйл явдал, бодит байдлаас үүдсэн байдаг тул үүнийг тайлбарлах гэдэг нь анх юунаас болж хэлэлцэх болсон шалтгааныг эрж сурвалжлахыг хэлнэ. Үүний тулд:

Хэлц анх юунаас үүдсэнийг хаанаас мэдэж болох вэ?




Үлгэрлэвэл:

Нохой явган, гахай нүцгэн	Нохой хамартаа хүрэхээр усч
Анх юунаас үүдсэн:	
Нүүдэлчин монголчуудын ахуй соёлтой холбоотой. Нүүж суухад нохой явган дагадаг бол харин гахай бараг үсгүй байдгаас	Ямар ч нохой хэчнээн их ус, ширүүн голыг төвөггүй сэлээд гарах чадвартай байдгаас
тус тус адилтгаж, зүйрлэн хэлэлцэж заншжээ.	

Алхам 3. Гол ба үүссэн санааг мэдсэн цагт уран дүрслэлийг тайлбарлахад төвөггүй болно. Үлгэрлэвэл:

Нохой явган, гахай нүцгэн	Нохой хамартаа хүрэхээр усч
Уран дүрслэл нь:	
Унах унаагүй хүнийг нохойтой, өмсөх хувцасгүй хүнийг гахайтай адилтгасан.	Нохойн усанд сайн сэлдэг төрмөл байдлыг аливаа ажлыг цагаа тулахаар ямар нэг аргаар хийж гүйцэтгэх хүний зан байдалтай адилтгасан.

Монголчууд:



гэх зэргээр “Адилтган зүйрлэж, егөөдөн” хэлэлцдэг. Энэ мэтээр хэлцийн уран дүрслэлийг тайлбарлана.

Алхам 4. Тайлбарлаж буй хэлцийн ойролцоо ба эсрэг утгатайг нь түүвэрлэн цуглуулж, тохирох үлгэр, домог зэргээр дэлгэрүүлбэл бүрэн гүйцэд болно. Үлгэрлэвэл:

Нохой явган, гахай нүцгэн	Нохой хамартаа хүрэхээр усч
Ойролцоо утгат хэлц нь:	
“модоо барьсан”, “чаа гэх ямаагүй, чүү гэх морьгүй”, “хөл дүүжлэх унаагүй”	“хийх хүн арга хайна, хийхгүй хүн шалтаг хайна”, “эвлэвэл бүтнэ, ховловол гутна” гэх мэт

Алхам 5. Ийм алхмаар судалж бичиж сурвал эх хэлний эрдэнэсийн сан болсон хэлцийн утга санааг ойлгож, монгол сэтгэлгээний гайхамшиг, монгол хэлний үгийн сангийн баялаг бүхнээс суралцана.

5. Хэлцийн онцлог шинжийн талаар мэдлэгээ бататгая.

а. Хүснэгтэд өгсөн хэлцүүдийг уншиж ажиглаарай.

гар	“гар газар, хөл хөсөр”, “гар татуу”, “гар бариад бугуй барих”, “гараа гаргах”, “хоёр гартай”, “гарын үзүүрээр хийх”, “нэг гараа нөгөөгөөр барих”, “урт гартай”, “гарын салаагаар урсгах”, “гар нь ганзагад, хөл нь дөрөөнд хүрэх”
өр	“өр нимгэн”, “өр зөөлөн”, “өр өвдөх”, “өрөнд бариулж, өтөнд идүүлэх”, “өртэй хүн өөдлөхгүй, өтэй мал таргалахгүй”, “өр шир нэхэх”, “өрөвдөхөд өр өшиглөх”, “өрний цаагуур чулуудах”, “өр зээл тавих”, “өр зүрхээ чагнах”
ам	“амандаа ус балгасан мэт”, “амаа үдүүлсэн юм шиг”, “ам нь ардаа гарсан юм шиг”, “амаа барих”, “ам хэлээ билүүдэх”, “амаа алгадуулах”, “амны гарз”, “ам хэлээ ололцохгүй”, “амны хишигтэй”, “амны бэлгээс ашдын бэлгэ”
толгой	“хөл толгой нь мэдэгдэхгүй”, “толгой мэдэх”, “толгой цусдах”, “толгой даах”, “том толгойтой”, “толгой цохих”, “өөрийн толгойгүй”, “толгой хагарагч малгай дотроо, олгой хагарагч тогоон дотроо”, “толгойтныг бөхийлгөх, тойгтныг сөхрүүлэх”, “хар толгойдоо гомдох”
нүд	“нүд алдах”, “нүдний гэм”, “нүд нь орой дээрээ гарах”, “нүднээс далдуур”, “нүд хариулах”, “нүдээ олох”, “нүдээ хөхөртөл”, “нүд үзүүлэх”, “нүд хөмсөг болсон”, “нүд халтирах”

сана-	“цагаан санаатай”, “санааны мухарт хадгалах”, “санаан зоргоор”, “хар санах”, “санасан газар, болгосон идээ”, “санаа алдах”, “санаа нь гүйцэгдэхгүй”, “сайн санааны үзүүрт тос, ...”, “муу санаатай”, “санаанаас гарахгүй”
хөл-	“хөлсөх”, “хөл хорих”, “хөл мэдэн явах”, “хөлийн газар”, “хөлөө гамнах”, “усны хөл”, “хөлд нь суух”, “хөлийн дүн”, “хөлөө шороодох”, “хөл газар хүрэхгүй”
мэд-	“мэднэ мэднэ гэж мэлхий алж ганзагалах”, “мэдэхгүй мянган үгийн таглаа”, “мэдлэгт оройгүй”, “мэдсэн мэдээгүй хоёрын дунд”, “жор мэдэхгүй эмчээс зовлон үзсэн чавганц дээр”, “мэддэгт мэргэн цоохор, мэдэхгүйд эрэн цоохор”, “мэдэмхийрэх нь мэргэдэд харш”

- б. Өмнө сонсоогүй, утгыг нь сайн мэдэхгүй, хэлц хэр олон байна вэ? Толь бичиг ашиглан мэдэж аваарай.
- в. Хосоороо дөрвөн хэлц сонгоод, гол санаа ба юунаас үүдэснийг тайлбарла. “Хэлцийн утгыг тайлбарлах алхам дараалал”-ыг баримтлаарай.
- г. “хөл”, “мэд” гэсэн үг орсон хэлцийг дараах асуултын дагуу харьцуулаарай.
- Бүтцийн хувьд ямар байна вэ? Үг, холбоо үг, өгүүлбэрийн аль нь вэ?
 - Бүрэлдэхүүнд нь байгаа үгс үндсэн утгаараа юу, утга нь шилжсэн үү?
 - Үг тус бүрийн тодорхой утга алдагдаж, бүхэл шинжтэй болсон уу?
 - Ямар нэг юм үзэгдлийг шууд зааж зүйрлэсэн үү?
 - Сургаж хүмүүжүүлсэн утга байна уу?
- д. “хөл”, “мэд” гэсэн үг бүхий хэлцүүдэд байгаа онцлогийг нэгтгэж тайлбарлана уу.
- “Хэлцийг хэн сайн мэдэх вэ?” сэдвээр мэтгэлцээн зохиож болно. Дараах хоёр чиглэлийг анхаараарай.

№	Зохион байгуулалт	№	Асуулт даалгаврын чиглэл
1	4 гишүүнтэй 3-4 баг оролцохоор төлөвлөх	1	Сугалсан хэлцийнхээ гол санааг тайлбарлаж ярих
2	3 сурагч шүүгчээр ажиллах	2	Өгсөн хэлцийн эсрэг ба ойролцоо утгатайг олох
3	1 сурагч хөтлөгчөөр ажиллах	3	“зүрх, элэг, сэтгэл” гэх зэрэг үгс орсон хэлц аль болох олныг олж хэлэх
4	Зарим сурагч хөгжөөн дэмжигч болох	4	Хэлцийн хувилбараас өгүүлбэр дэх цэгийн оронд тохируулан нөхөх
5	Хөгжөөн дэмжигчдийн дунд тэмцээн зохиох	5	Хэлцээр өгүүлбэр зохиох гэх мэт

- Мэтгэлцээний бэлтгэл, үнэлэх шалгуур зэргийг багштайгаа хамтарч хийгээрэй.

Хэлцийн утгыг тайлбарласан эх зохиох нь тэдгээрийг найруулгад оновчтой сонгож, утга санааг зөв уялдуулан, уран дүрслэлтэй бичиж сурахад тустай юм.

Хэлц, уран дүрслэл ашиглан, мэдрэмж сэтгэгдлээ тусган найруулж бичих

1. Хэлцийн гол санааг дэлгэрүүлж, дүрслэн тайлбарласантай танилцъя.

Алхам 1. “Тэнгэрийн царай харах” гэсэн хэлцийн утгыг дэлгэрүүлэн, эх зохион бичих төлөвлөгөө гаргаарай.

а. Уг хэлцийнхээ гол санааг ойлгож мэдэх нь чухал. “Тэнгэрийн царай харах - Цаг улирлын байдлыг харах, аж амьдралаа зохицуулах”

б. Гол санаатай уялдуулан, юуны тухай дэлгэрүүлж бичихээ төлөвлөөрэй.

- Тэнгэр эрхэс, цаг агаарыг шинжих тухай хэлц учраас монголчуудын эрхэлдэг аж ахуй, амьдралын туршлагатай холбож тайлбарлах нь зүйтэй.
- Дүрслэн тайлбарлаж бичих тул уг хэлцтэй утгаараа холбогдож болох бусад хэлцийг бүртгэж тэмдэглэнэ. Үлгэрлэвэл:

Цаг цагаараа байдаггүй
Цахилдаг хөхөөрөө байдаггүй

Өглөөний нарыг наранд бүү бод
Өсөхийн жаргалыг жаргалд бүү бод

Дуутай тэнгэр бороогүй
Цуутай хүүхэн хуримгүй

**ТЭНГЭРИЙН
ЦАРАЙ ХАРАХ**

Нарны эртэд малаа бэлчээ
Насны залууд эрдэм сур

Орох тэнгэрийн орой цоорхой
Орсон буурын шил цоорхой

Ширүүн бороо удадаггүй
Шиврээ бороо удаг

Тэнгэр
эвгүйрхэх

Салхи урдаасаа урих

Тэнгэр хангай хилэгнэх

Тэнгэр задраах

Алхам 2. Тэмдэглэсэн хэлцийнхээ утгыг ажиглаж, эхийн бүтцийн аль хэсэгт ашиглахаа бодож бичнэ. Үлгэрлэвэл:

Эхлэл
хэсэгт

Монголчуудын амьдралын туршлагын талаар бичихэд ямар хэлцийг хамааруулж болох вэ?

Гол
хэсэгт

Монголчуудын цаг уурын уламжлалт мэдлэг, тэнгэр шинжихдээ хүн амьтан, байгаль ертөнцийн үзэгдлээс юуг ажигладаг тухай бичихэд хэлцийн аль нь холбоотой байна вэ?

Төгсгөл
хэсэгт

Жилийн дөрвөн улиралд нүүдэллэж амьдрахдаа байгаль дэлхийтэйгээ яаж харьцаж, хамгаалж, шүтэж ирсэн талаар нэгтгэн бичихэд хамаарах хэлц байна уу?

Алхам 3. Цуглуулсан мэдээллээ ашиглан, дээрх загвар төлөвлөгөөний дагуу эхээ бичиж болно. Үлгэрлэвэл:

“Тэнгэрийн царай харах” хэлцийн утга

Бэлчээрийн сайхныг дагаж, мал сүргээ адуулан аж төрж ирсэн нь монголчуудыг олон зүйл ухаанд сургажээ. Эдгээрийн нэг нь цаг уурын уламжлалт мэдлэг мөн. Монголчууд “Цаг цагаараа байдаггүй, цахилдаг хөхөөрөө байдаггүй” гэдэг хэлцийг шууд болон шилжсэн утгаар нь түгээмэл хэлэлцэнэ. Энэ хэлц малаа хотлуулахдаа маргааш ямар байхыг, үүр цүүрээр босохдоо өдөр нь хэрхэхийг ажиж заншсан малчдын аж төрлөөс үүдсэн нь гарцаагүй.

Монголчууд тэнгэрийн байдлыг шинжихдээ гараг эрхэс, таван хошуу мал, араатан гөрөөс, жигүүртэн шувуу, хорхой шавж, эд юмс, газар орны байдлыг тус тус ажиглаж, “салхи урдаасаа урих”, “тэнгэр эвгүйрхэх нь”, “хараацай доогуур нисэх” гэх мэтээр ярилцана. Үүгээр ч зогсохгүй хал үзэж, халуун чулуу долоосон ахмад настнууд бие махбодоороо тэнгэр муухайрахыг зөгнөн хэлнэ. Туршлагаар шалгарсан энэ бүх мэдлэгээ зүйр үг, хэлцэд шингээн “Өглөөний нарыг наранд бүү бод, өсөхийн жаргалыг жаргалд бүү бод”, “Ширүүн бороо уддаггүй, шиврээ бороо уддаг”, “Үүл сөрвөл бороо, үг сөрвөл хэрүүл”, “Орох тэнгэрийн орой цоорхой, орсон буурын шил цоорхой” зэргээр хэлэлцдэг заншилтай.

Өвөг дээдэс маань байгаль дэлхийгээ хайрлах хамгаалах үүднээс “тэнгэр задраах”, “тэнгэр хангай хилэгнэх” зэргээр хэлэлцдэг байсан нь ус нутаг, хангай дэлхийгээ унаган төрхөөр нь байлгах эрхэм уламжлалын илрэл юм.

(Ц.Шагдарсүрэн “Монголчуудын утга соёлын товчоон”)

- a. “Тэнгэрийн царай харах” гэдгийн утгыг дэлгэрүүлэн тайлбарлаж бичихдээ хэд хэдэн хэлц ашигласны учрыг ярилцаарай.
- б. Уг хэлцийн утгыг тайлбарлахдаа ямар баримт ашигласан бэ? Яагаад? Тайлбарлаарай.

2. Дүрслэн тайлбарлаж бичихдээ хэлцийг зөв хэрэглэе.

- a. Эхийг уншихдаа хэлцийн утгыг яаж дэлгэрүүлэн тайлбарласныг дараах асуултын дагуу ажиглаарай.
 - Хэлцийн утгыг дэлгэрүүлэн бичихдээ ямар эх сурвалж ашигласан бэ?
 - Монгол уламжлал, ёс заншилтай холбоотой байна уу?
 - Гол санааг илэрхийлсэн арга нь ямар байна вэ?
 - Юунаас, ямар үйл явдлаас үүдсэнийг бичсэн үү?
 - Зөвхөн нэг хэлцийн хүрээнд бичсэн үү?
 - Ойролцоо санааг хэлцийг дурдсан уу?

Хөхөө өвлийн хүйтэнд

Хөр цасны жаварт

Монголчууд өвлийн гурван сарыг хүйтрэх, хөр цас унах байдлаар нь гурав гурван есөд хувааж, есөн есийн наян нэгэн хоногийн хүйтэн болдог гэж үзнэ. 12-р сарын 22-оос ес эхэлнэ. Эхний гурван есийг балчир, дундхыг идэр, сүүлийнхийг хөгшин гурван ес гэдэг. Энэ нь хүний насаар бол бага,

залуу, өтөл үетэй зүйрлэсэн нэр юм. Идэр есийн хүйтэнд гунан үхрийн эвэр хөлдтөл хүйтэрдэг. Энэ үеийг цаг тооны хуучин тооллоор “хөхөө сар” гэдэг ажээ. Өвөл хөхөө байхгүй атал “хөхөө өвөл” гэж хэлдэг нь үүнээс улбаатай бөгөөд улмаар “хөхөө өвлийн хүйтэн, хөр цасны жаварт” гэсэн хэлц үг дэлгэрсэн байна. Үүнтэй холбоотой “хөхөөг хүйдсээр цохих” гэсэн огтоос бүтэхгүй юмыг зүйрлэн хэлсэн гол санаатай хэлц буй болсон. Анх үүдсэн нь өвөл хөхөө шувуу үзэгдэхгүй; хүйдэс (малын хөлдүү баас) зөвхөн өвлийн хүйтэнд байдаг. Тэгэхээр хөхөөг хүйдсээр цохих гэдэг бодит байдалд байх боломжгүй зүйл болно. Үүнтэй ойролцоо утгатай “харганын ноос түүж унгас хийх”, “нар, баруун хойноос гарах”, “зангууны үлгэр”, “аалзны шүлсээр гөлөм гөрөх” зэрэг хэлц бий.

(Д.Баттогтох, “Үлгэрээс үүдсэн хэлцийн толь”-оос)

б. Хүснэгтэд байгаа хэлцийн тайлбарыг гүйцээж бичээрэй.

1	2	3	4
Тайлбарласан хэлц нь	Гол санаа	Анх юунаас үүдсэн	Уран дүрслэл
Хөхөө өвлийн хүйтэнд Хөр цасны жаварт	?	?	эхний гурван ес- балчир дунд гурван ес- идэр адаг гурван ес- хөгшин - адилтгал
Хөхөөг хүйдсээр цохих	?		?
Ойролцоо утгат хэлцүүд			?
			?

в. Өмнөх алхам дараалал, жишээ баримтыг ажиглаад, бие дааж хэлцийг тайлбарлан бичээрэй.

САНАМЖ

Бичихдээ дараах санамжийг баримтлаарай.

- ✓ Тайлбарлах хэлцийг сонгох
- ✓ Бичихээр сонгосон хэлцийн гол санааг ойлгох
- ✓ Сонгосон хэлцийн юунаас үүдсэнийг эрж сурвалжлах, мэдээлэл цуглуулах
- ✓ Цуглуулсан мэдээлэл, баримтаа эмхлэх, чухлыг ялгах
- ✓ Бичих төлөвлөгөөгөө гаргах
 - Эхлэл: Тайлбараар эхлэх үү? Уран дүрслэлээр эхлэх үү? гэдгээ сонгох
 - Гол хэсэг: Тайлбарлахад ашиглах баримт, дүрслэлийг зөв дараалуулах
 - Төгсгөл хэсэг: Ашигласан баримт мэдээлэлдээ тулгуурлан, тайлбараа дүгнэх
- ✓ Ойролцоо ба эсрэг утгат хэлцийг олж бичих
- ✓ Эхээ ноороглон бичих. Энэ үед сонгосон хэлцийн гол утга санаанд холбогдуулан, өөрийн мэдрэмж, сэтгэгдлийг аль ч хэсэгт илэрхийлж болно.
- ✓ Учир зүйн алдаагүй, оновчтой дүрслэн бичихэд анхаарна.
- ✓ Бичсэнээ нягтлан уншиж, зөв бичих дүрмийн болон найруулгын алдаагаа хянах, сийрүүлэн бичих

Өөрийгөө сорьё.

1. Эхийг уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Хоёр залуугийн үлгэр

Эрт цагт Их залхуу гээч зартай залхуу хүн байж гэнэ. Нэг өдөр түүн дээр залуухан хархүү ирээд:

- Би танд шавь орохоор ирлээ. Та надад залхуурахыг зааж өгнө үү гэжээ.

Их залхуу:

- За тэгье. Урьдаар би энэ гурилыг элдчихье. Хүү минь залуугаараа босоод, завгайд байгаа гамбанз аваад өг дөө гэсэнд, Бага залхуу:

- Яаж босох вэ? Яршиг даа. Нуруун дээр минь нухсан гурилаа элдчих гэжээ.

Энэ цагаас “Залхуу хүн завгайдаа хүрдэггүй” гэх шог хэлц үг дэлгэрчээ.

(Д.Баттогтох, “Үлгэрээс үүдсэн хэлцийн толь”-оос)

- а. “Залхуу хүн завгайдаа (монгол гэрийн туурганы хоолой, цаваг хоёрын завсар. Заваг ч гэнэ.) хүрдэггүй” гэсэнтэй ойролцоо утгатай хэлц таваас доошгүйг олж бичээд, үлгэрийн гол санаатай холбон ярилцаарай.
- б. Хэлцийн утгыг тайлбарлан бичээрэй.

Хэлц	Таны бодол	Толь бичигт тайлбарласан нь	Жишээ
Нар баруун хойноос навтас нөмөрч гарах	?	Хэзээ ч бүтэхгүй зүйл	?
Өр зүрхээ чагнах			
Хөл толгой нь мэдэгдэхгүй			
Нэг гараа нөгөөгөөр барих			
Нүдээ хөхөртөл...			
Хар шоргоолж адил			

- в. Дараах хэлцийн утгыг ярилцаад, тохирох үгтэй нь харгалзуулаарай.

1. Сохор харын өртөөнд очих
2. Давсанд явах
3. Нүдний хор гаргах
4. Цурам хийх
5. Дугхийх

хажуулах
зүүрмэглэх
дугжрах
хурхирах
унтах

- г. “Айргийг нь ууж, ангаа гармагц алагч гүүг мартана”, “Ховдог хүнд хонины бөөр ихтэй багатай” гэсэн хэлцэд дэлгэрэнгүй тайлбар бичээрэй. Бичихдээ өмнө ажилласан даалгавар, загвар, алхам дарааллыг ашиглаарай.

2. Эхийг уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

“Савын гурван гэм” гэдэг хэлцийн утга

Нэгэн талаас багш нь номлох, нөгөө талаас шавь нь ихэд хичээнгүйлэн суралцах үйлийн барилдлага тэгш бүрдвээс сая эрдмийн хишиг хүнд тогтдог болой. Энэ нь цэвэр ариун, бүрэн бүтэн саванд өрөм загсаахтай адил юм.

Нэгэн зүйл: Номын ширээнд багшийн урд суувч чихээр үл сонсон, өөр юм бодох нь хөмөрсөн тогоонд сүү юүлж дүүргэж болдоггүйтэй үлгэр нэг.

Хоёр зүйл: Багшийн айлдах номыг чихээр сонсовч хагас хугас тогтоох нь цоорхой тогоонд хийсэн сүү мөдхөн гоожиж дуусах мэт.

Гурван зүйл: Чихээр сонсовч утгыг үл ухаарах, ухаарлаа ч буруу тогтоох нь бохир саванд хийсэн сүү гашлан ээдэж, өрөм цөцгий суудаггүй лүгээ адил.

Нэгтгэн дүгнэвээс, уруу харуулсан сав, цоорхой сав, бузартай саванд сүү хөөрүүлж, өрөм загсааж болдоггүй. Үүн лүгээ адил багшийн номыг сонсдоггүй, алдаг оног сонсдог, сонслоо ч утгыг буруу ухаардаг шавь эрдэм сурдаггүй. Ном сурахын өмнө “савын гурван гэмийг тэвч” гэдэг сургаалын утгын тайлал ийм.

(Т.Галсан)

- Эхэд юуны тухай тайлбарлан бичсэн байна вэ?
- Тайлбарлахдаа уран дүрслэл ашигласан хэсэг байна уу? Ялган тэмдэглээрэй.
- Тухайн уран дүрслэл яаж бүтэснийг загварын дагуу тайлбарлана уу. Үлгэрлэвэл:

Уран дүрслэл	Юу ашигласан	“юуг- юутай”	
Адилтгал	“адил”	шавь хичээнгүйлэх	цэвэр саванд өрөм загсаах
...
...

- Эхийн дүгнэлт хэсэгт байгаа ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

Сав		Шавь	
1	уруу харуулсан	а	алдаг оног сонсдог
2	цоорхой	б	сонслоо ч буруу ухаардаг
3	бузартай	в	ном сонсдоггүй
Сүү хөөрүүлж, өрөм загсааж болохгүй.		Эрдэм сурахгүй.	

- Эхэд “шавь”-ийг “сав”-тай адилтган зүйрлэсний учир юу вэ? Өөр ямар нэг зүйлтэй зүйрлэж болох уу?
- Эхийн гол санаанд холбогдох хэлц таваас доошгүйг олж бичээд, уран дүрслэлийг тайлбарлаарай. Үлгэрлэвэл: “Нэг чихээрээ оруулаад нөгөө чихээрээ гаргах”, “Хичээвэл сурдаг, хийвэл бүтдэг” гэх мэт

Утга ялган, зөв бичих

а. Хоёр хэсэгт байгаа жишээг ажиглаад холбогдох дүрмийг ярилцаарай.

Оноосон нэр <i>Төмөрөөр, Дарханаас</i>	Ерийн нэр <i>төмрөөр, дархнаас</i>
Тодотгон холбохын “Х” <i>дарах, халах, чимэх</i>	Нэр үгийн “Х” <i>дарх, халх, чимх</i>
Хоолойн “Г” <i>тарга, булга, дарга</i>	Хэлний “Г” <i>тараг, булаг, дарга</i>
Хэлний үзүүрийн “Н” <i>хаана, хоног, сана</i>	Хэлний угийн “Н” <i>хаан, хонго, сан</i>

б. Үгсийг утгаар нь зөв холбоод, холбоо үг бүтээж, өгүүлбэр зохиож бичээрэй.

анах, удаа, отож, анх, тараг, бүрх, бүрэх, малгай, будаг, шунах, өнгөнд, шунх, халах, аялгуу, толгой, халх, чанах, хойно, цай, чанх, бөмбөг, цөлх, цөлөх, эр, бай, онх, онох, буух, эрэх, мэдэл, номоо, эрх, тостой, торох, нүдэнд, торх

в. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээд, дүрмийг тайлбарлаарай.


I	II
..... утаа боргилсон Малчны гэрт төрсөн би... явбал үхэр тэргээр туулай гүйцнэ.
“Алтан үлгэр”-ийг Ц.Дамдинсүрэн орчуулжээ. ихэдвэл шулам болно.
Өсөхийн бүү бод.	Идээшиж дассан гэр минь танан
Төрлийн эх нь, усны эх нь ухааны салбарт нээлт хийжээ.
“..... муухай дэгдээхий” хэмээх алдарт үлгэрийг Андерсен зохиожээ.	Уулархаг нутгаар олон жилийн дунджаас илүү хур байх гэнэ.
Малчид намар оторт гарч малаа алхаатай яа Дал мөрөө дагасан гээгтэй еэ хө

г. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй. Нөхөх үг: хувиараа, хорогдоно, хуваариа, хоргодно.

Монголчуудын дийлэнх нь хөдөлмөр эрхэлж байна.
 Их сургуулийн оюутнууд хичээлийн өөрөө сонгодог болжээ.
 Төрсөн нутаг, ээж ааваа бодохоор сэтгэл
 Зарим аймгийн сумдаар хаваржилт хүндэрвэл, малын тоо толгой



МЭДРЭМЖ, СЭТГЭГДЛЭЭ ИЛЭРХИЙЛЖ БИЧИХ



Эзэмших мэдлэг, чадвар

Эхээс зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлийг
ялган, учрыг тайлбарлах

Мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлж
бичих

Нутгийн аялгууны үгийг таних,
найруулгын үүргийн тодорхойлох

Эхээс зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлийг ялган, учрыг тайлбарлах

1. Эхийн утгыг ойлгож, зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлийг олъё.

а. Шүлгийг урнаар уншаарай.

Зун

Цагийн сайхан зуны эхэнд
 Газрын сайхан хангайн нуруунд
 Хөхөө шувуу урьхнаар донгодох үес
 Энэхүү дэлхий юутай сайхан тааламжтай
 Ногооны униар огторгуйд тулж зэрэглэн мяралзахад
 Хүлэг морь урт янцгааж, төрсөн нутгийг зүглэнэ
 Цэцгийн хур дэлхийн нүүрийг угаахад
 Залуу хүмүүсийн сэтгэл сэргэж, бие биеэ бодно
 Үзэсгэлэнт уул, тунгалаг ус зуны цагт тэгш
 Эрийн гурван наадам Монголын манлай баясгалан
 Хүүхэд багачуудын гийнгоолох дуу хөндий талд яруу
 Хурдан морины яралзан ирэх нь хүн бүхний бахдал
 Уудам талд наадам цэнгэлийн аялгуу зөөлнөөр цуурайтна
 Хээр хөдөөд таван хошуу мал дураараа бэлчинэ
 Өрх бүрийн үүдэнд айраг сархдын үнэр сэнгэнэнэ
 Ийм сайхан баясгалантай, тийм сайхан жаргалтай

(Д.Нацагдорж)

б. Шүлэгт нүдээр харж, чихээр сонсож, хамраар үнэрлэж, хэлээр амталж, биеэр хүртэж мэдэрч болох хэсэг байна уу? Нөхөж бичээрэй. Үлгэрлэвэл:

Шүлгийн мөрүүд:	Яаж мэдэрч болох вэ?
Цагийн сайхан зуны эхэнд Газрын сайхан хангайн нуруунд	Харах
Ногооны униар огторгуйд тулж зэрэглэн мяралзахад	
Хүлэг морь урт янцгааж	
Цэцгийн хур дэлхийн нүүрийг угаах	
Залуу хүмүүсийн сэтгэл сэргэх	
Үзэсгэлэнт уул, тунгалаг ус зуны цагт тэгш	
Эрийн гурван наадам монголын манлай баясгалан	
Хүүхэд багачуудын гийнгоолох дуу хөндий талд яруу	
Хурдан морины яралзан ирэх	
Уудам талд наадам цэнгэлийн аялгуу зөөлнөөр цуурайтах	
Хээр хөдөөд таван хошуу мал дураараа бэлчих	
Өрх бүрийн үүдэнд айраг сархдын үнэр сэнгэнэнэ	

6. *Зохиогч шүлгийн мөр бүрд мэдрэмжээ яаж уран яруу илэрхийлснийг ярилцаарай. Мэдрэмжээ илэрхийлэхдээ ямар уран дүрслэл хэрэглэсэн байна вэ? Тайлбарлаарай. Үлгэрлэвэл:*

1. *Цэцгийн хур дэлхийн нүүрийг угаахад* - Зуны дэлгэр цагт байгаль дэлхий өнгөө засаж, цэцэг навч дэлгэрдэг байдлыг хур бороо орохтой адилтгасан. Нүүр - хүн амьтны толгойн өмнө этгээд. Аливаа юмын өвөр, урд тал. Ямар нэгэн зүйлийн харагдах өнгөн тал гэсэн утгаас салбарлуулан, дэлхийн нүүр хэмээх амьдчилал хэрэглэжээ.

2. *Ногооны униар огторгуйд тулж зэрэглэн мяралзахад* - Хаврын урин дулаан болоход агаарын хэм нэмэх рүү шилжихэд цас мөс хайлж, хөлдүү газар гэсэж, уур дэгддэг. Энэхүү үзэгдлийг “Униар огторгуйд тулах, униар зэрэглэн мяралзах” хэмээн урнаар дүрсэлжээ. “Хөх униар татах, ногооны униар” гэсэн хэллэгүүдийн утгыг толь бичиг ашиглан мэдэж аваарай.

2. *Зохиогчийн мэдрэмжээ илэрхийлсэн байдлаас төрсөн сэтгэгдлээ хуваалцана уу. Сурагч бүрийнх адилхан байна уу? Учрыг ярилцаарай.*

2. “Зун” шүлэгт зохиолч мэдрэмж, сэтгэгдлээ яаж илэрхийлснийг олж уншъя.

Д.Нацагдоржийн “Дөрвөн цаг” шүлгийн тухайд

“Дөрвөн цаг” бол дэлхийн яруу найрагчид аль ч үед хүч чадлаа сорин туршдаг сэдэв юм. Нацагдоржийн номын эхний хуудсыг нээх бүр, үргэлж шинэ санагдах хэрнээ, хуучин танил шиг дотно түүний ертөнц рүү би орж явчихдаг юм. Хуудас бүхнээс Монгол орны минь салхи сэр сэр үлээж, бүлээн бороо шивэрч, оргилын мөнх цас гялбан, мөр бүхнээс нь цэцэгсийн үнэр анхилж, монгол хүний уй гуниг, баяр жаргал сонсогдох бүлгээ. Нацагдоржийн ном надад үүл нүүсэн хөх тэнгэр шиг, үргэлж амьдрал буцалсан дэлхий шиг мөнхийн санагдана. Энэ номоос үй түмэн өнгө, аялгуу, үнэр, зүсэн зүйлийн дүр төрх, зан авирыг мэдрэх бүр Нацагдоржтой дэлхий дээр ирсэндээ би баярладаг.

Нацагдоржийн “Зун” шүлэгт малчин ардын энэ нэгэн улирлын амьдрал нь бүхий л амт, өнгө, үнэртэйгээ дүрслэгдэж, зуны борооны зөөлөн аяс, аянга цахилгаан, аадрын ширүүн цохилго, цэцэгсийн шивнээ баяр цэнгэл, хөгжим дуу, найр наадам, хурдан морьдын төвөргөөн сонсогдоно.

“...Үзэсгэлэнт уул, тунгалаг ус, зуны цагт тэгш

Эрийн гурван наадам Монголын манлай баясгалан

Хүүхэд багачуудын гийнгоолох дуу хөндий талд яруу

Хурдан морины яралзан ирэх нь хүн бүхний бахдал...” Энд үнэхээр нэг жаргалтай ардын цэнгэлтэй аялгуу сонсогдох агаад баяр баясгалангийн симфони гэж нэрлэж болмоор! Чухам ясны монгол шүлэгч л үүгээр бахархах агаад давааны орой дээр өндөлзөн, түрүү морь гарч ирэхэд нулимсан дунд нь уулс торолзож, хоолой дээр нэг юм зангиран, хурдан морины яралзан ирэх нь яруу сайхны нэгэн жигд давтамж болон бүх биеэр нь тархаж, хүүхдийн гийнгоолох дуунд баярын нулимс нь өөрийн эрхгүй сад тавин, мориндоо мордон давхиулах малчин ардын зураг нүднээ үзэгдэнэ. Энэ шүлгийн мөр бадгийн завсар зай бүхнээр нарны гэрэл үерлэн цутгасаар, “Уудам талд

наадам цэнгэлийн аялгуу зөөлнөөр цуурайтна”. Дөрвөн улирлын гайхамшиг найртай сайхан зуны цаг ирэхэд үнэхээр хүн төрөлхтөн, түмэн бодисын толгой сэргэнэ. Нацагдорж дөрвөн улирлын дотроос зун цагийг хамгийн төгс төгөлдөр манлай улирал, амьтны жаргалыг соёрхогч гэж үзжээ. Тэгээд ч зуныг “Дөрвөн улирлын гайхамшиг” гэж нэрлэсэн байна. “Дөрвөн цаг” цувралын “Зун” шүлэг үнэхээр төгс төгөлдөр нь бөгөөд “Цэцгийн хур дэлхийн нүүрийг угаахад”, “Эрийн гурван наадам Монголын манлай баясгалан болж”, “Уудам талд наадам цэнгэлийн аялгуу зөөлнөөр цуурайтсан” гайхамшигт амьдралын тухай дуулал юм.

(О. Дашибалбар)

- а. Эхээс тайлбарласан юм болон түүний тайлбарыг ялгаж болох уу?
- б. Зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлсэн хэсгүүд байна уу? Тэдгээрт “харах, сонсох, үнэрлэх, хүртэх, амтлах” таван мэдрэхүйг дүрсэлж, сэтгэгдлээ илэрхийлснийг ялган бичээрэй. Үлгэрлэвэл:

“...Хуудас бүхнээс Монгол орны минь салхи сэр сэр үлээж, бүлээн бороо шивэрч, оргилын мөнх цас гялбан, мөр бүхнээс нь цэцэгсийн үнэр анхилж, монгол хүний уй гуниг, баяр жаргал сонсогдох бүлгээ...” гэсэн нэг өгүүлбэрээс:

харах	оргилын мөнх цас гялбах;
сонсох	монгол хүний уй гуниг, баяр жаргал сонсогдох;
үнэрлэх	мөр бүхнээс нь цэцэгсийн үнэр анхилах;
хүртэх	хуудас бүхнээс Монгол орны минь салхи сэр сэр үлээх, бүлээн бороо шиврэх;


зэргээр “Зун” шүлгийг уншаад, амтлахаас бусад мэдрэхүйгээр олж авсан мэдрэмжээ гайхамшигтай дүрслэн тайлбарлажээ. Цаашлаад төрсөн сэтгэгдлээ “Нацагдоржийн ном надад үүл нүүсэн хөх тэнгэр шиг, үргэлж амьдрал буцалсан дэлхий шиг мөнхийн санагдана” гэж бичжээ.

...?

- в. Бүдүүвчээр үзүүлсэн номын талаарх уран дүрслэлийг тодруулж, учрыг тайлбарлан ярилцаарай.




- г. Эрдэмтэн зохиолч Ц.Дамдинсүрэн “Миний сэтгэгдэл”-д номын ач холбогдлын талаар:



гээж дүрсэлснийг “в” даалгаврын уран дүрслэлтэй харьцуулан ярилцаарай.

- д. “Миний сэтгэгдэл”-д номыг зохиогчийн талаар болон зохиогчтой уулзахад төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ дараах байдлаар дүрсэлжээ. Үүний уран дүрслэлийг тодруулж ярилцаарай.



Зохиогчтой уулзах нь нартай тунгалаг өдөр цэцэгт өргөн талаар үлгэрийн сайхан дагинатай зугаалах мэт...

- е. Чамд хамгийн сонин сайхан мэдрэмж, гүн сэтгэгдэл төрүүлсэн ямар ном, зохиол байдгийг ярилцаж, саналаа солилцоорой.

Мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлж бичих

- а. Уншсан номоос төрсөн сэтгэгдлээ нэгтгэж, тайлбар бичээрэй. Бичихдээ дараах алхмыг баримтлаарай.


Алхам

- Багаараа ярилцан, цаасны гол хэсэгт цааш нь дэлгэрүүлэх сэдвээ бичнэ. Нэг үг, холбоо үг, богино өгүүлбэрээр ч байж болно.
- Сэдэвт хамаатай хамгийн сонин, хачин мэдрэмж төрүүлсэн санаануудаа тойруулан бичиж, сэдэвтэйгээ шугамаар холбоно. Санаагаа аль болох өргөжүүлж, олон зүйл бичихийг чухалчилна. Цагаа зөв хуваарилах хэрэгтэй.
- Санаанд орсноо улам бүр өргөжүүлэн салбарлуулж 2 ба 3-р шат үүсгэн бичиж болно.
- Бичсэн зүйлд чинь утгын болон учир зүйн талаас холбоотой асуудлууд гарч ирвэл хооронд нь бас холбож болно.
- Санаагаа бүрэн гаргаж, ижил төстэйгөөр нь бүлэглэн нэгтгээд, эмхэлж бичээрэй.

Бүдүүвч загвар ашиглах нь бичих зүйлийн санааг өргөжүүлэхэд тустай. Тухайн зохиолоос сэтгэлд хоногшсон үйл явдал, баатруудын харилцаа холбоо, төрсөн сэтгэгдэл зэрэг санаанд орсон зүйлээ бичнэ.

Зөвхөн уг зохиол, эхэд өгүүлснийг бус өөр номоос уншсан хэсэг, өөрийн туршлага ч байж болно. Мэдрэмж, сэтгэгдлээ зөв илэрхийлж сурвал насан туршдаа амжилттай ажиллаж, амьдрах зөв гараагаа ч олох боломжтой юм шүү.

- б. Багаар ажиллахдаа дараах бүдүүвч загварыг ашиглаарай. Яаж ажиллахыг Английн зохиолч Ж.К.Роулингийн “Харри Поттер ба Эрлийз ханхүү - 6” номоор үзүүлье.



в. Зургаас төрсөн сэтгэгдлээ бичээрэй.

Ч.Цогбаяр “Монгол нүүдэл”



г. “Монгол нүүдэл” зурагт сурагчийн бичсэн тайлбарыг уншаарай.

Нүүдлийн цай

“Нүүдэл, нүүдэл” гэж
Гадаа хүүхэд хөөрнө.
“Уудал, уудал” гэх шиг
Гал дээр цай оргино.
Өнгөрөөд явчих вий гэж
Ээж гэртээ сандарна.
Өрөм зөөхийд хөөрцөглөж
Хийц амтыг нь болгооно...

...Дайн дарсан баатар
Угтах гэж байгаа юм шиг
Дайраад л гарах нүүдлийг
Ээж минь амдан гүйнэм.
(С.Дулам)

“Монгол нүүдэл” зургаас төрсөн сэтгэгдэл

...Өглөөхөн чанасан цай
Домбоны хүзүүгээр халуун ч
Өндөр хангайд зорьсон
Нүүдлийнхэнд шинээр хийцлэв... гэсэн
“Нүүдлийн цай” шүлгийн нэг бадгаар энэ
зургийн агуулгыг илэрхийлж болно. Үнэхээр эх
орны минь байгалийн сайхан, монгол уламжлалт
ёс заншлыг харуулсан гайхалтай сайхан бүтээл
юм. Хөх уулсын орой хяраас нь сэрүүн салхин
хийсгэж, ус голын мэлмэрээнээс нь цэнгэг агаар
сэнгэнээд, таван хошуу мал, таван тэмээт хөсгөөс
амар амгалан, аливаа бүхний жаргалын дээд
мэдрэгдэнэ. “Үртэй хүн жаргаж, үндэстэй мод
цэцэглэнэ” гэдэгчлэн тэгнээтэй араг дахь бяцхан
хүүхдүүд, нүүдэл тосож яваа хөөрхөн хүү, хоточ
банхрын гөлөг, хунгийн дэгдээхий зэргээс
ертөнцийн хамаг л ариун цагаан, гэнэн цайлган
бүхний туйл, хайр энхрийллийг хүртнэм.

(Ө.Өнөрөө)

- д. Хосоороо хамтарч, зургийн тайлбарт үнэлгээ өгнө үү. Үнэлэхдээ “тийм, үгүй” гэсэн баганад (+), (-) тэмдэг тавиарай. “Үгүй” гэсэн тэмдэглэгээтэй шалгуур байна уу? Ярилцаарай.

№	Шалгуур	Тийм	Үгүй
1	Тайлбарлаж буй юм буюу зургийн гол агуулгыг тайлбар эхээр бүрэн илэрхийлсэн үү?		
2	Эхийн бүтцийн хэсгүүдийг догол мөрөөр илэрхийлсэн үү?		
3	Тайлбарлахдаа мэдрэмжээ илэрхийлсэн хэсэг байна уу? Хаана нь байна вэ?		
4	Зургийг тайлбарлахдаа уран дүрслэл ашигласан уу? Аль хэсэгт нь байна вэ?		
5	Эхийн аль хэсэгт бичигч сэтгэгдлээ илэрхийлсэн бэ?		
6	Холбоо хамааралгүй зүйлийг дүрсэлсэн хэсэг байна уу?		
7	Найруулгын болоод зөв бичих дүрмийн алдаа байсан уу?		
8	Гарчиг нь сонин, содон байж чадаж байна уу?		

е. Сайжруулах оновчтой хувилбар олж, саналаа нэгтгээрэй.

Зураг тайлбарлахдаа мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлж бичих алхам

- ✓ Тайлбар хийх зургаа сайтар ажиглах;
- ✓ Дүрслэхээр сонгож авсан юмсын хоорондын хамаарлыг сайтар тооцох;
- ✓ Ойлгосноо төсөөлөн бодох, зураглах;
- ✓ Сонирхолтой гарчиг өгөх;
- ✓ Зургийн чухам юу нь сонин, хачин, этгээд санагдсаныг тайлбарлахад анхаарах;
- ✓ Санаагаа цаасан дээр буулгаж ноороглох;
- ✓ Мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэхдээ дүрслэлтэй бичих;
- ✓ Хүн бүрийн мэдрэх байдал, сэтгэгдлээ илэрхийлэх нь ялгаатай тул өөрийнхөөрөө тайлбарлах;
- ✓ Учир зүйн алдаагүй байх;
- ✓ “Ямар нэг зүйлийг дүрслэх гэдэг хоёр юмыг аль нэг төстэй шинжээр нь адилтгах, эсвэл холбоо бүхий аль нэг зүйлээр орлуулахыг хэлнэ.” Тиймээс бодит байдалд хоорондоо холбогдохгүй, адил төсгүй зүйлсийг зэрэгцүүлэх, зүйрлэх, адилтгах нь учир зүйн талаас алдаа болно. Жишээ нь:


<p>Жаргаж буй говийн наран зэрэглээнд талимааран, сүүдэрт нь сумыг тойрсон толгод галт тэрэг шиг угсраа харагдана.</p>	<p>“наран талимаарна” гэж дүрсэлсэн нь харанхуй болоогүй байгааг илэрхийлж байна. Гэтэл “сүүдэрт нь” хэмээн бичсэн нь учир зүйн талаас холбоогүй, юуны сүүдэр нь мэдэгдэхгүй болсон тул алдаатай болжээ. Мөн сумыг тойрсон толгод “галт тэрэг шиг угсраа” гэсэн нь төдийлөн оновчтой биш болсон байна гэх мэт</p>
<p>Сайхан саар <u>дурсамжууд</u> сэтгэлийн гүнээс <u>хөвхөлзөнө</u>.</p>	<p>дурсамж – хөвхөлзөх гэж болох уу? “хөвхөлзөх” гэсэн үйлийг хэн, юу гүйцэтгэх боломжтойг анхаарах хэрэгтэй. Толь бичигт: хөвхөлзөх – 1. хөвхгөр юмны хөвхөс хөвхөс хөдлөх, бамбалзах, намалзах, хотолзох; 2. Хөвсөргөн зан байдал гаргах гэж тайлбарлажээ. Ийнхүү үгийн утга, утгын холбоог сайтар анхаараарай.</p>
<p>Олон хүнээр хүрээлүүлсэн хүн бүр сайн сайхан байдаггүй юм. Яг л навчсаар хүрээлүүлсэн мод шиг.</p>	<p>Найз нөхөд олонтой хүний тухай бичихдээ хавар цагт навчилж буй модтой зүйрлэх нь оновчтой юу?</p>

гэх мэтчилэн дүрслэн бичих гэж байгаа юм, үзэгдэл тэдгээрийн хоорондын холбоо хамаарлыг маш сайн тунгаан бодох нь чухал шүү!

- ✓ Бичсэнээ солилцож унших
- ✓ Зөв бичих дүрмийн ба найруулгын алдаагаа хянаж, дүрслэлээ сайжруулах

ё. Таалагдсан зургаа сонгон тайлбар бичээрэй. Бичихдээ дүрслэл ашиглаж, мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлээрэй.

Төрийн соёрхолт, ардын зураач Д.Амгалан “Мөрөөдөл”



В.Ундраа “Азжаргалтай гэрбүл”

Г.Одон “Ажлын дараа”



Нутгийн аялгууны үгийг таних, найруулгын үүргийн тодорхойлох

1. Нутгийн аялгууны үгийг ялган танья.


- а. Хүснэгт дэх мэдээллийг уншаад, “хэл - нутгийн аялгуу” гэсэн ойлголтуудын ялгаатай талыг тодруулж ярилцаарай.

Хэл	Нутгийн аялгуу
<ul style="list-style-type: none">• Тухайн улс үндэстний харилцааны гол хэрэглүүр.• Аман ба бичгийн хэлбэртэй.• Хэл зүйн нарийн дүрэм тогтолцоотой.• Албан харилцааг зохицуулах гол суурь болдог.• Нутгийн аялгууны үг хэллэгээр үгийн сан нь баяждаг.	<ul style="list-style-type: none">• Тодорхой газар оронд оршин буй хэсэг бүлэг хүн харилцана.• Аман хэлбэр зонхилно.• Тухайн хэлнийхээ дүрэм журам, зүй тогтолд захирагдана. Тусгайлан боловсруулсан дүрэмгүй.• Албан харилцаанд хэрэглэхгүй.• Утга зохиолын хэлийг баяжуулах чухал хэрэглүүр.

- б. Хэл ба аялгууны ижил тал нь юу байж болохыг гаргаж ярилцана уу.



- в. Хэл ба аялгууны харьцааг аль хэсэгт оновчтой дүрсэлсэн бэ? Зөв гэж үзсэнээ баримтаар батлаарай.



- г. Эрдэмтэн зохиолч Б.Ринчений “Монгол хэл” шүлэгт:

....Чихинү чимэг болсон аялгуу сайхан монгол хэл

Чин зоригт өвгөд дээдсийн минь өв их эрдэнэ

Сонсох бүр яруу баялгийг гайхан биширч

Сод их билигт түмэн юүгээн бишрэн магтму, би...


гэж өгүүлсний учрыг ярилцаарай.

- д. Дараах жишээнүүд аль нутгийн аялгуу байж болох вэ? Таамаглан ярилцана уу.
1. - Би тэдэнхүр ёвсув. Чи эдэнхүр ёв. Хаана үүдэнд харһий.
 2. - Дуула дуулаһаар сэсэн болохо, дуһа дуһаһаар далай болохо
 3. - Чингэвэл нэлээд удаан суух юм байна. Чөлөө жаваараан манай гэрт тойрохоор очоорой. Манай гэр сургуулийн хүрээний 5-р асарт 42 тоотод байна.
 4. Дуслыг хураавал далай.
Дуулсныг хураавал эрдэм
 5. Би түүгээр явъя.
Чи үүгээр яв.
Билүүгийн голд уулзъя

Орчин цагийн монгол хэл олон нутгийн аялгуутай. Монголчуудын нийтийн хэлэнд хэрэглэгдэхгүй ч тухайн нутгийн аялгуунд буюу нэг хэсэг нутаг орны хүмүүсийн ярианд хэрэглэгдэг үгс бий. Нутгийн аялгууны үг нь:

- Утга зохиолын хэлэнд цөөн байдаг,
- Зарим нэг үгийн бичлэг адилхан ч утгын ялгаатай,
- Дуудлагын хувьд тус тусын нутгийн аялгууны өвөрмөц шинжийг хадгалсан,
- Хэлцэд түгээмэл тохиолддог,
- Монгол хэлний олон нутгийн аялгуу эх хэлний яруу тансаг, үнэт эрдэнэс болсон үг, хэлцээр баялаг байдаг зэрэг онцлогтой.

Монгол хэлний нутгийн аялгууг ерөнхийд нь дараах байдлаар ангилан үзнэ.



2. Нутгийн аялгууны үгийг хэрэглэе.

- а. Харилцан ярианы асуултыг ямар аялгуугаар буулгасан байна вэ? Халх аялгуугаар хариулаарай. Даалгавруудыг гүйцэтгэхдээ хавсралтад байгаа “Нутгийн аялгууны үгийн тайлбар”-ыг ашиглаарай.

1. - Танаа алдар кэн гэдэг вэ?
- Хамаа ямар сургууль дүүргэж вэ та?
- Та альк нутгаан тохонтаа күмэн билээт?
- Настанлаа күүндэдэвтэ?
- Ойрд тангачид күрлээв гэж санатн юн гэж мөндөлхүв та?
- Бичхан көвүүн мөөжин бөөжин гэгээд хүрээд иркүлэ яганайт?
- Өөдөө суутан! гэхлээ ягаж суунайт?

2. - Танай алдар хэн бэ?
- Ямар хургуули дүүргээ хэм та?
- Түрэнэн тоонтотнай хаанаб?
- Наһатан зонтоёо хөөрөлдэжэ байдаг гүта?
- Буриад зон соо ошог гэлээт Юн гэжэ амаршалхабта?
- Бишыхан хүбүүн бэлтэгэшэжэ харан харан байг гэлэй. Яахаб та?
- Дээшээ һуугты гэхэдэнь хайшан гэхэб та?

б. Өвөр монгол аялгуугаар буулгасан харилцан ярианы асуултад өөрсдийн мэддэг аялгуугаар хариулж бичээрэй.

- Та хэжээ ирсэн бэ?
- Бид төгссөнөөс аваад уулжаадуй нэг хоёр жил боллоо. Энэ хооронд таны байдал жүгээр үү?
- Та энд юунд ирсэн бэ?
- Юу сурахаар ирээ вэ?
- Та энд хэдүй удаан суух вэ?
- Та ямар ном жээлэх вэ?
- Та хэжээгээс эхэлж англи хэл үжсэн бэ?
- Өө тийм үү? англи хэл сурахад хүчиртэй юү?
- Би англи хэл үжье гэж бодлоо. Яаж үжвэл болно доо?
- Сондгой гараг бүхэлд бүр энд ирж англи хэл хэлчэж байвал болно уу?

в. Нэр үгсийг сайтар нягтлаад, ерөнхий нэрийг нь монгол бичгээр бичээрэй.

А.	Б.	В.	Г.	Д.
харт	бүдэрхий	туух	аман хүзүү	шилбэ
атгаал	толь	зоо	хаган хүзүү	таахай
дал	хуруу	харгам	тоором	тагалцаг
хавирга	халбага	зовлонт	шил	голх, туур
	цорой	харцага		шивнүүр

г. Угсаатан тус бүрийн өмсдөг хувцасны нэрийг зөв сонгоно уу.

Буриад	Өөлд	Ордос	Урианхай	Торгууд
тоорцог	ууж	хантааз	шалбуур	готовл
тооровч	цэгдэг		шаавар	госн
товь	цээдэг		годосо	
жатар	бэрз	ханжаар	маяг	гутал
мандаа	бишмэд			тоокуу
овоодой		уужмаг	дамбаала	маага
маахууз				сөөхий

д. Асуултын дагуу ярилцаарай.

- Харилцан ярианы асуултуудад хариулахад ямар онцлогтой байна вэ?
- Яриа тус бүрд халх аялгуунаас ялгаатай авианы ямар өөрчлөлт байна вэ?
- Утга нь ойлгогдож байсан уу?
- Нутгийн аялгууны үг хэллэгээр тухайн суурь (халх аялгуу) утга зохиолын хэлний үгийн сан баяжиж байдаг гэдгийг юу гэж ойлгосон бэ? Жишээ авч тайлбарлаж ярилцана уу.

Өөрийгөө сорьё.

Эхийг уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

...Дунгуй гэж юу гэсэн утгатай, юуг заан нэрлэсэн үг бол? гээд л зарим оюутан, магистрант нараас тандаж асуухлаар “нэг л дугуйрсан юмыг хэлээд байх шиг” гээд, таанан дунгуй буюу дундгуйгаас цааш хэтэрч, тайлбар хэлж чаддаггүй нь хачин санагддаг сан. Зарим толь бичиг сөхөж үзэхэд “дунгуй”, “бухын дунгуй аргал” гэх мэт үг, тайлбар байхгүй юм. Тэгэхлээр бидний сонирхоод байгаа “дошсон сарлагийн бухын дунгуй” бол сарлагтай газрын үг, хангайнхны үг, ер нь нутгийн аялгууны үг бололтой. Говийнхон энэ үгийг бүр ч мэдэхгүй байх гэж бодогдов. Гэхдээ нутгийн аялгууны үгээр утга зохиолын хэлний үгийн сангийн үүсвэр бүрэлдэхүүн ба найруулбар бүрэлдэхүүн байнга баяжиж байдаг гэдгийг хэлэх нь л бидний энэ таталбарын нэг зорилго юм л даа.


Аргал ер нь олон янз. Олдоц тархац, хэлбэр галбир, цаг цагийн өнгө зүс, хэмжээ дамжаа, эрчим чадал, галын бурхан - гэрийн эзэгтэй нараас авах үнэлэмж нь хүртэл өөр өөр. Хаврын халтар хомоол, олон жилийн өнжмөл төмөр хөх хомоол, монгол үхрийн сармай цагаан, сарлаг үхрийн сайхан халтар аргал, угалзан хээтэй хөх аргал, өмхий пэндий, хөвсгөр үнгүүш, дошсон сарлагийн бухын хөх дунгуй гээд л янз янзын нэртэй, өөр өөрийн үг хэллэгтэй. Бухын дунгуй бол аль ч талаараа хангай газрын аргалын “хаан” буюу дээд нь юм л даа...

(Б.Пүрэв-Очир “Дошсон сарлагийн бухын дунгуй”-аас)

- а. Эхийн хэсэгт тайлбарласан зүйлүүд ямар дараалалтай байна вэ? Загвараас тохирохыг олоорой.



- б. “Таанан дунгуй буюу дундгуй” гэсэн үгийн утгыг тайлбар толь бичиг ашиглан ярилцаарай.
- в. Тайлбарлахдаа дүрслэл ашигласан хэсгийг бүдүүвчийн дагуу ялган тэмдэглээрэй. Үлгэрлэвэл:




- г. Зургийг тайлбарлахдаа ямар уран дүрслэл ашигласныг ярилцаарай. Өгүүлэгчийн мэдрэмж, сэтгэгдэл туссан хэсэг байна уу?



Энэ дунгуй бол нэг талаас, байгалийн бүтээгдэхүүн “монгол үхрийн баас”... л юм. Ёстой л нэг дээд хөх тэнгэрийн нар, сар, хураар тэжээлгэж, доод бор дэлхийн эрчим дулааныг авч, талын хөх салхиар алгадуулан алгадуулсаар мөлийсөн, элдүүр нь ханасан хөх аргал болой. Нөгөө талаас, цаасан дээрх зургийг нүүдэлчдийн соёл, сэтгэлгээ, гоо сайхны таашаалыг хослуулан байж хийсвэрлэн бодвоос, нэг сайхан зүмбэрлэсэн хээ хуар ч юм шиг, монгол эмээлийн баавар даруулга ч юм шиг, бас нэг сайхан суран хазаарын мөнгөн товруу ч юм шиг, нэг их сайхан мөнгөн ембүү ч гэмээр, аль эсвэл их уриа дуудлагын цагаан лавай ч гэмээр...

- д. Аргалыг эхэд дурдсанаас өөрөөр юу гэж нэрлэн хэлэлцдэг вэ? Өөрсдийн мэддэг үгсийг бүртгэн ярилцаарай.
- е. Дараах бичвэрийг уншаад, хамгийн анх унисан номоос төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ 5-6 өгүүлбэрт багтаан бичээрэй. Бичихдээ өмнө үзсэн алхам дараалал, санамжийг ашиглаарай.



...Анх 3-р ангид байхдаа “Монголын нууц товчоо” номыг уншиж байсан. Тухайн үед Чингис хааны тухай ил ярьдаггүй байлаа. Хүүхдүүд “Чингис хаан”-ы зураг гээд олон дахин татаж угаасаар байгаад дүрс нь мэдэгдэхгүй сүүдэр шиг болчихсон зургийг нууцаар дамжуулж үздэг байсан юм даг.

“Нууц товчоо”-г уншаад, төрсөн сэтгэгдэл үнэхээр гайхамшигтай. Өнөөдрийн анх уншиж байгаа хүүхдүүд ч мөн адил тийм гайхамшигтай ертөнцөд

нэвтрэн ордог байх гэж найддаг. Анхны сэтгэгдлээрээ Бөрт чоно, Хоо маралыг зурсан маань одоо надад байна. Тэр зураг дээр дүрсэлсэн цацарч байгаа гэрэл “Нууц товчоо” хэмээх бүтээл надад хэрхэн нөлөөлж, ямар их догдлуулж байсныг сануулдаг юм...”

(Зураач Р.Батцэнгэл)

**Эзэмших мэдлэг, чадвар**

Эхэд зохиогчийн ашигласан баримт, мэдээллийг ялгаж дүгнэлт гаргах

Тоочин тайлбарласан эхийг дэлгэрүүлж бичих

Угсарсан нийлмэл угийг таньж, найруулгын үүргийг тодорхойлох

Балархай эгшгийн дүрмийг давтах

1. Тоочин тайлбарласан эхийн сэдэв, утга санааг ойлгоё.

- Амьдарч буй нутагт тань түүхэн дурсгалт, өвөрмөц тогтоц бүхий байгалийн үзэсгэлэнт ямар газар байдаг вэ? Бусдадаа танилцуулаарай.
- Дараах эхийг уншихдаа утгыг нь сайн мэдэхгүй үгийн доогуур зураарай.



Гурван Цэнхэрийн агуйн зураг

I. Ховд аймгийн Манхан сумаас 30 орчим километрийн зайд орших Хойд Цэнхэрийн агуйд 40,000 жилийн тэртээх хадны сүг зургийн түүхэн дурсгал бий. Уг агуй нь шохой чулуун тогтоцтой, дотроо бөмбөгөрдүү оройтой, шалнаас адар хүртэл 20 орчим метр өндөр.

II. Тус агуйд янз бүрийн амьтдын зургийг улаан зосоор зурсан хунх дөрөв бий.

1-р хунх. Уг хунхад 20 гаруй жадан эвэрт оронго гөрөөс (каниба), могой тэргүүтнийг

зурж үлдээжээ. Энд гөрөөсийг өргөн сүүлтэй, соотон чихтэйгээр маш чадварлаг зуржээ.

2-р хунх. Энэ хунхад арслан заан, аргаль, тэмээн хяруул, цацагт хяруул, цэн тогоруу зэрэг амьтдыг дээр дээрээс нь давхарлан гоёмсог зуржээ. Эл хунх хамгийн том нь бөгөөд тус агуйн хамгийн ур хийц сайтай, гоёмсог зургуудыг агуулдаг.

3-р хунх. Энд зэрлэг тэмээг нэлээд том хэмжээгээр, чөлөөтэй дүрсэлсэн байхаас гадна янгир, нисэж яваа шувууг дүрсэлсэн байна.

4-р хунх. Энэ хунхад шувуу, гацуур мод, харайж буй гөрөөс зэргийг зуржээ.

III. Эдгээр зосон зургийн дүрслэл нь палеолитын үеийн онцлогийг харуулжээ. Зосон зурагт жадан эвэрт оронго гөрөөс, тэмээн хяруул, цацагт хяруул, арслан заан зэрэг амьтад байдаг нь монгол нутагт эрт цагт эдгээр амьтад амьдарч байсан, тэр цагт манай нутаг эдгээр амьтдын амьдрах орчин бүрдсэн, одоогийн Африк тив шиг чийглэг, халуун уур амьсгалтай байсан гэдгийг харуулж байна. Амьтдын гадаад төрхийг гаргахад анхаарч, зарим амьтдын дүрслэлийг тааруулан, жижиг жижиг олон толбо хийж, давтмалыг илэрхийлжээ.


IV. Эл зургуудыг олон эрдэмтэн судалж, үнэлэлт дүгнэлт өгсөн байна. 1951 онд газар зүйч, судлаач О.Намнандорж Хойд Цэнхэрийн агуйн хадны зураг дүрслэлийг судлах оролдлого хийжээ. Чехийн монголч эрдэмтэн П.Поух "Монгол орноор гучин мянган бээр аялсан нь" номдоо энэ агуйн зургийн талаар бичжээ. Мөн Зөвлөлтийн нэрт монголч эрдэмтэн, академич

А.П.Окладников “Гурван Цэнхэрт хүн төрөлхтний эртний урлагийн бие даасан хүчирхэг голомт байсан бөгөөд асар өндөр хөгжилтэй, уран сайхны их авьяастай зураачид амьдарч байсны гэрч юм” гэж үзжээ.

V. Зургууд нь дүрслэлийн агуулга, зохиомж, арга зэргээрээ дэлхийн палеолитын үеийн түүх соёлын судлалд чухал байр суурь эзэлдэг. 1996 онд ЮНЕСКО-оос Хойд Цэнхэрийн агуйг “Дэлхийн гайхамшигт үнэт зүйл болох нь” зэрэглэлээр дэлхийн соёлын эртний чулуун зэвсгийн өвд бүртгэжээ.

(“Монголын үндэсний нэвтэрхий толь”-оос)

а. Дараах үгсийн утгыг хам сэдвийн хүрээнд таамаглаж, зөв холбоорой.



б. Эхээс түлхүүр үгсийг түүж бичээд, эхийн агуулгыг бүдүүвчээр харуулаарай.

в. Дараах асуултад хариулж, даалгаврыг гүйцэтгээрэй.

- Эхэд юуны тухай өгүүлсэн байна вэ? Ярилцаарай.
- Гурван Цэнхэрийн агуй нь хэмжээгээр хэр том санагдав? Ямар нэг зүйлтэй жишиж тайлбарлаарай.
- А.П.Окладниковын “Гурван Цэнхэрт хүн төрөлхтний эртний урлагийн бие даасан хүчирхэг голомт байсан бөгөөд асар өндөр хөгжилтэй, уран сайхны их авьяастай зураачид амьдарч байсны гэрч юм.” гэсэн дүгнэлтээс ямар сэтгэгдэл төрөв? Эхээс эш татан тайлбарлаарай.
- ЮНЕСКО-ийн соёлын өвд ямар зүйлийг бүртгэж авдаг юм бол? Энэ агуйг соёлын өвд бүртгэсний учрыг ярилцаж, ямар үнэт дурсгал болох талаар дүгнээрэй.
- “...Монгол нутагт эрт цагт эдгээр амьтад амьдарч байсан, тэр цагт манай нутаг эдгээр амьтдын амьдрах орчин бүрдсэн, одоогийн Африк тив шиг чийглэг, халуун уур амьсгалтай байсан.” гэдэгтэй санал нийлж байна уу? Үзэл бодлоо илэрхийлээрэй.

2. Эхийн утга, бүтцийн холбоо хамаарал, дарааллыг тодорхойлъё.

а. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг өөр өнгөөр ялган тэмдэглээрэй.

б. Эхийн бүтцийг шинжлэхдээ дараах хүснэгтийн дагуу ажиллаарай.

Бүтцийн хэсэг	Цогцолбор	Цогцолбор тус бүрд юуны тухай (сэдэв) өгүүлсэн байна?
Эхлэл		
Гол хэсэг		
Төгсгөл хэсэг		

в. Дараах асуултын дагуу ярилцаад, эхийн бүтцийн хэсэг ба утгын холбоо хамаарлыг бүдүүвчээр харуулаарай.

- Аль нь хамгийн ерөнхий сэдэв бэ? Эхийн аль хэсэгт байна вэ?
- Ерөнхий сэдвийг дэмжсэн сэдвүүд аль хэсэгт байна вэ?
- Төгсгөл хэсэг байна уу? Түүнийг юугаар баглах вэ?

г. Цогцолборуудын дарааллыг тодорхойлоорой.

- Өгүүлбэр, цогцолборуудыг юугаар холбосон байна вэ? Түүж бичээд, утгыг тайлбарлаарай.
- Холбох хэрэглүүрийг бүлэглээд, дүгнэлт бичээрэй. Дараах хүснэгтийн дагуу ажиллана уу. Жишээ нь:

Цогцолборын дугаар	Өгүүлбэрийг юугаар холбосон байна вэ? Энэ нь ямар утгыг илэрхийлж байна вэ?	Цогцолборуудыг юугаар холбосон байна вэ? Энэ нь ямар утгыг илэрхийлж байна вэ?
2	уг - гэсэн үгээр холбосон ба энэ нь юмыг зааж, төлөөлсөн утгатай байна.	тус - гэсэн үгээр холбосон. Энэ нь юмыг заан төлөөлсөн утгатай. нэгдүгээр, хоёрдугаар - тооны нэрээр холбосон. Энэ нь дэс дараа заасан утгатай.


Дүгнэлт:

Өгүүлбэрүүдийг ихэвчлэн тодотгон холбох нөхцөл болон зэрэгцүүлэн холбох үг, төлөөлөх үгээр холбосон нь эхийн найруулга, мэдээлэн тайлбарлаж бичих аргатай холбоотой.

Дүгнэлт:


.....

- Бичигч дараах байдлаар цогцолборуудаа дараалуулжээ. Цогцолборуудын байрыг хооронд нь сольж болох уу? Учрыг жишээгээр батлан тайлбарлаарай.



д. Мэдээлэн тайлбарласан эхийн бүтэц, дарааллын талаарх ойлголтоо нэгтгээрэй.

- Мэдээлэн тайлбарласан эх нь заавал эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй байх ёстой юу? Ярилцаарай.
- Цогцолборуудыг яаж дараалуулах вэ? Дараах аргаар мэдээлэн тайлбарласан эхийн цогцолборуудыг дараалуулж болох уу? Жишээгээр батлан тайлбарлаарай.



3. Эхээс чухал хэсгийг ялган, мэдээллийг хурааж бичье.

а. Дараах алхмын дагуу ажиллаарай.

Эхлэл хэсгээс олох	<ul style="list-style-type: none"> • Эхийн сэдэв (юуны тухай өгүүлсэн)-ийг санаарай. • Сэдвийн тухай ерөнхийд нь мэдээлсэн өгүүлбэрийн доогуур зурж тэмдэглээрэй.
Гол хэсгээс олох	<ul style="list-style-type: none"> • Цогцолбор тус бүрд юуны тухай өгүүлснийг тодорхойлоорой. • Цогцолбор тус бүрээс эхийн сэдвийг дэмжиж, тухайн цогцолборын утга санааг ерөнхийд нь мэдээлсэн өгүүлбэрийн доогуур зураарай.
Төгсгөл хэсгээс олох	<ul style="list-style-type: none"> • Мэдээллийг дүгнэсэн өгүүлбэрийг олж тэмдэглээрэй.
Унших	<ul style="list-style-type: none"> • Зурж тэмдэглэсэн өгүүлбэрүүдийг дарааллаар нь холбон уншаарай. • Ийнхүү холбон уншихад найруулгын болон учир зүйн хувьд чөлөөтэй сайн холбогдож байна уу? Төдийлөн сайн холбогдохгүй бол дахин хийж үзээрэй. • Мэдээллийн гол утга санаа ойлгогдож байна уу?

Үлгэрлэвэл:

Гурван Цэнхэрийн агуйн зураг

Цогцолбор 1: Ховд аймгийн Манхан сумаас 30 орчим километрийн зайд орших Хойд Цэнхэрийн агуйд 40,000 жилийн тэртээх хадны сүг зургийн түүхэн дурсгал бий.

Цогцолбор 2: Тус агуйд янз бүрийн амьтдын зургийг улаан зосоор зурсан хунх дөрөв бий.

Цогцолбор 3:

Цогцолбор 4:

Цогцолбор 5:

б. Холбон бичсэн эхээ анхны эхтэйгээ харьцуулаарай. Дараах загварын дагуу ажиллана уу.

	Дэлгэрэнгүй эх	Ижил тал	Товчилсон эх
	Ялгаатай тал		Ялгаатай тал
Зорилго			
Утга санаа			
Бүтэц, дараалал			
Эхийн агуулгыг бүрдүүлэгч хэсэг			
Хэмжээ			

в. Дараах асуултад хариулж, ярилцаарай.


- Цогцолбор тус бүрийн утга санааг илэрхийлж, ерөнхийд нь мэдээлсэн өгүүлбэр хаана байрлаж байна вэ?
- Тэдгээр өгүүлбэрийг эхээс хасаж уншвал эхийн утгад өөрчлөлт гарах уу?
- Эдгээр өгүүлбэр эхэд ямар үүрэгтэй байна вэ?

Цогцолбор тус бүрийн утга санааг илэрхийлж, ерөнхий мэдээллийг агуулсан өгүүлбэрийг ялгах аргаар мэдээлэн тайлбарласан эхийг хурааж (товчилж) болно. Монгол хэлэнд ийм өгүүлбэр нь цогцолборын хаана ч орж болдгийг анхаарч, зөв ялган таньж сураарай.

Бие даах ажил. Хүүхэд бүр Монгол орныхоо түүхэн дурсгалт, үзэсгэлэнт, өвөрмөц тогтоцтой ямар нэг газрын тухай мэдээлэл олоорой. Олсон мэдээллээ марафон уншлагын аргаар дамжуулан уншаарай. Уншсаныхаа дараа хүүхэд бүр таалагдсан 3-5 эхийг сонгоод, чухал хэсгийг ялгах аргаар мэдээллийг хураан бичээрэй.

4. Эхэд шинжилгээ хийж, чухал баримтыг ялгая.

а. Эхээс ерөнхий мэдээлэл ба баримтуудыг ялгаад, ямар холбоо хамааралтай байгааг ярилцаарай. Жишээ нь:



б. Баримтуудыг дараах хэлбэрээр ангилж, яагаад ингэж ялгаснаа тайлбарлаарай.


Баримтын хэлбэр	Баримтын дугаар	Шалтгааныг тайлбарлах
Бодит байдал		
Таамаглал		
Үнэлэлт дүгнэлт		
Судалгаа		
Тоон үзүүлэлт		
Тодорхойлолт		
Эшлэл		

Бодит амьдралд туршлагаар батлагдсан бүхэн баримт болно. Баримт заавал үнэн байх ёстой. Болсон үйл явдал, үзэгдэл, юмс, тоон үзүүлэлт, тодорхойлолт, эшлэл, жишээ зэргийг баримт гэж үзэж болно.

в. Цогцолбор тус бүрд байгаа баримтыг чухал, чухал бусаар ялгаарай. Дараах хүснэгтийн дагуу ажиллана уу. Жишээ нь:

Ерөнхий мэдээлэл бүхий өгүүлбэр	Баримт	Чухал (+) Чухал бус (-)	Шалтгаан
Тус агуйд янз бүрийн амьтдын зургийг улаан зосоор зурсан хунх дөрөв бий.	1-р хунх Уг хунхад 20 гаруй жадан эвэрт оронго гөрөөс, могой тэргүүтнийг зуржээ.	+	<ul style="list-style-type: none"> Янз бүрийн амьтны зургийг зурсан тухай ерөнхийд нь мэдээлсэн ба тэр санааг тодорхой болгож байгаа учир чухал. Уг амьтдын зурагт тулгуурлан эрт цагт монгол нутаг чийглэг, дулаан уур амьсгалтай байсан гэж батлахад хүргэсэн учир чухал.
	Энд гөрөөсийг өргөн сүүлтэй, соотон чихтэйгээр маш чадварлаг зурсан байна.	+	<ul style="list-style-type: none"> Янз бүрийн амьтны зургийг зосоор зурсан тухай ерөнхий мэдээлснийг тодорхой болгож байгаа учир чухал. Зургийг яаж зурсан нь бас чухал. Яагаад гэвэл “Гурван цэнхэрт асар өндөр хөгжилтэй уран сайхны их авьяастай зураачид амьдарч байжээ” гэх дүгнэлтэд хүргэсэн.


г. Дараах асуултад хариулж, баримтын талаарх ойлголтоо нэгтгээрэй.




5. Эхийн онцлогийг нэгтгэн дүгнэе.

а. Дараах асуултын дагуу ярилцаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

- Бичигч “Гурван Цэнхэрийн агуйн зураг” эхийг ямар зорилгоор бичсэн юм бол? Ярилцаарай.
- Эхэд юуг тоочин тайлбарласан байна вэ? Дараах загварын дагуу ажиллаарай. Үлгэрлэвэл:



б. “Гурван Цэнхэрийн агуйн зураг” эхэд дараах ойлголтууд байгаа эсэхийг шинжлээрэй. Байгаа бол (+), байхгүй бол (-) тэмдгийг өмнөх дугуйд тавиарай. Байгаа, байхгүйн учрыг бичигчийн зорилготой холбон тайлбарлаарай.



в. Дээрх эхийн үгийн утга болон үгийн сангийн бүрэлдэхүүнийг судлаарай.

Үг хэллэг	Байна (+) Байхгүй (-)	Жишээ	Шалтгаан
Далд утгатай үг хэллэг			
Шууд утгатай үг хэллэг			
Мэргэжлийн болон нэр томъёоны үг			
Уран дүрслэл			

г. Өгүүлбэрт шинжилгээ хийгээрэй. Эхлээд өгүүлбэрүүдээ дугаарлан, дараа нь хүснэгтийн дагуу ажиллаарай.


Утга	Өгүүлбэрийн дугаар	Өгүүлбэрийн төгсгөл
Баталж нотолсон утгатай өгүүлбэр		
Дам эх сурвалжаас авсан өгүүлбэр		

- Мэдээлэн тайлбарлаж байгаа тохиолдолд уг юм, үзэгдэл, үйл явцын талаар бичигч өөрөө мэдэж байгаагаа баттай ноттой харуулж байгааг, эсвэл дам эх сурвалжаас авсныг өөр ямар ямар үг, нөхцөлөөр илэрхийлдгийг ойлгон, өгүүлбэр зохиогоорой.

Баталж нотолсон өгүүлбэр: -в, -лаа⁴, -на⁴, -даг⁴, шүү, за, юм, үнэхээр, үнэндээ, мэдээж хэрэг, гарцаагүй, зайлшгүй, яриангүй, чухам, ёстой...

Дам эх сурвалжаас авсан өгүүлбэр: -даг ажээ, -жээ, -чээ, гэнэ, олны амаар бол,-ний хэлснээр бол, түүний жишээлснээр, дам сонсвол, энэ номд дурдсанаар бол, чиний хэлдгээр, -сан юм гэдэг...

д. Дараах бүдүүвч дэх ойлголтуудыг дэлгэрүүлэн ярилцаарай.



е. Ойлголтоо бататган, дараах тайлбарыг гүйцээж бичээрэй.

..... эх гэдэг нь хүн, юм, үзэгдлийн гол гол шинжийг тодорхой (орны, цагийн, учир зүйн), (эхлэл, гол, төгсгөл) -ийн дагуу янз бүрийн баримтаар баяжуулан, бичигчийн хувийн үнэлэлт дүгнэлтгүй бичихийг хэлнэ. Жишээ нь: “Турван Цэнхэрийн агуйн зураг” эхэд агуй, түүний хананд байдаг сүг зураг, тэдгээрийн дүрслэл, судалгаа, ач холбогдол, үнэ цэнийг ямар ч уран дүрслэлгүй, өнгө аясаар бодит байдлыг шууд тодорхойлж, сэтгэл хөдлөл, уянгын халилгүй бичсэн байна.

Мэдээлэн тайлбарласан эхийн агуулгыг бүрдүүлэгч чухал зүйл бол ерөнхий мэдээлэл юм. Уг мэдээлэл нь цогцолбор тус бүрийн гол агуулна. Үлгэрлэвэл: Бичигч агуй, сүг зураг, зургийн дүрслэл, ач холбогдол, үнэ цэнийн талаар цогцолбор бүрийн эхэнд ерөнхий мэдээлэл өгөөд, түүнийгээ бодит амьдралын баримт болон судалгаагаар баталж нотолсон байна.

Эхийн агуулгыг бүрдүүлэгч нөгөө нэг чухал зүйл бол юм. Бодит амьдралд туршлагаар батлагдсан бүхэн болно. Дээрх эхэд,, зэрэг баримтыг ашиглан, уншигчдад эл агуйн талаар уншигчдад зорьжээ.

Мэдээлэн тайлбарласан эхэд үгийг утгаар хэрэглэхээс гадна, зэргийг ашигладаг. Жишээ нь: Энэ эхэд гэх мэт түүх, археологийн ашиглажээ.

Мөн өгүүлбэр болон цогцолборуудыг төрөл бүрийн үгээр холбон найруулна. Энэ нь санааг давтан нуршихаас зайлсхийх арга болно. Жишээ нь: Дээрх эхэд тус, уг, энд, эдгээр, эл, мөн гэх мэт заан төлөөлөх үг болон зэрэгцүүлэн холбох үгийг олон хэрэглэжээ.

Тоочин тайлбарласан эхийг дэлгэрүүлж бичих

- “Гурван Цэнхэрийн агуй”-н тухай бичлэгийг аялал, жуулчлалын Mongoliaexpeditions.blogspot.com/2010/10/blog_post.html/ цахим хуудаснаас үзэж, ямар сэтгэгдэл, мэдрэмж төрж буйгаа тэмдэглээрэй.

1. Эхэд үзэл бодол, мэдрэмж, сэтгэгдэл, сэтгэл хөдлөлөө оруулж бичье.

а. Дараах онолын тайлбар ба жишээг анхааралтай уншаарай.

Зарим нэг дүрсэлсэн үг хэллэгийг аливаа тайлбарт хэрэглэх нь өгүүлэгчийн сэтгэл хөдлөлийг илэрхийлэх, уншигчдад нөлөөлөх, гэдэнд хүчтэй сэтгэгдэл төрүүлэх, уншигчийн сонирхлыг татах, мэдээллийг ой тойнд нь хүртэл дамжуулах зорилготой байдаг. Жишээ нь: ...Цаст цагаан уул нь хадган цэнхэр Алтайн зүрхэнд оршино. Тиймээс Жамьянгарав оргил нь зүрхэн галбиртай бөгөөд “Мөгөөрс нимгэн хоолойтны дуу нь ч хүрээгүй” газар. Нээрээ, энэ оргилд цас тогтдоггүй шовх юм чинь хүн яаж ч тогтох юм билээ. Хэрвээ цас тогтлоо л бол энд цас зуд болдог, эмгэг өвчин дэлгэрдэг гэнэ. Урианхай түмнээ гай барцадтай учруулахгүй гэхдээ Цаст хайрхан оройнхоо цасыг дандаа шилгээчихдэг юм байна...

...Цаст цагаан уулын савдаг нь алтан шарга морьтой, арван найман настай алиа хонгор бүсгүй. Ийм учир бүсгүй хүнд ээлтэй гэнэ. Нутгийн эмэгтэйчүүд “Цаст цагаан уул минь” гэж урин дуудаж, цайныхаа дээжийг өргөнө. Уулын савдаг сайхан дээл өмсөж гоёсон хүүхнүүдийг харахлаараа баясдаг тул бүсгүйчүүл уул руугаа өгсөж нүүхдээ ч, уруудаж буухдаа ч “цайныхаа” дээлийг өмсдөг заншилтай...

Цаст цагаан уул эргэн тойрондоо зуун найман нууртай. Зуун найман нуурыг нь Цаст уулын таван оргил, мөнх тэнгэрийн хөвөн үүл хоёр хээлдэг юм билээ. Орой нь далайн түвшнээс дээш 4362 метр өндөр. Цас нь 160-170 метр зузаан гэнэ.

Монгол, Солонгос, Япон, Хятадын эрдэм шинжилгээний хамтарсан ангийнхан оргилын цасыг өрөмдөөд, “Барилгачин” гэсэн орчин үеийн “онцгүй” нэрийг өгсөн юм байна. Бид уулсынхаа эртний сайхан нэрийг нь огоороод, элдэв янзын нэр шинээр өгөөд, мундрыг нь хутгаад хаячих юм даа. Ухаан нь, Хималайд авирч, Жомолунгма оргилд нь гарсан хүн бүр өөр өөрийн нэрийг өгөөд байх юм бол хачин юм болно биз дээ...

(Го. Аким)

- б. Эхээс өгүүлэгчийн үзэл бодол, мэдрэмж, сэтгэгдэл, сэтгэл хөдлөл илэрсэн хэсгийг ялгаарай. Эдгээр нь эхэд ямар үүрэгтэй байгааг тодорхойлоорой.
- в. Дээрх эхээс санаа авч, “Гурван Цэнхэрийн агуйн зураг”-ийг дэлгэрүүлээрэй.
- “Гурван Цэнхэрийн агуй”-н тухай бичлэгийг үзээд ямар сэтгэгдэл төрсөн бэ? Ярилцаарай.
 - “Гурван Цэнхэрийн агуйн зураг” эхийг дахин уншаарай. Төрсөн сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодол, сэтгэл хөдлөлөө тэмдэглээрэй.

- Тэдгээрийг оруулж, найруулан бичээрэй.
- г. Дараах шалгуурын дагуу өөрийгөө үнэлээрэй.

Шалгуур	Үнэлгээ (☺ ☹ ☹)
Сэтгэгдэл мэдрэмжээ тусгасан эсэх	
Үзэл бодлоо бичсэн эсэх	
Сэтгэл хөдлөлөө оруулсан эсэх	
Анхны эхтэйгээ харьцуулахад илүү сонирхолтой болж чадсан эсэх	

2. Эхэд шинэ баримт мэдээлэл, тайлбар оруулан бичье.

- а. Дараах зургийг ажиглаж, тайлбарыг анхааралтай уншаарай.

Хойд Цэнхэрийн агуй нь хоёр салаа бөгөөд нэг нь 130 метр, нөгөө нь 90 метр урт. Өргөн болон өндөр нь харилцан адилгүй бөгөөд дунджаар өргөн нь 3-4 метр, өндөр нь 3 метр орчим байдаг. Зарим газраа намхан тул хүн мөлхөж ороод цааш явахад зай нь уужуурч, босоо явах боломжтой болдог юм.

(Э. Авирмэд “Монгол орны агуй” номоос)



Гурван Цэнхэрийн домог

Эрт цагт холбоо гурван нуур байсан ажээ. Холын газраас цэнхэрлэн харагдах ах дүү гурван нуурыг хүйн холбоотой гэх. Өвөлдөө хөлдөхгүй, хургүй зун ч ширгэх гэж айлгадаггүй байжээ.

Нуурын ёроолд алт эрдэнэс байдаг тухай нутгийнхан нууцхан шивнэлдэх болжээ. Харийн амбан энэ тухай сонсоод, холбоо гурван нуурыг ширгээж, баялгийг нь өвөрлөхөөр шийджээ. Нутгийн олон нуураа аврах гэж тэнгэрт залбиран гуйгаад, тусыг эс олов. Эрэг хөвөөг нь ухааж, элс чулууг нь зөөж эхлэхийн цагт ах дүү гурван нуур ширгэж үгүй болсон гэнэ. Ёроолд нь харийн амбаны мөрөөдсөн алт эрдэнэс ч байсангүй.

Харин лусын хааны ордон гэмээр ер бусын тогтоцтой агуй л үлдсэн аж. Сарны гэрэлд шөнөөр цэнхэр туяагаар дүүрч, өдөртөө хана нь толин цэнхэр өнгөтэй харагддаг энэ «ордныг» “Гурван Цэнхэрийн агуй” гэж нэрлэх болсон гэнэ.

(Хууч ярианаас)

Ховд аймгийн нутаг дахь Хойд Цэнхэрийн агуй нь Цэнхэрийн голын хөвөөнд оршдогоос ийнхүү нэрлэгдсэн бөгөөд манай улс энэ агуйг түүх соёлын дурсгалынх нь хувьд 1971 оноос улсын хамгаалалтад авчээ.
(Монголын үндэсний нэвтэрхий толь)

“Урлагийн эхлэл түүний үндэс, үүсвэр өрнө дахинд байсан бол дорно дахинд төв Азийн гүнд байжээ” хэмээн Хойд Цэнхэрийн агуйн зургийг судлаачид дүгнэжээ.
(П.Даваажав. “Залуу байгальч” номоос)

Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам, “Монголын Аялал Жуулчлалын Холбоо”-оос Гурван Цэнхэрийн агуйг Монголын 9 гайхамшгийн нэгээр тодруулж, “Батламж” хүртээжээ.

(www.shuud.mn)



Одоогоор дэлхий дээр хадны сүг зургийн насжилтаараа Испани улсын Эл Кастило агуй тэргүүлдэг байна. Энэ агуйн хадны сүг зураг 39 мянган жилийн насжилттай. Тэгвэл “Гурван Цэнхэрийн агуйн хадны сүг зургийг 40 мянган жилийн насжилттай” гэж судалгаагаар тогтоогоод байгаа юм. Үүнийг дэлхийд нотолж чадвал Гурван Цэнхэрийн агуйн хадны сүг зураг нь дэлхийд хамгийн урт насжилттай нь болох юм.

(hovd.govi.mn)

Саяхан эрдэмтэд Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутагт орших “Цагаан агуй” гэдэг газрыг судалсны үндсэн дээр 800-900 мянган жилийн тэртээ гэнд хүн амьдарч байсан байна гэж үзэж байгаа гэнэ. Хэрвээ энэ таамаг үнэн бол Монголын хамгийн эртний түүхт агуй өөрчлөгдөх бололтой.

(Х. Баттөр)

Анх Хойд Цэнхэрийн агуйн гайхамшигт зураг дүрслэлийг Ховд аймгийн Манхан сумын нэгэн ажигч гярхай малчин санамсаргүй үзэж, сумын захиргаанд мэдээлсэн гэдэг.

(Ардын ярианаас)

Агуйн зургууд нь Ази тивд цорын ганцад тооцогдох палеолитын хосгүй дурсгал агаад хуучин чулуун зэвсгийн дээд үеийн хүмүүс урлагийг ойлгож, мэдрэх, бодит хийсвэрлэл, дүрслэн үзүүлэх арга, хэлбэр ямар түвшинд байсныг харуулах чухал баримт болно.

(<http://mongolianshaman.com/node/591>)

б. Дээрх баримтуудад юуны тухай өгүүлснийг тодорхойлоод, даалгаврыг гүйцэтгээрэй.

- Агуйн зураг дүрслэл, судалгаа, ач холбогдол, үнэ цэнийн алинд хамаарах баримт нотолгоо болохыг тэмдэглээд, эхийн аль хэсэгт яаж холбон найруулж оруулахаа бодоорой.

- Эхэд өгүүлэгдээгүй шинэ баримт мэдээлэл байвал ялгаарай. Тэдгээрийг нэгтгэн, өөр цогцолбор болгон оруулах боломж байна уу? Хамтарч ярилцаарай.
 - Шинэ баримт мэдээлэл бүхий цогцолбороо хаана нь оруулбал учир зүйн болоод найруулгын хувьд зөв байх вэ? Тунгаан бодоорой.
- в. *Баримт мэдээлэл, тайлбар, дүгнэлтийг оруулан, эхийг дэлгэрүүлж бичээрэй. Тэгэхдээ мэдээлэн тайлбарласан эхийн бүтэц, дараалал, үгийн сан, өгүүлбэрийн онцлогийг харуулж, баримтаа зөв сонгож бичихийг анхаарна уу.*

3. Харьцуулан дэлгэрүүлж бичье.

а. *Дараах алхмын дагуу ажиллаарай.*

- Зургийг анхааралтай ажиглаарай.
- Дараах асуултын дагуу тэмдэглэл бичээрэй.
 - Зургуудын ижил ба ялгаатай талыг олоорой.
 - Зургийн дүрслэлээс ямар дүгнэлт хийж болох вэ?
 - Цаг хугацааны хувьд аль нь эртнийх байх боломжтой вэ? Таамаглал дэвшүүлж батлаарай.

Гурван Цэнхэрийн агуйн зураг



Фонт де Гомын зураг



б. Дараах мэдээллийн агуулгыг “Гурван Цэнхэрийн агуйн зураг” эхтэй харьцуулаарай.

Фонт де Гомын агуйн зураг



Хойд Цэнхэрийн агуйн зураг олон талаараа хуучин чулуун зэвсгийн үед хамаарах сүг зураг бүхий Фонт де Гомын агуйн зурагтай төсөөтэй юм.

Фонт де Гом бол Франц улсад байдаг бөгөөд хуучин чулуун зэвсгийн сүүл үед хамаарах эртний уран зураг, сийлбэр бүхий агуй юм. Зургийг анх Денис Пейрон хэмээх багш хүн 1901 онд нээсэн байна. Уг агуйд 200 гаруй өнгө өнгийн зураг байдаг ба голлох өнгө нь хар, улаан, бор ажээ.

Судлаачид 17000 жилийн тэртээх зураг гэж үздэг. Дүрслэхдээ хадыг сийлээд, дараа нь өнгө оруулсан гэж үздэг. Зургийн ихэнх хувийг нь бух гөрөөс, адууны зураг эзэлдэг. Хамгийн алдартай зураг нь таван бух гөрөөсний зураг гэнэ.

в. Дараах асуултын дагуу ярилцаж, тэмдэглэлээ өргөжүүлээрэй.

- Хоёр эхэд өгүүлсэн агуйн зургийн ижил ба ялгаатай талыг жагсаан бич.
- Зургийг ажиглаад, ямар үнэлгээ дүгнэлт өгөв? Саналаа солилцоорой.

г. Загварын дагуу хоёр эхийг харьцуулан, нэг эх болгон найруулж бичээрэй.

1 ... Гурван Цэнхэрийн агуй	2 ... Фонт де Гомын агуй
Байршил ... Монгол улсад	Франц улсад
Түүхэн хугацаа ...	
Нээсэн хүн ...	
Зургийн дүрслэл ...	
Юугаар зурсан ...	
Яаж зурсан ...	

- Бичихдээ дараах холбох хэрэглүүрээс ашиглаарай.

-даг⁴ бол, харин, гэхдээ, -аас илүү, хамгийн, шиг, мэт, адил

Угсарсан нийлмэл үгийг таньж, найруулгын үүргийг тодорхойлох

1. Зэрэгцсэн нийлмэл үгийн талаар сэргээн саная.

Оюун

Энэ бол хүнд төрөлхөөс заяадаг дотоод хүч. Өөрөөр хэлбэл, хүнийг бусад амьтдаас ялгах мөн чанар юм...

Хүнд төрөлхөөс заяасан оюун хэмээх тайлагдашгүй далд эрчим хүч, мөн чанарыг нээж, хөдөлгөж, тэнхээ чадал суулгахгүй бол харанхуй мунхаг явсаар дуусна. Оюуны мэлмийг нь нээж, гал зулыг нь асааж, оч цогийг нь бадрааж, гэрэлтүүлж цацруулж, билиг авьяасынх нь хүчээр тамир тэнхээ оруулж байж л хүн хүншиж, хүмүүжихийн зам мөрд ордог байна...

Хүн аливаа зүйлийг танин мэдэж, ухаарч ойлгосныгоо хэлэндээ тусган илэрхийлдэг. Үүнийг л хэлэн дэх ертөнцийн дүр зураг гэдэг. Тэгвэл оюун хэмээх энэ зүйлийг монголчууд хэлэндээ яаж илэрхийлдгийг товч тайлбарлая.

Оюун хэмээх ухагдахууныг тайлбарлахын тулд ямар ухагдахуунтай холбож сэтгэдгийг хэлний баримтаар жишээлж үзүүлье. Монгол хэлэнд оюун ухаан, оюун бодол, оюун санаа, оюун билиг гэсэн зэрэгцсэн нийлмэл үг тохиолдож байна. Үүнээс үзвэл, оюун нь ухаан, бодол, санаа, билигтэй учир зүйн ямар нэг холбоотой зүйл байх нь! Монгол хэлэнд зэрэгцсэн нийлмэл үгийн аль нь өмнөө, аль нь ардаа байрлах нь нарийн зүй тогтолтой.

Хэлний баримтаас үзвэл оюун гэдэг үг зэрэгцсэн нийлмэл үгийн бүтцэд бусад үгийн дараа орох нь тун ховор ажээ. Учир нь оюун нь хүнд угаас заяагдмал, тэнгэрлэг, сав шим ертөнцийн шинжтэй.

(Ц. Өнөрбаян, "Нээлттэй сургууль" сониноос)

- а. Эхээс зэрэгцсэн нийлмэл үгсийг олж, доогуур нь зураарай. Зурсан үгсээ ажиглаад, үгийн аймгаар бүлэглээрэй.
- б. Зэрэгцсэн нийлмэл үгийн аль нэгийг нь хасаж бичвэл эхийн утга, найруулгад ямар өөрчлөлт гарах вэ? Ярилцаарай. Жишээ нь: тамир тэнхээ - тамир, тэнхээ

2. Угсарсан нийлмэл үгийн тухай ойлголттой болъё.

- а. "Турван Цэнхэрийн агуйн зураг" эхэд байгаа дараах үгсийн утга, бүтцийг ажиглаад, асуултад хариулаарай.

жадан эвэрт, оронго гөрөөс, одос үхэр, арслан заан, тэмээн хяруул, цацагт хяруул, цэн тогоруу, сүг зураг, газар зүйч, чулуун зэвсэг)

Асуулт	Тийм	Үгүй
Эсрэг ба ойролцоо утгатай байна уу?		
Хоёр үг нийлж, нэг ухагдахуун, юмыг нэрлэж байна уу?		
Дан дангаараа асуултад хариулагдаж байна уу?		
Хоёр үг нийлж, нэг асуултад хариулагдаж байна уу?		
Зэрэгцсэн нийлмэл үгээс өөр шинжтэй нийлмэл үг байна уу?		

- б. Дараах онолын мэдээллийг уншаад, зэрэгцсэн нийлмэл үгийн тухай өмнөх мэдлэгтэйгээ холбон, нийлмэл үгийн талаарх гол ойлголтыг нэгтгэн, бүдүүвчээр илэрхийлээрэй.

Хоёр бие даасан үг зэрэгцэх ба угсрах харьцаагаар нийлж, үг бүтээх аргыг үг нийлэх арга гэнэ. Энэ аргаар бүтсэн үгийг нийлмэл үг гэнэ. Нийлмэл үгийг зэрэгцсэн ба угсарсан нийлмэл үг гэж ангилна. Хоёр үгийн нэг нь нөгөөдөө угсран захирагдаж бүтсэн үгийг угсарсан нийлмэл үг гэнэ.

Угсарсан нийлмэл үг нь хоёр аргаар холбогдож бүтнэ.

А. Нэг үг нь нөгөөдөө үндсээрээ холбогдож, хамжсан угсраа үг бүтнэ. Ингэхдээ:

- Өнгө заасан тэмдэг нэрс жинхэнэ нэртэй холбогдоно. (хөх бух, шар шувуу)
- Таван хошуу малын холбогдолтой жинхэнэ нэр амьтан, ургамал, зэвсэг хэрэглэл, бодис юмсыг заасан жинхэнэ нэртэй холбогдоно. (морин зөгий, тэмээн хяруул, үхэр чулуу)
- Байгалийн нэг бодис юмын нэр нөгөө бодис юмын нэртэй холбогдоно. (мөнгөн ус, алтан харгана, элсэн чихэр)
- Орон цаг, учир шалтгааны холбогдол бүхий 2 жинхэнэ нэр холбогдоно. (гар бөмбөг, хөл машин)
- Хоёр өөр өнгө, зүс заасан тэмдэг нэр холбогдоно. (хар хээр, цагаан цэнхэр)
- Өнгө зүс заасан тэмдэг нэр өнгө зүсний дээд чанарыг агуулсан юмсын нэртэй холбогдоно. (ангир шар, үнсэн саарал, дун цагаан)

Б. Нэрийн ба үйлийн холбох нөхцөлөөр холбогдож, найрсан угсраа үг бүтнэ.

- Нэг үг нь нөгөөтэйгөө харьяалахын тийн ялгалын нөхцөлөөр холбогдож бүтнэ. (үхрийн нүд, эдийн засаг, нохойн хошуу)
- Үйлийн тодотгон холбох нөхцөлөөр холбогдож бүтнэ. (шинжлэх ухаан, унадаг дугуй, хоргодох байр)

3. Угсарсан нийлмэл үгийг таньж, хэрэглэе.

а. Дараах эхээс угсарсан нийлмэл үгийг түүж бичээрэй.

б. Дурдсан шувуудын тухай янз бүрийн эх сурвалжаас уншиж судлан, эхийг дэлгэрүүлэн найруулаарай.

Монголын байгаль орчныг хамгаалах нийгэмлэгээс эрхлэн гаргасан “БНМАУ-ын Улаан ном” (УБ, 1987)-д дэлхий дахинаа нэн ховор болж, устах аюулд дөхөөд байгаа цагаан тогоруу, хар тогоруу, цэн тогоруу, жороо тоодог, реликт цахлай, хургач бор хэмээх 6 зүйл, мөн нутгийн ихэнх хэсгээр ховордож байгаа борцгор хотон, халбаган хошуут, хар өрөвтас, гангар хун, хуруут хун, хээрийн галуу, хошуу галуу, явлаг сар, усны цагаан сүүлт бүргэд, цасны хажир, гургуул, тоодог зэрэг 12 зүйл шувууг оруулжээ. (С. Жамбалдорж)

в. Таван хошуу малын нэр оролцсон ургамал, амьтны нийлмэл нэрийн товч тайлбар толь хөтлөөрэй. Жишээ нь: морь

Морин зөгий: Нарийвтар биетэй, шар хар эрээн зүстэй, хатгавал хортой нэгэн зүйл ялаа

Морин зээргэнэ: Цагаан ба шар цэцэгтэй, анхилам үнэртэй нэгэн зүйл ургамал

Морин мэлхий: Бие нь нарийхан, үүгүй, нэгэн зүйл мэлхий

Морин тарвага: Монгол Алтайд цөөн тоотой байдаг, биерхүү том тарвага

Өөрийгөө сорьё.

Дараах эхийг уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Богд хааны ордон



Богдын ордон нь Улаанбаатар хотын урд хэсэгт Туул голын хөвөөнд оршдог. Энэхүү ордныг 1893-1903 онд бүтээн босгожээ.

Нийт 20 гаруй сүм дуганаас бүрдсэн чуулга юм. Дурдвал: Халхавч хаалга, ямба ёслолын нээлттэй гурван хаалга, хоёр тугны мод, хэнгэрэг хонхны саравч, уран зураг, зээгт наамал, гоёл чимэглэл бүхий урчуудын хоёр сүм, Богдын мөргөл хийдэг шүтээний хоёр сүм, лаврин сүм, өвлийн ордон, хувцасны сангийн

сүм, хэрмэн хашаа, жижиг асар хаалга зэрэг орно.

Барилгууд нь ур хийц, зохиомж, төлөвлөлт, гоёл чимэглэлээрээ уран барилгын нэгэн гайхамшиг болдог. Ялангуяа Амгалан эрдэнийн хаалга нь ганц ч хадаас ороогүй 108 оньс, сүлжээ, углуургаар хийсэн хосгүй дурсгал юм. Сүм дуганы дотор болон гадна тал, дээврийн амьтан, уран зураг, гоёл чимэглэлийг шашны зан үйлийг тодорхойлсон үлгэрийн сэдвээр хийжээ.

Уг ордонд VIII Богд Жавзандамба, эх дагина Дондогдулам нар амьдарч, ажил үйлс, ямба ёслолоо гүйцэтгэж байсан ба тэдний эдэлж хэрэглэж байсан эд агуурс, хувцас хунар цөм тавиаастай байдаг. Энд хааны титэм, 80 хар үнэгний арьсаар хийсэн нөмрөг, нэг дугуй хээндээ 22000 ширхэг сувд оёсон хоргой хүрэм, хаан хатан хоёрын ор, VIII Богдыг 25 нас зооглосон өдөр Цэцэн хан аймгийн бэйс Санлигдоржийн төхөөрч бэлэглэсэн бүрэн тавилгатай, 150 ирвэсийн арьсан бүрээстэй гэр, хүүхэд ахуй цагт нь ямаанд тохон, унуулж байсан эмээл, Англид захиалан хийлгэсэн сүйх тэрэг зэрэг сонин үзмэрүүд бий. Хааны ордныг 1926 онд дурсгалын музей болгосон байна.

(“Монголын үндэсний нэвтэрхий толь”-оос)

а. Дараах асуултад хариулаарай.

- Богд хааны ордныг хэдий хугацаанд барьж байгуулсан бэ?
- Яагаад 20 гаруй сүм дуганаас бүрдсэн чуулга гэж онцолсон бэ?
- Ганц ч хадаас оруулалгүй хийсэн хэрнээ одоо хүртэл хэвээрээ хадгалагдаж байгааг юу гэж дүгнэх вэ?
- Энэ ордонд байгаа үзмэрүүдийг хайрлаж, хамгаалах нь ямар ямар ач холбогдолтой гэж бодож байна вэ?

б. Эхийн бүтцийн хэсэг тус бүрийг зааглаарай. Дараа нь цогцолбор тус бүрд юуны тухай өгүүлснийг тодорхойлоод, бүтэц ба утгын хамаарлыг бүдүүвчээр харуулаарай.

в. Чухал хэсгийг ялгах аргаар эхийг хурааж бичээрэй.

г. Чухал баримт ба мэдээллийг ялган бичээрэй.


Ерөнхий мэдээлэл

Дэлгэрүүлсэн баримт

Чухал эсэхийг тайлбарлах

д. Эхээс угсарсан нийлмэл үгийг түүж бичээд, утгын тайлбар хийгээрэй.

Балархай эгшгийн дүрмийг давтах



1. Гээгдэх эгшгийн дүрмээ сэргээн саная.

а. Тулгуур бичиглэлийг тохирох жишээтэй зөв холбоорой.



б. Дараах үгсийг тийн ялгалын нөхцөлөөр хувилгаж бичээд, дүрмийг тайлбарлаарай.

авдар, харсан, нөхөд, туурга

в. Дараах үгсийг ажиглаад, балархай эгшгийг гээж бичих аль тохиолдолд хамаарахыг тодорхойлоорой.

олноос, ханаар, боловсрол, хийсчээд, жүжгийн, авснаар, нэрлээд, суртлаар, тооныг, сурагчдад, асчхаад, шашны, халсныг, санаад

Дүрмийн тулгуур бичиглэл		
ГЭ+ЭЭ=ГЭЭ	ЭГ+ЭЭ=ГЭЭ	ГЭГ+Г=ГГЭГ

г. Дараах хүснэгт дэх балархай эгшигийг гээж бичсэн үгсийг өнгөөр ялган будаарай.

а	й	м	г	и	й	н	т	а	г	у	р	в	а	н	с	ө	н	а	р	н	ы
ж	а	ө	н	д	р	и	й	г	м	б	д	э	э	д	л	э	х	а	х	а	л
и	ё	е	г	а	л	б	и	р	а	а	р	р	х	ө	л	г	ө	ө	с	ө	б
г	х	ө	г	ш	н	и	й	г	т	а	б	д	г	а	р	з	д	а	х	м	ё
л	а	в	э	г	а	р	с	н	ы	т	э	э	э	л	б	а	я	л	г	а	а
а	в	л	з	а	э	р	е	с	т	р	й	м	м	г	х	а	н	ы	г	и	я
а	р	и	г	в	а	д	р	ы	г	ы	с	у	д	р	ы	н	м	й	а	ф	з
д	а	й	и	р	ш	а	з	а	р	г	ы	г	т	н	г	н	ө	х	д	ө	д
д	а	н	й	ы	р	а	ш	а	н	э	р	л	э	э	д	ү	т	ү	м	э	н
г	с	б	г	г	э	э	в	а	в	в	я	н	з	а	г	ы	г	а	т	г	а
х	а	м	б	а	а	с	р	р	с	г	г	с	у	р	л	а	г	ы	н	й	х
э	э	л	ж	л	э	н	г	р	ы	х	х	а	й	р	ц	а	г	л	а	а	д
а	м	ь	д	р	а	л	ы	г	р	г	м	э	д	л	э	г	т	с	э	н	ы
д	а	г	у	у	л	а	н	ө	ө	б	о	л	о	в	с	р	о	л	о	о	р

д. Балархай эгшигийг гээж бичих тохиолдол бүрээр будсан үгсээ бүлэглэн, дэвтэртээ бичээрэй.

2. Балархай эгшгийн гээгдэхгүй тохиолдлыг сэргээн саная.

а. Дараах үгсэд урт эгшгээр эхэлсэн нөхцөл залгаж бичээд дүгнэлт гаргаарай. Яагаад балархай эгшиг гээгдэхгүй байна вэ?

нөхцөл + ийг
боловсрол + ын

хүчтэн + ий
Анар +ын


тэмдэглэх+ийг
тамир + ын

- б. Балархай эгшигийг гээдэггүй дараах хэдэн тохиолдол байдаг. Тохирох жишээтэй нь зөв харгалзуулаарай.

Дүрэм	Жишээ
Оноосон нэрийн төгсгөлийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшигийг гээдэггүй.	үлгэрийн хэвлэлийн
Эгшигт гийгүүлэгч эгшиггүйдэхэд хүрвэл балархай эгшигийг гээхгүй.	боддогоор мэдсэнийг
Заримдаг гийгүүлэгчийн дараа орсон заримдаг гийгүүлэгч эгшиггүйдэхэд хүрвэл балархай эгшигийг гээхгүй.	ангирын тамираас
Үгийн дунд орсон хэлний үзүүрийн “н”, хоолойн “г”-ийн ялгах эгшигийг гээхгүй.	сурахаар давтахыг
Зөөлрүүлэх үүргээр орсон “и” эгшигийг гээхгүй.	янзагаар эрдэнээс
Тодотгон холбохын “-х”-ийн өмнөх балархай эгшигийг гээхгүй.	саналаар хагараад
Дараалан орсон гурван гийгүүлэгчийн дүрмээр бичсэн балархай эгшигийг гээхгүй.	Улаанбаатарын Норовын

- в. Дараах хоёр эхийг анхааралтай уншаад, балархай эгшиг нь гээгдээгүй үгсийг олж, дүрмийг тайлбарлаарай.

Цөл



Зарим газар эцэс төгсгөлгүй их элсээр хучигдсан байдаг. Ийм газрыг цөл гэнэ.

Тэгвэл цөл хэрхэн бий болдог вэ? Олон жилийн тэртээ дэлхий чулуугаар хучигдмал байжээ. Мянга мянган жилийн туршид салхи, нар, бороо болон хүйтэн агаарын нөлөөнд байсан олон чулуу жижгэрэн хуваагдсанаар элс тогтдог аж. Энэ элс ихээр овоорч хуримтлагдсанаас аажмаар цөл буй болдог байна.

Мод нь салхийг халхалдаг учир элсийг нүүлгэдэггүй аж. Иймээс цөлжилт бий болгохгүй байя гэвэл модоо хамгаалж, сайн тарьж, ургуулах шаардлагатай.

Нар

Гэрэл болон дулааныг ялгаруулах чадвартай бүх оддын дотроос нар хамгийн том нь ч биш, жижиг нь ч биш.

Харин том харагддагийн учир нь нар бол бидэнд хамгийн ойрхон од юм. Нар дэлхийгээс харьцангуй том. Диаметр нь 1,4 сая километр. Хэрэв дэлхийг наран дээр тавьж болдог сон бол 1,3 сая дэлхийг агуулж чадахаар хэмжээтэй аж. Нарыг сагсны бөмбөгтэй зүйрлэвэл дэлхий дэргэд нь будаа шиг л харагдах болно.

Нар дэлхийгээс 150 сая километр хол оршдог. Хэрэв тийш алхах юм бол 3500 жилийн дараа хүрч чадна.

(М.Саруул-Эрдэнэ)

3. Дүрмийг зөв хэрэглэе.

а. Дараах хоёр эхийг хуулж бичихдээ бүтээврийг зөв залгаарай.

1. Анхдагч, хоёрдогч, гуравдагч... гэх мэтээр тоолбол хэдэн зуун мянган үеийн+хэн+ий хэрэглэж байгаад цаг цагтаа өөд болж, талийхдаа ард үлд+гсэд+д+ээ үлдээсэн юм нь хэл. Харин өв+л+ж авсан хүмүүс нь хэрэглэж баяжуулж өргөтгөж байгаад бас л цагийн эрхээр нүд анихдаа ард үлдсэн хүндээ залгамж+л+уул+н үлдээдэг.. Тэр мэтээр үе+ээс үе+ийг дамжаад өнөөг хүрсэн учир+аас анх ер ямар байсан+ыг мэд+х+д бэрх. Иймээс үгийн гарал үүсэл+ийг судалж тогтоож байх учиртай. Үг хэллэг хэдийгээр цагийн аясаар өөр+чил+гд+дөг боловч анхныхаа төрөлхийн мэнгэ+ийг хэзээд хадгалсаар ирсэн онцлогтой.

2. “Дэлгэсэн тэрлэг шиг” монгол нутаг+ийн хормойг алтан шаа утас+аар эмжсэн элсэн манхан “далайнууд” үргэлжилнэ. Энэ элсэн далай элэр балар+ын эрт үедээ их усан далай байсан гэдэг домогтой. “Монголын нууц товчоон” зохиолын эхэнд монгол угсаатан+ы уг гарвал+ын түүхийг өгүүлэхдээ “Дээд тэнгэр+ээс заяат төрсөн Бөрт чоно, Хоо марал хоёр бөлгөө. Тэд тэнгис далайг гэтэлж, Онон мөрөн+ий хөвөөнд ирж нутаглавай. Тэр цагт Батцагаан хэмээх нэгэн хөвүүн төрөв...” хэмээн монгол алтан ургийнхан+ы хэлхээг аман түүхээр өгүүлдэг. Энд өгүүлж буй “тэнгис далай” нь даруй өдгөөгийн Монголын өмнөд их говь эрт урьддаа оломгүй их далай байсан агаад одоо ч их говийн элсэн цөлийн доороос далайн аварга биет амьтад, үлэг гүрвэл+ийн араг яс, ховор сонин олдвор илэрц, эртний амьтад+ын ул мөр олдсоор байгаа билээ...

(Д. Баттогтох)

б. Доогуур нь зурсан үгийг бүтцээр задалж, зөв бичих дүрмийг тайлбарлаарай.

- Өвөрхангай аймгийн Бат-Өлзийт сумын нутагт Орхоны баруун гараас жижгэвтэр гол цутгана.
- Байгалийн гоо үзэсгэлэнт Улаан цутгалангийн хүрхрээ нь аялагчдын сонирхлыг татсан үзмэрийн газар юм.
- Хамт олныхоо нэр алдрын төлөө цуцалтгүй тэмцэхийн хамт хувиа хичээх, атаархах, онгирах занг жигших ёстой.
- Шүдний цөгц яаж элэгдсэнээр насыг нь хэлдэг юм даа.

в. Балархай эгшигийн дүрмийг буруу хэрэглэсэн жишигээ арвыг олж бичээрэй. Ямар эх сурвалжаас авснаа тэмдэглээрэй.


- Ном, сонин, сэтгүүл
- Цахим хуудас
- Телевиз, радио
- Зар мэдээ
- Хаяг, зар сурталчилгааны самбар гэх мэт

IV

ТООЧИН ТАЙЛБАРЛАЖ БИЧИХ



Эзэмших мэдлэг, чадвар



1. Тоочин тайлбарласан эхийн утга, бүтцийг тодорхойлъё.

- Монгол гэрийн онцлог, түүнтэй холбоотой заншлын талаар ярилцаарай.
- Дараах эхийг уншихдаа цогцолборуудын дарааллыг анхаараарай.

Монгол гэр

Гэр бол Төв Азийн нүүдэлчин ард түмний уламжлалт сууц юм. Монгол гэр 3000 орчим жилийн тэртээгээс одоогийн хэв шинж нь бүрэлдэн, амьдралын гол хэрэгцээ болсоор өнөө цагт иржээ. Хөнгөн, авсаархан, удаан эдлэгддэг, архитектурын онцгой шийдэлтэй. Геометрийн огтлолцол бүхий конус хэлбэртэй.

Эл сууц яс мод болон бүрээс гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ. Яс мод нь унь, тооно, хана, хаалганаас бүрддэг бол бүрээсэнд өрх, дээвэр, туурга, үүд хамаарна. Бүтцийн хэсгүүдийг нь угсрах нарийн дүрэмтэй. Үүнээс гадна хэсгүүдийг хооронд нь уяж бэхэлдэг бүдүүн, нарийн, урт, богино оосор бүчүүд чухал үүрэгтэй.

Ямар ч орон сууцны зай, багтаамж хананаас хамааралтай байдаг. Гэрийн ханыг нүүдэл хийх үед авсаархан, харин сууц болгон ашиглахад хэд дахин том болгохын тулд эвхдэг сараалж маягаар хийдэг. Гэрийн хэмжээ хананаас хамаарч янз бүр байна. Монгол гэр ихэвчлэн 4, 5, 6, 8, 10 ханатай байна. Үүнээс улбаалж, таван ханат, найман ханат, их таван ханат, бага таван ханат гэх мэтээр нэрлэдэг. XIX зууны эцэс хүртэл жирийн малчин айл дөрөв, чинээлэг баячууд тав, харин аймгийн хан, хошуу тамгын газар 8-10 ханатай гэр барьдаг байжээ.

Эрт цагт хүмүүс ширмэл эсгий хаалтыг дээш сөхөж орж гардаг байсан бол орчин үед модон хаалга хэрэглэх болжээ. Хаалга нь ханатай адил гэрийн дээд хэсгээс ирэх ачааллыг дааж байдаг, бас түүнийг байнга нээж, хааж байдаг тул бат бөх хийдэг учиртай.

Монгол гэрийн унийг тогтоож байдаг, цамхаг бүхий дугуй цагираг модыг тооно гэнэ. Гэрийн зай багтаамжийг ихэсгэх, гэрэл гэгээ оруулах, яс модны гол бүтцийг тогтооход чухал үүрэгтэй. Малчид үнээ малаа саах, хонь бэлчээх, хотлуулах зэрэгт гэрийнхээ тооноор туссан нарны тусгалаар цагийг баримжаалдаг заншилтай юм. Монголчууд тооныг гэрийн “Сүлд” хэмээн дээдэлсээр иржээ.

Тооно тэгш байх, мөн байгалийн салхи, шороо, шуурганаас болж гэр хазайх, унахаас сэргийлж, баганыг ашигладаг. Гэр барихдаа баганыг тоононд бэхэлж, босгодог. Баганын өндрөөр гэрийн өндрийг хэмжинэ. Түүнийг хаалганаас 1,5 метр өндөр байхаар тооцоолж хийнэ.

Гэрийн доторх нарны цацрагийг бэлгэддэг яс мод бол унь. Энэ нь хана болон тооныг холбох, бүрээсийг тогтоон барих үүрэгтэй. Монголчуудын дунд шулуун болон махир үзүүртэй хоёр янзын унь уламжлагдан иржээ. Таван ханатай гэрийн унь 2-2,5 метр урт байдаг бол дөрвөн ханатай гэрийн унь 1,5-2 метр урттай байдаг.

Гэрийн бүрээсийг хонины ноосоор хийж, ямааны тосоор тослон, борооны ус нэвчихээргүй болгодог. Өнгийг нь цайруулахын тулд эсгийг ясны гурил, шохойгоор өнгөлнө. Эсгийгээр өрх, дээвэр, туурга, үүд зэргийг хийх бөгөөд энэ нь дулааныг хамгийн бага алддаг бүрээс юм.

Тоонон дээгүүр бүтээж, нар, салхи, цас, бороо, шороо, хурц гэрэл гэгээнээс хамгаалах, мөн гэрт тусах нарны гэрэл гэгээг тохируулах үүрэгтэй бүрээс бол өрх. Харин гал голомт арвай будаа шиг арвижин дэлгэрч, цэвэр тунгалаг байхыг бэлгэддэг оосор бол чагтага. Тоононы чанх голоос чагтагыг уяж, сул үзүүрийг унинд хавчуулна. Салхи ихтэй үед чагтагыг буулгаж, үзүүрт нь хүнд юм уях буюу газарт гадаслах замаар гэрийг хөдөлгөөнгүй болгодог.

Гэрийн модны хээ угалз, чимэг, өнгө будаг эрт үеэс уламжлалтай. Монголчууд улаан, улбар өнгө бол нарны дулаан орчныг бүрдүүлдэг гэж үздэг учир тооно, унь, багана, хаалгаа ийм өнгөөр буддаг. Харин нарны гэрлийг гэрийн дотор хэт хурц тусахаас сэргийлж, унины цээжийг ногоон өнгөөр тайвшруулан буддаг болжээ.

Гэрийн доторх зайг хоймор тал, үүдэн тал, гэрийн эзэгтэйн тал, гэрийн эзний тал гэж ялгах нь зай талбайн журмыг тогтоосон хэв ёс байжээ. Монголчууд гэрийнхээ гол дунд гал голомт буюу тулгаа байрлуулдаг. Түүнийг тойрсон орон зайн баруун талд эрэгтэй хүний эд зүйл, зүүн талд эмэгтэй хүний эд зүйлийг байрлуулдгаас болж эзэгтэй тал, эрэгтэй тал хэмээх болсон ажээ. Мөн гэрийн доторх орон зайг 12 жилээр хуваан нэрлэх, зүг чиг заах, өнгөөр ялган, гэрийн наран цагийн хуваарийг бий болгосон нь гэртэй холбоотой ардын мэдлэгийн нэгэн өв билээ.

Гэр бол барих, буулгах, зөөж тээвэрлэх, үйлдвэрлэх арга технологи нь хялбар, багтаамжийн хувьд хамгийн оновчтой, агаарын болон дулааны солилцоог амархан зохицуулах бололцоотой сууц бөгөөд нүүдэлчин монголчуудын бүтээсэн гайхамшигт эдийн соёлын нэг юм.

[\(https://mn.wikipedia.org/wiki/\)](https://mn.wikipedia.org/wiki/)



а. Дараах асуултад хариулж, бичээрэй.

- Монгол гэрийн түүх хэдий үеэс эхэлдэг вэ?
- Монгол гэр конус хэлбэртэй байдгийн давуу талуудыг мэдэж, мэдээлэл солилцоорой.
- Монгол гэр бол нүүдэлчин монголчуудын бүтээсэн эдийн соёлын нэг. Суурин соёл иргэншил рүү шилжиж буй өнөө үед хэр үнэ цэн, ач холбогдолтой вэ? Саналаа солилцоорой.
- Монгол гэрийн бүрдэл хэсгүүдийн нэрийг зургийн хажууд бичээрэй.

б. Монгол гэрийн бүрдэл хэсэг, тэдгээрийн үүргийг ялгаад, хүснэгтээр харуулаарай.

в. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг өөр өнгөөр ялган тэмдэглээрэй.

г. Эхийн бүтцийг шинжлэхдээ дараах хүснэгтийн дагуу ажиллаарай.

- Аль хэсэгт ерөнхий танилцуулга, аль хэсэгт нэмэн дэлгэрүүлж, сэдвийг дэмжсэн санаа, аль хэсэгт дүгнэлт байгааг тэмдэглээрэй.

Бүтцийн хэсэг	Цогцолборын дугаар	Цогцолбор тус бүрд юуны (сэдэв) тухай өгүүлсэн байна вэ?
Эхлэл		
Гол хэсэг		
Төгсгөл хэсэг		

д. Дараах асуултын дагуу ярилцаад, эхийн бүтэц ба утгын холбоо хамаарлыг бүрдүүвчээр харуулаарай.

- Аль нь хамгийн ерөнхий сэдэв бэ? Яагаад?
- Дэд сэдвүүд нь юу юу вэ? Яагаад ингэж үзсэн бэ?
- Дүгнэлт өгсөн хэсэг байна уу? Түүнийг яаж таньсан бэ?

2. Тоочин тайлбарласан эхийг задлан шинжилье.

а. Өгүүлэгч “Монгол гэр” эхийг ямар зорилгоор бичсэнийг тодорхойлоорой.

б. Тоочин бичих онцлогийг дараах асуултын дагуу шинжлээрэй.

- Ямар үгийг олон удаа хэрэглэсэн байна вэ?


Үгийн аймаг	Жишээ	Ямар утгаар орж байна вэ?
Жинхэнэ нэр		Юмыг заан нэрлэсэн.
Тэмдэг нэр		
Үйл үг		
Тооны нэр		
Орон цагийн нэр		
Дүрслэх ба дуурайх үг		

- Үгийн аймаг тус бүрийн хэл зүйн хэлбэржилт нь ижил байна уу? Ялгаатай байна уу? Ажиглаарай.
- Таслалыг олон удаа хэрэглэсний учир юу вэ? Тайлбарлаарай.

в. Үгийн утгыг шинжлээрэй. Дараах загварын дагуу ажиллана уу.

Үг хэллэг	Байна (+) Байхгүй (-)	Жишээ	Шалтгаан
Далд утгатай үг хэллэг			
Шууд утгатай үг хэллэг			
Мэргэжлийн болон нэр томъёоны үг			
Уран дүрслэл			

г. Баг болж, өгүүлбэрт шинжилгээ хийгээрэй. Эхлээд өгүүлбэрүүдээ дугаарла. Дараа нь бүдүүвчийн дагуу хувааж ажиллаад, нэгтгэнэ үү.




д. Өгүүлбэр, цогцолборуудаа юугаар холбож, яаж дараалуулсныг тодорхойлоорой.

- Дараах хүснэгтийн дагуу ажиллана уу. Жишээ нь:

Цогцолборын дугаар	Цогцолборын доторх өгүүлбэрийг юугаар холбосон байна вэ?	Цогцолборуудыг юугаар холбосон байна вэ?
4	ба - зэрэгцүүлэн холбох үг харин - зэрэгцүүлэн холбох үг тулд - шалтгааны утгат угсруулан холбох үгээр	

- Дээрх хүснэгтийг сайн ажигла. Зэрэгцүүлэн болон угсруулан холбох хэрэглүүрийн алийг нь олон хэрэглэсэн байна вэ? Учрыг тайлбарлаарай.

е. Дараах бүдүүвчийг ажиглаад, цогцолборуудыг ингэж дараалуулсны учрыг тайлбарлаарай. Эдгээрийн байрыг сольж болох уу? Яагаад?



ё. Эхэд дараах ойлголтууд байгаа эсэхийг шинжлээд, байгаа, байхгүйн учрыг бичигчийн зорилготой холбон тайлбарлаарай.



3. Баримтад шинжилгээ хийе.


- а. Эх дэх ерөнхий мэдээлэл болон баримтыг өөр өнгөөр ялгаж будаарай.
- б. Ерөнхий мэдээлэл, баримт хоёр тохирч байгаа эсэхэд шинжилгээ хийнэ үү. Дараах хүснэгтийн дагуу ажиллаарай.

Цогцолборын дугаар	Ерөнхий мэдээлэл	Чухал баримт

Жишээ баримтаар баталж, тоочин тайлбарлаж бичих

1. Сэдэв сонгож, мэдээ, танилцуулга бичье.

а. Дараах бүдүүвчийг ажиглаад, хэт ерөнхий, ерөнхий, тодорхой сэдвийн аль нь болохыг цэгийн оронд тэмдэглээд, учрыг тайлбарлаарай.



б. Хэт ерөнхий, ерөнхий, тодорхой сэдэв сонгохын давуу ба сул талыг тунгаан, ярилцаарай.

Сэдэв	Давуу тал	Сул тал
Хэт ерөнхий		
Ерөнхий		
Тодорхой		

в. Өгсөн сэдвээс сонгоорой. Сонгохдоо дараах асуултын дагуу тунгаагаарай.

- Энэ сэдэв хэр сонирхолтой вэ? Энэ сэдвийн талаар хэр мэдэх вэ?
- Хэт ерөнхий эсвэл явцуу сэдэв биш биз?
- Мэдээллийн олон эх үүсвэрээс баримт, мэдээлэл хайх боломжтой юу?
- Бусдаасаа сонсож, баримт мэдээллээ өргөжүүлэх боломжтой юу?

- Ховордсон ургамлын тухай
- Уламжлалт баяр наадмын тухай
- Монголын түүхэн болон алдартай хүний тухай
- Монгол цайны ёсны тухай
- Монгол үндэсний хувцасны тухай
- Байгаль ертөнц, гараг эрхсийн элдэв үзэгдлийн тухай

2. Мэдээлэл цуглуулж, бүлэглэе.

а. Цуглуулахын өмнө дараах зөвлөгөөг уншаарай.

Зөвлөгөө

1. Ямар ямар эх үүсвэрээс мэдээлэл хайж болох вэ? Өөрт тань ямар боломж бололцоо байна вэ? Жишээ нь: Номын сан, сонин, интернэт, телевиз, радио, сэтгүүл, олон нийтийн мэдээллийн сүлжээ...
2. Мэдээллээ яаж хайх вэ? Сэдвээр, түлхүүр үгээр, эхлэл төгсгөлийн өгүүлбэрээр, цогцолбороор, ойролцоо утгатай үгээр...
3. Чанартай, үнэн зөв, найдвартай мэдээлэл мөн эсэхийг мэдэж хяна.
4. Мэдээллийг ямар зорилгоор цуглуулж байгаагаа бод.

б. Цуглуулсан мэдээллээ эмхэлж, цэгцлэхдээ сэдвээр эсвэл түлхүүр үгээр нь бүлэглээрэй.

Мэдээлэл цуглуулсан эх үүсвэр	Хаана?	Сэдэв	Түлхүүр үгс
Сонин хэвлэл	Өдрийн сонин, 1-р нүүр		
Интернэт	News.mn сайт		


Зөвлөгөө

Мэдээллээ цэгцэлж, зохион байгуулахдаа:

1. Өгүүлэгдэж байгаа юм нь юу вэ? гэдгийг шинжил.
2. Миний бичсэн мэдээллийг хэн унших вэ? гэдгийг бод.
3. Бичих мэдээлэл тань ач холбогдолтой юу? гэдгийг сайн тунгаа.
4. Мэдээллээ дугаарлах, өнгөөр ялгах, бүдүүвчээр зураглах зэргээр бүлэглэ.

3. Бичих төлөвлөгөө гаргая.

а. Дараах бүтцийг уншаарай.




б. Төлөвлөгөө гаргаарай. Дараах аргуудаас санаа аваарай.

- Наадаг цаас ашиглан, төлөвлөөрэй.



- ✓ Бичих санаануудаа наадаг цаасан дээр бичээд, дараа нь түүнийг зөв дараалал, эмх цэгцэд оруулаарай.
- ✓ Шинэ санаа нэмэх бол өөр цаасан дээр бичээд, тохирох газар нь байрлуулах зэргээр ажиллаарай.

- Бүдүүвч, хүснэгт ашиглан, төлөвлөөрэй. Жишээ нь:



Сэдэв	Ирвэсийн тухай
Зорилго	Уншигчдад танин мэдүүлэх
Хэв маяг	Тайлбарламж
Тайлбарлах арга	Мэдээлэн тайлбарлах

Эхийн бүтэц	Бичих бүтэц	Жишээ
Эхлэл	Сэдвийн танилцуулга	Гадаад төрх, зарим нэг онцлог
Гол	Сэдвийг дэмжсэн санаа -1	Уулын хүйтэнд дасан зохицсон.
	Сэдвийг дэмжсэн санаа -2	Ирвэс бол махчин амьтан
	Сэдвийг дэмжсэн санаа -3	Ирвэсийн тоо толгой хорогдож байна.
Төгсгөл	Дүгнэлт	Агнахыг хориглож, "Улаан ном"-д орсон.

4. Ноороглон бичье.

а. Бичихийн өмнө сурагчийн бичсэн мэдээллийг уншаад, дараах шалгуурын дагуу засаж сайжруулаарай.

- Эхийн бүтцийн хэсэг, цогцолборын уялдаа холбоо, дарааллыг гаргаж чадсан эсэх
- Дэмжсэн санаа нь ерөнхий сэдэв рүү чиглэсэн эсэх
- Ерөнхий мэдээлэл, баримт хоёр тохирч байгаа эсэх
- Чухал баримтыг сонгож чадсан эсэх
- Зөв бичих дүрмийн болон найруулгын алдаатай эсэх



Ирвэс

Цогцолбор 1

Ирвэс нь мий овгийн амьтан. Цоохор зүстэй, сунагар урт, том биетэй. Мөч богино, том нуумал хумстай. Толгой жижиг, чих богино, нүд том, хүүхэн хараа дугуй, хэвлий хавиар толбогүй, цагаан цайвар. Толгой, духны хэсэгтээ жижиг жижиг шигүү хар толботой. Архирдаггүй. Цагт 60 километр хурдлах чадвартай.

Цогцолбор 2

Ерөнхий мэдээлэл: Түүний биеийн онцлог нь уулын орчинд дасан зохицох нөхцөлийг бүрдүүлдэг.

Дэмжих баримт: Бие бахим, үс өтгөн, чих жижиг, дугуй байдаг тул дулаан бага алддаг. Тавхай өргөн байдаг нь цасан дээр явах, жингээ жигд хуваарилахад хэрэг болдог бөгөөд тавхайдаа үстэй байдаг нь эгц гадаргуу дээр чадмаг явахад тусалдгаас гадна биеийн дулааныг бууруулдаг ажээ. Урт, уян хатан сүүл нь тэнцвэрээ олоход дэм болдог төдийгүй өтгөн үстэй учир дулаан алдагдлыг багасгахаас гадна унтахдаа нүүрээ хучдаг хөнжлийн үүрэг гүйцэтгэдэг байна.

Цогцолбор 3

Ерөнхий мэдээлэл: Ирвэс бол махчин амьтан.

Дэмжих баримт: Идэш тэжээлийн 40 гаруй хувийг янгир ямаа эзлэх бөгөөд аргаль, хонь, тарвага, туулай, огдой, хойлог зэрэг амьтдыг барьж иднэ. Голдуу бүрэнхий харанхуйд хоолоо олно. Монгол Алтай, Говь-Алтай, Алтайн өвөр говь, Хөвсгөлийн уулс, Хангайн нуруунд нутагладаг.

Цогцолбор 4

Ерөнхий мэдээлэл: Судалгаанаас үзэхэд ирвэсийн тоо толгой багассан бөгөөд энэ нь хэд хэдэн шалтгаантай.

Дэмжих баримт: Худалдааны зорилгоор цоохор ирвэсийн арьсыг голдуу толгойн яс, сарвууны хамт үргэлжээр нь бэлтгэдэг. Мөн мах, ясыг нь хил давуулан наймаалдаг. Хөх сэрх, Модонт, Баатарсайхан ууланд цоохор ирвэс халуурч үхсэн тохиолдол бий. Бас нялх гүен үерт урсах, махчин амьтдад бариулах зэргээр үрэгдэнэ. Эзэнгүй бэлчих гэрийн малд халдвал эзэн нь түүнийг хавх тавих, буудах зэргээр хорооно. 1970-аад оны дундуур 2000 орчим ирвэс бүртгэгдсэн бол сүүлийн үеийн судалгаагаар 700-1200 болсон байна.

Цогцолбор 5

Дүгнэлт: 1993 оноос ан олзворын зориулалтаар агнахыг хориглож, “Амьтны тухай хууль”-д нэн ховор амьтнаар бүртгэн оруулжээ.

(Сурагч Б.Номингэрэл)

б. Төлөвлөгөөний дагуу ноороглон бичихдээ дараах алхмыг баримтлаарай.

- Эхлэл хэсэгт ерөнхий сэдэв болон түүнтэй холбоотой санаагаа бичээрэй.
- Гол хэсэгт ерөнхий мэдээлэл бүхий өгүүлбэр цогцолбор тус бүрд заавал байх ёстойг анхаараарай. Ерөнхий мэдээллээ батлах баримт нотолгоо оруулаарай.
- Төгсгөл хэсгээ бичээрэй. Дүгнэлт хийхдээ дараах зөвлөгөөг дагаарай.

Зөвлөгөө

1. Өмнө бичсэн санаагаа тэр чигээр нь хуулж бичихгүй байх
2. Бичиж байгаа сэдвийнхээ баримт, мэдээлэлд тулгуурлан, гол санааг гаргах
3. Эцэст нь уншигчдад хамгийн сонирхолтой байж болох, эсвэл тэдэнд хандаж юуг ойлгуулах гэсэн санаагаа бичих

в. Ноороглноо хянаад, засаарай.

- Бичсэнээ дахин анхааралтай уншаад, дараах асуултын дагуу хянаарай.

Шалгуур	Тэмдэглэл
Эхлэл хэсэгт ерөнхий санаагаа гаргасан байна уу? Нэмж бичих юм уу, өөрчлөхөөр зүйл байна уу?	
Гол хэсгийн цогцолбор бүрийн санаа, бүтцийг зөв зохион байгуулсан байна уу?	
Сонгосон баримт нь санаагаа баталж нотолж чадаж байна уу?	
Сэдэвтээ тохироогүй илүүц санаа, баримт мэдээ оруулсан байна уу?	
Төгсгөл хэсэгтээ санаагаа ерөнхийд нь дүгнэсэн байна уу?	

- Зөв бичих дүрмийн болон найруулгын алдаагаа засаарай. Дараах тэмдэглэгээг ашиглаарай.

Алдаа	Засвар	Тэмдэглэгээ
Үсэг, бүтээвэр, үг, өгүүлбэр дутаасан	Нэмэх, оруулах	↑
Үсэг, бүтээвэр, үг, өгүүлбэр илүү бичсэн	Хасах	↓
Үсэг, үг, өгүүлбэрийг буруу байрлуулсан	байр солих (зэрэгцээ бол)	↔
	Шилжүүлэх (хол зайтай бол)	↔
Үг нийлүүлж бичсэн	Салгах	
Үг салгаж бичсэн	Нийлүүлэх	
Догол мөр гаргаагүй	Догол мөр гаргах	Z

2. Бичсэнээ сольж уншаад, санал зөвлөгөө авч, дахин сайжруулаарай.

- Дээрх (в)-д байгаа шалгуурын дагуу сайжруулах санал зөвлөгөөг аваарай.
- Хэний ямар санал зөвлөгөөг тусгахаа сайн шийдэж, засаарай.
- Сайжруулснаа цаасан дээр сийрүүлэн хуулж бичээд, холбоотой зураг дүрсээр чимэглээрэй.
- Ангийнхантайгаа хамтран “Танин мэдэхүйн ном” бүтээж, ангийнхаа номын санг баяжуулаарай.

5. Хамтран бүтээл хийцгээе.

Сүүлийн жилүүдэд цаг уур, хүрээлэн буй орчны таагүй сөрөг үзэгдлүүд ихээр гарч, экосистемд гажуудал үүссэн нь хэн бүхэнд тодорхой. Тиймээс “Дэлхийн дулаарал ба цаг уурын өөрчлөлт” сэдвээр танилцуулга бэлтгээрэй.



Өөрийгөө байгаль хамгаалах мэргэжилтэн гэж төсөөл. Өнөө үед байгалийг тэнцвэртэй байхад чухал үүрэгтэй амьтдын тоо толгой цөөрч байна. Тиймээс байгалийн тэнцвэрт байдлын ач холбогдол, амьтдын байгальд нөлөөлөх нөлөөллийн талаар орон нутгийн хүмүүст мэдээлэл өгөөрэй.

Чи өөрийгөө аяллын хөтөч гэж төсөөл. Тэгээд монгол орноор тойрон аялал хийх гэж байгаа хүмүүст зориулсан гарын авлага бэлтгээрэй.



Бэрхшээлээс шантардаг хэн нэг найздаа зориулан, түүнд үлгэр дуурайл болохуйц, амьдралдаа унаж боссон ч, шантралгүй тэмцээр амжилтад хүрсэн алдартай хүмүүсийн талаар судлан, ном бүтээж, уншуулаарай.

Жишээ баримтаар баталж, тоочин тайлбарлаж ярих

1. Мэдээллээ бэлтгэе.

а. Дараах сэдвийн дагуу мэдээлэл цуглуулаарай.

Өөрийгөө Үндэсний номын сангийн ховор номын тасгийн ажилтан гэж төсөөл. Чи ажлынхаа чиглэлээр ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад “Монголчуудын үнэт баялаг - номыг эрхэмлэх уламжлалт ёсон” сэдвээр мэдээлэл хийхээр болжээ.

б. Дараах санааг заавал оруулаарай.

- Монголчууд номыг хэрхэн дээдэлдэг байсан, түүнийг батлах ямар ямар баримт, мэргэн үг байдаг тухай
- Монголчууд автомат машинаар тоноглогдсон хэвлэх үйлдвэртэй болохоос өмнө бүтээсэн үнэт, ховор номуудын талаар
- Тэд номыг ямар аргаар хийдэг, номоо яаж хавтаслаж, чимэглэдэг байсан талаар

в. Цуглуулсан мэдээллээ цэгцлэн, яриагаа төлөвлөөрэй.

- Цуглуулсан мэдээллээсээ алийг нь эхлэл хэсэгт оруулах вэ? Яаж эхлэх вэ?
- Сэдвийг дэмжсэн санааг ямар ямар баримтаар батлах вэ? Аль нь чухал вэ?
- Хэрхэн дүгнэх вэ? гэдгээ төлөвлөөрэй. Өөрөө дүгнэх үү? Бусдын үнэлгээ дүгнэлтээр төгсгөх үү?

г. Зориуд цаг гаргаж, яриагаа бэлтгээрэй.

2. Мэдээлэн тайлбарлаж ярья.

а. Дараах шалгуурын дагуу өөрийгөө үнэлээрэй.

Шалгуур	Үнэлгээ
Ярих сэдвийнхээ талаар ерөнхий мэдээлэл хийсэн үү? Түүнийг баримтаар баталсан уу?	
Ярих сэдвийнхээ санааг дэмжсэн чухал мэдээллийг оруулж, баримтаар нотолж чадсан уу?	
Баримтаа янз бүрийн эх үүсвэрээс авсан уу?	
Монголчуудын оюуны соёлыг хэрхэн үнэлж, хүндэтгэж ирснийг дүгнэж чадсан уу?	
Ойлгомжтой, тодорхой, өөртөө итгэлтэй ярьж чадсан уу?	

Өөрийгөө сорьё.

а. Эхлэл хэсгийн тухай ойлгосноо бататгаарай.

Бодомж	Зөв	Буруу	Яагаад?
Эхлэл хэсэгт эхийн сэдэв, түүний тухай ерөнхий танилцуулга, мэдээлэл байх ёстой.			
Эхлэл хэсэгт өгүүлсэн санаа нь гол хэсгийнхээ санааг чиглүүлэх үүрэгтэй.			
Эхлэл хэсэгт баримт огт оруулж болохгүй.			

б. Гол хэсгийн тухай ойлгосноо бататгана уу.

Бодомж	Зөв	Буруу	Яагаад?
Гол хэсгийн цогцолборуудын санаа нь эхлэл хэсэгт өгүүлсэн санааг дэмжинэ.			
Гол хэсгийн цогцолборын байр дарааллыг ямагт чөлөөтэй сольж болно.			
Гол хэсгийн цогцолборыг ихэвчлэн угсруулан холбох үгээр холбоно.			
Гол хэсэгт бичигчийн сэтгэл хөдлөл, сэтгэгдэл, мэдрэмж, тайлбар хааяа орж болно.			

в. Дараах хүснэгтийг нөхөж, тоочин тайлбарласан эхийн онцлогийн талаарх ойлголтоо бататгаарай.

Асуулт	Хариулт
Тоочин тайлбарласан эхийг ямар зорилгоор, ямар аргаар бичих вэ?	
Ямар утгатай үг зонхилдог вэ?	
Өгүүлбэрүүд ихэвчлэн ямар нөхцөлөөр төгсдөг вэ?	
Баримт мэдээллийг дам эх сурвалжаас авбал ямар үг, нөхцөл хэрэглэх вэ?	

г. Дараах бодомжийг бодоод, саналаа солилцоорой. Бодомжийн өмнөх дугуйд зөв бол (+), буруу бол (-) тэмдэг тавиарай.

- Төгсгөл хэсэгт бичигчийн дүгнэлт, тухайн эхийн гол санааг бичнэ.
- Эхлэл болон гол хэсэгт байгаа санаагаа давтана.
- Тухайн сэдэвтэй холбоотой уншигчийн сонирхлыг татахуйц санааг оруулж болно.

1. Гадаад үгийг яагаад хэрэглэдгийн учрыг мэдье.

а. Чиний бодлоор дараах эхэд ямар ямар гадаад үг байна вэ? Доогуур нь зураарай.

Эс

Ганцхан эсээс л амьдрал эхэлдэг. Анхны эс хуваагдан хоёр, хоёр нь дөрөв гэх мэтээр үргэлжилнэ. Ердөө дөчин долоо хоног хуваагдсаны дараа 10 мянган их наяд эс бий болох бөгөөд ийнхүү чи хүн болж төрөхөд бэлэн болно. Тэдгээр эс бүхэн чиний олдсон цагаас эцсийн амьсгалаа хураах хүртэлх хугацаанд чамайг яаж асарч, чамд хэрхэн хандахыг мэддэг.

Чамд эсээсээ нуух нууц гэж байхгүй ба тэд чиний талаар чамаас ч илүүг мэднэ. Тус бүрд нь бүрэн генетик код бий. Энэ нь чиний биеийн талаарх төгс зааварчилгаа болно. Иймээс эс зөвхөн өөрийн ажлаа хийгээд зогсохгүй бусад эсийнхээ ажлыг яаж хийхийг мэддэг. Чи амьдралдаа хэзээ ч эсэндээ аденозин тризосфатын түвшнийг анхаараарай гэх буюу дөнгөж сая гарч ирсэн нэмэлт фолийн хүчлийг хаана аваачиж байрлуулах талаар хэлэх шаардлагагүй. Эс чиний өмнөөс үүнийг хийх бөгөөд өөр бусад сая сая эсийн үйлдлийг хажуугаар нь гүйцэтгэдэг.

Эсүүд чинь 10000 их наяд иргэн гэсэн үг. Тус бүр нь өөрсдийнхөө онцгой, нарийн арга замаар сайн сайханд чинь хувь нэмрээ оруулж байдаг. Тэдэнд хийхгүй зүйл гэж үгүй. Тэд чамд таашаал мэдрүүлж, бодол үүсгэдэг. Зогсож, биеэ сунгаж, үсрэх боломж чамд олгодог. Хоол идэхэд чинь тэндээс шим тэжээлээ сорж аван, энергийг нь түгээж, хаягдлыг нь зөөвөрлөж гаргадаг. Тэр чамайг өлсгөж, хоол идсэний дараа цатгалдуулдаг. Мөн чамд хоол идэхээ мартаж боломж олгохгүй. Үсийг чинь ургуулж, тархийг чинь чимээгүй чичирхийлүүлж байдаг.

Эс хэрэгцээгүй болмогцоо нэр төртэйгөө өөрсдийгөө устгадаг. Өөрсдийг нь тогтоон барьж байсан бүхий л зүйлсийг задлан, дотоод бүрдэл хэсгүүдээ идэж устгадаг. Энэ процессийг апоптоз буюу эсийн программчлагдсан үхэл гэж нэрлэдэг. Өдөр бүр олон тэрбум эс чиний сайн сайхны төлөө үхдэг бөгөөд өөр бусад олон тэрбум эс үлдэгдлийг нь цэвэрлэдэг. Үнэндээ хэрвээ амьдар гэж тушаагаагүй л бол, эсвэл өөр эсээс ямар нэг идэвхтэй зааварчилгаа аваагүй л бол автоматаар өөрийгөө устгадаг.

Эсийг олон зүйлтэй зүйрлэдэг. “Цогц химийн боловсруулах үйлдвэр” хэмээн физикч Жеймс Трэфил хэлсэн бол “Асар том, хөдөлгөөнт хот шиг” хэмээн биохимич Гай Браун хэлжээ... (“Шинжлэх ухааны түүх-II” номоос)

б. Эхийн утга санааг ойлгож, ярилцаарай

в. Дараах асуултын дагуу ярилцаж, гадаад үгийн талаар ойлгоорой.

- Уг эхэд гадаад үг ямар үүрэгтэй орсон байна вэ? Гадаад үгийг хэрхэн таньснаа тайлбарлаарай.
- Ямар аймгийн үг зонхилж байна вэ?
- Эдгээр гадаад үгийг монголчлох боломж бий юү? Саналаа солилцоорой.
- Гадаад үг тухайн хэлэнд яаж орж ирдэг юм бол?

г. Гадаад үгийн тухай дараах тайлбарыг уншаад, гол ойлголтыг дэвтэртээ тэмдэглээрэй.

Улс үндэстний олон талын харилцаа холбоо өргөжиж, шинжлэх ухаан хөгжихийн хэрээр хэлэнд шинэ юм, ухагдахууныг нэрлэсэн үг байнга орж ирж байдаг. Тухайн хэлэнд бусад хэлнээс орж ирсэн үгийг гадаад үг гэнэ. Зайлшгүй тохиолдолд оновчтой авч хэрэглэсэн харь үгс нь хэлний үгийн санг баяжуулж байдаг. Харь хэлнээс ихэвчлэн шинээр үүссэн юм уу, урьд өмнө нь байгаагүй эд зүйлийн нэр, соёл шинжлэх ухааны холбогдолтой олон улсын чанартай үг хэллэг, нэр томъёо зэргийг зээлдэг байна. Харин үйл үгийг харь хэлнээс зээлдэггүй. Зарим гадаад үг монгол хэлэнд ороод монголжсон байдаг тул гадаад үг гэж танигдахгүй болсон байдаг.

Гадаад үг нь:

- Ихэвчлэн Манж, Хятад, Самгарди, Төвөд, Араб хэлнээс авч хэрэглэсэн үг байдаг. Гэхдээ эдгээрийн ихэнх нь гадаад үг гэж танигдахгүй болсон байна.
- Орос хэлнээс шууд орж ирсэн үг байна.
- Энэтхэг, Европ, Азийн бусад хэлнээс шууд орж ирсэн үг байна.
- Техник технологи, шинжлэх ухааны хөгжилтэй холбоотой орж ирсэн үгс байна.

2. Гадаад үгийг зөв бичье.

а. Дараах гадаад үгсийг тийн ялгалын нөхцөлөөр хувилгаж бичээрэй.

автобус математик рубль термометр

б. Гадаад үгийн дүрмийг судлаад, зөв бичсэн эсэхээ шалгаарай.

Нэг үгэнд хэд хэдэн өөр эр эгшиг байвал аль өргөлттэй эгшигт нь зохицуулан залгавар залгана. Хэрэв эр эгшиг дээр өргөлт ноогдоогүй байвал эхний эр эгшигт зохицуулан залгавар залгана. Жишээ нь: **автобуснаас, прокуророос**

“к” үсгээр төгссөн эр үгэнд “ий” эгшиг залгана. Жишээ нь: **паркийн, маркийг, математикийн, арифметикийн**

Орос хэлний “у” үсгийг монгол хэлний “ү” эгшигтэй адилтган, эм эгшигт тооцож, залгавар залгана. Жишээ нь: **клубээс, группийн**

Хоёр үгээс бүтсэн гадаад үгийн сүүлчийн үгийн эгшигт зохицуулан залгавар залгана. Жишээ нь: **амперметрийн, агротехникээр**

Гадаад үгийн эцсийн эгшиг өргөлттэй бол хасаж болохгүй. Жишээ нь: **кино, пальто**

Гадаад үгэнд ямар нэг эр эгшиг байхгүй бол эм үгийн “ий” залгана. Жишээ нь: **химийн, менежерийг**

V

ШАЛТГААН, ҮР ДАГАВРЫН ХОЛБОО ХАМААРЛЫГ ГАРГАЖ БИЧИХ



Эзэмших мэдлэг, чадвар

Албан бичгийн эхийг задлан шинжилж, бүтэц үгийн сан, найруулгын онцлогийг тодорхойлох

Албан бичгийн тогтсон бүтэц загварын дагуу учир шалтгааны холбоо хамаарлыг гаргаж бичих

Угсарсан нийлмэл өгүүлбэрийг таньж, найруулгын үүргийг тодорхойлох

Хатуу, зөөлний тэмдгийн дүрмийг давтах

Албан бичгийн эхийг задлан шинжилж, бүтэц үгийн сан, найруулгын онцлогийг тодорхойлох

- Монголчууд яагаад
“Юманд учир
Суманд занги
Өөд нь хаясан чулуу
Өөрийн толгой дээр”
гэж хэлэлцдэг вэ? Эдгээр үгсийн утгыг тайлбарлаж, ярилцаарай.
- Та нар өглөө эрт босохын тулд ямар нэг арга хэрэглэж байсан уу? Туршиж үзсэн үр дүнтэй арга байгаа бол найзуудтайгаа хуваалцаарай.

Өглөө эрт босохын ач тус

Амжилтад хүрсэн хүмүүс эртэч, хичээнгүй байдаг. Тэдгээр хүмүүсийн амжилт гагцхүү өглөөний нартай уралдан босож, хийж бүтээх бүх ажлаа төлөвлөн биелүүлдэгт оршдог. (1)



Өглөө эрт босдог хүн хэзээ ч адгаж сандрахгүй амар тайван ажилладаг төдийгүй ухаалаг, идэвхтэй, хичээнгүй, юманд ул суурьтай тайвнаар ханддаг, өөрийгөө дайчлах чадвартай байдаг бол шөнө дөл хүртэл сэрүүн байдаг, өглөө аажуу босдог хүмүүс эмзэг, мэдрэмтгий, гутранги, тайван бус байдаг ажээ. Өглөө эртлэн босож сурснаар та эрүүл саруул урт наслах болно. Зүгээр л нэг урт удаан амьдрах биш харин үр бүтээлтэй, хойч үедээ хийж бүтээсэн зүйлтэй, утга учиртай урт насалдаг. Мөн зорилгоо биелүүлж амжилт гаргадаг. (2)

Өглөө эрт босож сурахад танд чин хүсэл эрмэлзэл, хичээнгүй зан чанар байхад л болно. Өглөө 6-8 цагийн хооронд хүний тархи хамгийн цэлмэг, сэргэг байдаг. Энэ үед анхаарал төвлөрүүлэх, шийдвэр гаргах чадвар нь өдрийнхөөс 3 дахин илүү байдаг. Энэ хугацаанд 1 цаг хичээл хийх буюу өөрийгөө сурах зүйлдээ дайчлах нь хамгийн үр дүнтэй. Хэрэв та өглөөний 5 цагт босож сурвал бусдаас 4 цаг хэмнэн хожиж байгаатай ижил юм. Амжилтад хүрсэн хүмүүс бүгд өглөөд "сэрүүн" байдаг. Энэ бол хариуцлага бөгөөд аливааг хийж гүйцэтгэе гэсэн халуун хүсэл, өрсөлдөх сэтгэлгээ зэргээрээ бусдаас ялгардаг удирдагч хүний онцлог юм. Тэд өглөөний нэг цаг өдрийн гурван цагтай тэнцдэг гэдэг нууцыг мэддэг байна. (3)

Байгаль бүх хүнд өдөрт 24 цагаас илүүг өгдөггүй. Эрх мэдэл болон мөнгөөр бусдын цагийг булааж бас худалдан авч чадахгүй. Тиймээс цагийг сайн зохицуулан удирддаг хүн л амьдралаа захиран залж чадах бөгөөд амжилт бүтээлтэй амьдралыг бүтээх болно. Та яг маргааш өглөөнөөс эрт босож эхлээрэй. Танд амжилт хүсье. (4)

(Хувь хүний хөгжлийн институт)

1. Эхийн утга санааг ойлгож ярилцъя.

а. Эхэд юуны тухай өгүүлсэн байна вэ?

б. Эхийн цогцолбор бүрийн утга санааг ярилцаж, зөв харгалзуулаарай.

Цогцолбор 1	А. Өглөө эрт босохын ач тусын тухай
Цогцолбор 2	Б. Амжилтад хүрсэн хүмүүс эргэч, хичээнгүй байдаг тухай
Цогцолбор 3	В. Цаг хугацааны үнэ цэнийн тухай
Цогцолбор 4	Г. Өглөө ажлын бүтээмж өндөр байдаг тухай


в. Эхийн гол санааг дүгнэн бичиж, ярилцаарай.

2. Шалтгаан, үр дагаврын холбоо хамаарлыг тодорхойлъя.

а. Эхийн шалтгаан, үр дагаврыг дараах асуултаар ярилцаарай.

- Эхэд амжилтад хүрсэн шалтгааныг ямар ямар баримтаар тайлбарласан байна вэ? Түүж бичээрэй.
- Амжилтад хүрэхэд юу юу чухал гэж тайлбарласан байна вэ?
- Хүн хичээл зүтгэл гаргасны үр дүнд юунд хүрдэг вэ? Түүнийг баталсан баримт эхэд байна уу? Хэрэв байхгүй бол өөрийн мэдэх алдартай хүмүүсийн жишээгээр баяжуулан ярилцаарай.
- Амжилт гаргахын тулд гаргасан хичээл зүтгэл ямар үр дагаварт хүргэв? Хэрэв эрт босож чадаагүй бол үр дагавар нь ямар болох байсан бэ? Энэ талаар бусадтайгаа саналаа солилцоорой.

б. Эх дэх шалтгаан, үр дагаврын холбоог гаргасан дараах бүдүүвчийг ажиглаад, дүгнэлт гаргаарай.



в. Шалтгаан, үр дагаврын холбоо хамаарлын тухай дараах мэдээллийг уншиж, жишээгээр батлан, ярилцаарай.

Шалтгаан	Үр дагавар
Аливаа юм, үзэгдэл, үйл явдал бий болох урьдчилсан нөхцөл, түлхэх хүчийг шалтгаан гэнэ.	Шалтгаанаас үүдэж бий болсон юм, үзэгдэл, үйл хэргийг үр дагавар гэнэ. Үр дагавар нь сайн, муу аль ч байж болно.


г. Дээрх эхийг 40-50 үгэнд багтаан хурааж бичээрэй. Бичихдээ:

- “Эрт босох нь амжилтын үндэс” гэсэн гол санааг өөрчлөхгүй.
- Эрт босох шалтгаан, түүнээс гарах үр дагаврыг тодорхой тайлбарлана.
- Зөв бичих дүрмийн болон найруулгын алдаагүй байна.

д. Дараах мэдээллийг уншаад, “Өглөө эрт босохын ач тус” эхэд шалтгаан ба үр дагаврыг цогцолборын хаана байрлуулсныг олоорой.

Зарим эхэд эхлээд шалтгаан, дараа нь үр дагаврыг тайлбарладаг. Заримд нь эхлээд үр дагавар, дараа нь шалтгааныг бичих нь бий. Бас үр дагаврыг нь эхэнд бичээд, шалтгааныг нь цогцолборын төгсгөлд тодорхойлсон ч байдаг.

е. Дараах бүдүүвч болон жишээг харьцуулан ярилцаарай.




- Дээрх жишээнээс санаа авч загвар бүрд тохирсон жишээ гаргаж, ярилцаарай.

Загвар 1. шалтгаан → үр дагавар

Загвар 2. үр дагавар → шалтгаан

Загвар 3. шалтгаан → үр дагавар → шалтгаан → үр дагавар




ё. Дараах асуултад хариулж, шалтгаан үр дагаврын холбоо хамаарлын тухай ойлголтоо бататгаарай.

- Хоёр мэдээг уншиж, шалтгаан, үр дагаврыг тодорхойлж харьцуулаарай.

Ихэнх нутгаар гурав хоног орсон зүс бороо ган тайлж, хүн малын зоо тэнийлээ.	Улаанбаатарт усархаг, аадар бороо орсны улмаас үер болж, хэд хэдэн зам, гүүр эвдэрчээ.
--	--

- Харьцуулснаа дүгнэж, ярилцаарай.
- Дараах өгүүлбэрийг дэлгэрүүлж, тохирох шалтгаан, үр дагаврыг гүйцээж бичээрэй.



3. Эхийн агуулга, бүтцийг шинжилье.

Яаж эртэч хүн болох вэ?

"Олон хүн надаас яаж эрт босох вэ? Туршлагаасаа хуваалцаач" гэж хүссэн учраас өөрийн олж мэдсэн хэдэн зүйлийг зөвлөө.




1. *Өглөө босдог цагаасаа бага багаар 5, 10, 15 минутын өмнө сэрүүлгээ тавь.* Босохоор төлөвлөсөн тэр цагаа өдөр болгон минут минутаар ахиулаарай.
2. *Эрт унт.* Өглөө эрт босох дадалд суралцах хугацаанд орой унтах цаг чинь хэвээр байвал бие чинь дийлэхгүй, өдөржин манарч, нойр хүрч, ядрах учир зорилгоосоо ухрах талтай. Тиймээс өглөө хэдэн минутын өмнө сэрсэн яг тэр хугацаагаараа унтах цагаа урагшлуулж, эрт унтахыг бодоорой.
3. *Сэрүүлэгтэй цагаа орноосоо хол тавьж, сэргэнгүүтээ шууд босож унтраа.*
4. *Бүрэн гүйцэд сэр.* Сэрүүлгээ унтраангуугаа шууд нүүр гар, шүдээ угаах эсвэл сайхан цоглог дуу сонсож, өөрийгөө бүрэн сэрээгээрэй.
5. *Нойр хүрч байна гэж битгий бод.* Нойр хүрч байна, орондоо буцаад орох юм сан, ядарч байна, муу унтлаа, дэндүү эрт юм гэх мэтээр битгий бод. Ингэж бодоод байвал эрт босож сурахгүй.
6. *Эрт босох чухал шалтгаантай бол.* Эрт босох шалтгаан чинь юу вэ?, Яагаад эрт босох болов? хэмээн эргэцүүлээрэй. Мөн эрт боссон тэр

1. хугацаандаа юу хийхээ төлөвлөсөн байх нь маш чухал. Түүнийгээ хий! Үр дүнгээ хараад, улам их урам зориг орж, урагш ахих болно. Эрт боссон тэр цагаа ашиглаж чадаагүй, ач тусыг нь мэдрээгүй бол эрт босох нь дэмий мэт санагдаж, бууж өгөх болно.
2. *Эрт босох гайхамшигийг өөртөө мэдрүүл.* Өглөөний амттай унд бэлтгэх, мандах нарыг харах, дасгал хийх, өдрийнхөө төлөвлөгөөг гаргах нь чамд хэмжээлшгүй их эрч хүч, баяр баясгаланг өгөх болно.

Хэрвээ энэ бүгдийг мөрдөж чадвал чи ЭРТЭЧ ХҮН болжээ!

а. *Дараах асуултад хариулж, агуулгыг шинжлээрэй.*



б. *Зохиогч зөвлөгөөний зарим хэсэгт учир шалтгааныг хэрхэн тайлбарласныг олж дараах асуултад хариулаарай.*

- Яагаад эрт унтах хэрэгтэй вэ?
- Ямар учраас бүрэн гүйцэд сэрэх хэрэгтэй вэ?
- “Нойр хурч байна гэж битгий бод” гэсний учир юу вэ?
- Зохиогч яагаад “Эрт босох шалтгаантай бол” гэж хэлсэн бэ?
- Яагаад “Эрт босохын гайхамшигийг өөртөө мэдрүүл” гэсэн бэ?

в. *Зохиогчийн тайлбарлаагүй дараах хэсэгт тохирох шалтгааныг өөрийн бодлоор тайлбарлаж бичнэ үү. Яагаад хэрэгтэй вэ? гэсэн асуулыг тавиад бодоорой.*


Зөвлөгөө	Шалтгааныг тайлбарлах
Өглөө босдог цагаасаа бага багаар 5, 10, 15 минутын өмнө сэрүүлгээ тавь. Босохоор төлөвлөсөн тэр цагаа өдөр болгон минут минутаар ахиулаарай.	
Сэрүүлэгтэй цагаа орноосоо хол тавьж, сэрэнгүүтээ шууд босож унтраа.	

г. *Зөвлөгөөнд учир шалтгааныг заавал тайлбарлах хэрэгтэй юү? Учир шалтгааныг нь тайлбарлахгүй бол хүмүүс дагаж мөрдөх үү? Ярилцаарай.*

д. *Зөвлөгөөний бүтцийг шинжилье.*


- Зөвлөгөөний нэр ямар утга санаа илэрхийлж байгааг тайлбарлаарай.
- Зөвлөгөөний бүтцийн хэсгүүдэд юуны тухай бичсэнийг тодорхойлоорой.

е. Дараах бүдүүвчийн дагуу зөвлөгөөний талаар ярилцаарай.



ё. Дараах бүдүүвчийг ашиглан зөвлөгөө бичээрэй. Бичихийн өмнө асуултын дагуу төлөвлөөрэй.

- Зөвлөгөөний нэр
- Зөвлөгөө бичих болсон шалтгаан
- Зөвлөх зүйлээ жагсаан тэдгээрийн шалтгааныг тайлбарлах
- Амжилт хүсэх



4. Асуудлыг шийдвэрлэхэд тохирсон зөвлөгөө өгье.

а. *Найздаа өгсөн зөвлөгөөг анхаарч уншаарай.*

Туяад тулгарсан асуудал

Би математикийн хичээл дээр тааруу дүн авсан. Аав ээждээ хэлж чадахгүй байна.



Хулангийн өгсөн зөвлөгөө

Хэрвээ би чиний оронд байсан бол аав ээждээ үнэнээ хэлэх байсан. Учир нь хэлэхгүй яваад байх тусам өөрт илүү хэцүү болно. Үнэнээ хэлбэл аав ээж чинь алдаагаа засахад тусалж магадгүй шүү дээ.

Чиний хувьд хэлэх зориг хүрэхгүй байгаа бол одооноос хичээж байгаад дараагийн удаа сайн дүн авчхаад хэлж болох юм. Тэгвэл тэд чамайг загнахгүй, харин ч магтах байх.

Бас аав ээждээ энэ тухайгаа хэлсэн бас итгэлийг нь алдаж, тааруу дүн авсандаа уучлал гуйсан захидал бичиж болно шүү дээ. Шууд хэлснээс илүү чамайг ойлгож уучлах байх гэж бодож байна.

Найз Хулан чинь

б. *Туяад тулгарсан асуудал, түүнд өгсөн Хулангийн зөвлөгөөг уншаад, дараах загварыг нөхнө үү.*



в. *Асуултын дагуу ярилцаарай.*

- Чиний хувьд Хулангийн зөвлөгөөнөөс аль шийдлийг сонгох вэ? Яагаад?
- Хулан зөвлөгөөндөө олон хувилбартай шийдлийг тусгасны учир юу вэ?

г. *Асуудлыг шийдвэрлэхэд тохирсон зөвлөгөө өгцгөөе.*

- Чамд ийм асуудал тулгарч байсан уу?
- Хэрэв тулгарч байсан бол чи яаж шийдвэрлэж байсан бэ?
- Ямар нэг шийдвэрлэхэд хэцүү асуудал тулгарахад чи хамгийн түрүүнд хэнд ханддаг вэ? Яагаад?

Зөвлөгөө өгөхдөө анхаарах зүйл

- ✓ Зөвлөгөө авч буй хүний талаас бодож, чин сэтгэлээсээ ойлгож туслахыг хичээх нь чухал.
- ✓ Зөвхөн би байсан бол гэж өөрийн бодлыг тулгахгүйгээр асуудлыг шийдэх боломжтой хэд хэдэн хувилбарыг санал болгоорой. Хамгийн гол нь тухайн шийдлүүдийн шалтгаан ба түүнээс гарах үр дүнг сайн тайлбарлаж ойлгуулна.
- ✓ Зөвлөгөө авч буй хүн заавал чиний зөвлөгөөг дагах шаардлагагүй тул өөрт таалагдсан хувилбараа сонгох эрхийг нь нээлттэй байлгах хэрэгтэй.

д. Дараах зааврын дагуу зөвлөгөө өгөөрэй.

- Тав, таваараа баг болоорой.
- Нэг сурагч өөрт тулгамдсан асуудлаа хэлнэ. Аль эсвэл дараах асуудлаас сонгож болно.

Гадаадад олон жил амьдарсан үеэл маань сарын дараа ирнэ. Хаагуур аялуулж, юу үзүүлбэл зүгээр вэ?

Аав ээж маань намайг хуульч мэргэжилтэй болгохыг хүсдэг. Харин би жүжигчин болмоор байна.



Ээжийн төрсөн өдөр удахгүй болно. Гэнэтийн бэлэг баримаар байдаг. Гэвч надад ямар ч санаа орж ирдэггүй ээ.

Би зуны амралтаараа ном уншихаар төлөвлөсөн. Ямар ном сонгохоо мэдэхгүй байна.

- Үлдсэн дөрвөн сурагч дараах загварын дагуу найздаа зөвлөгөө өгнө.
- Сурагч бүр нэг удаа зөвлөгөө авч, 4 найздаа зөвлөгөө өгсөн байна.
- Зөвлөгөө өгөхдөө дараах загварын дагуу бичиж төлөвлөнө.

Асуудал:

Зөвлөгөө өгөхдөө:

Хэрвээ би чиний оронд байсан болучраас
.....тэгэх байсан.

Харин чиний хувьд учраас
.....хэрэгтэй гэж бодож байна.

Яагаад болохгүй гэж. Учир нь ...
.....

Өгүүлбэрийг шалтгааны утгаар холбож найруулах

а. Дараах өгүүлбэрийг уншаад, тохирох өгүүлбэрээр гүйцээж бичээрэй.

- Өөрийн бичсэн өгүүлбэрийг тайлбарлаж, бусдын бичсэнтэй харьцуулан ярилцаарай.
- Эдгээр холбоос нь ямар утга илэрхийлж байгааг тайлбарлаарай.



б. Монголчуудын эрт дээр үеэс уламжилж ирсэн эрхэмлэн дээдлэх ёс болон цээрлэх ёсны шалтгааныг тайлбарлан бичээрэй. Бичихдээ:

- Тухайн зүйлсийг дээдлэх болон цээрлэх болсон шалтгааныг харгалзуулах
- Шалтгааны утгат (-учраас, -тулд) гэх мэт холбоосыг оновчтой сонгон найруулах

Ёс уламжлал	Шалтгаан
1. Бидний өвөг дээдэс усыг чандмань эрдэнэ хэмээн дээдэлдэг.	А. Гал голомт ариун дагшин байх учиртай гэж үздэг.
2. Монголчууд мандах төрийн малгай, бүтэх төрийн бүс хэмээн эрхэмлэн дээдэлдэг.	Б. Хүслийг хангагч эрдэнэ, эр хүний дотно нөхөр, наадам цэнгэлийн бахархал хэмээн ойлгодог.
3. Монгол хүн адууг эрхэмлэн дээдэлдэг.	В. Амьдралыг тэтгэгч ариун зүйл хэмээн үздэг.
4. Алс аян замд яваа хүн босоо зогсож цай ууж, идээ амсахыг цээрлэнэ.	Г. Уруугаа харсан савтай адилтган, буян хишиг нь асарна гэж үздэг.
5. Галд хог новш, элдэв муу зүйл хийхийг чандлан цээрлэнэ.	Д. Аян замд саад тотгор, гай барцад тохионо хэмээдэг.
6. Хүнд малгай бэлэглэхийг цээрлэнэ.	Е. Хүний сүлд хийморь шингэсэн байдаг.

в. Бичсэн өгүүлбэрээ солилцон уншиж, ялгааг ярилцаарай.

Албан бичгийн тогтсон бүтэц загварын дагуу учир шалтгааны холбоо хамаарлыг гаргаж бичих

1. Зөвлөгөө өгсөн захиа бичих аргыг мэдье.

а. Ангийн охин Хулан та нараас тусламж хүсэж, энэхүү захиаг илгээжээ. Хуланд тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд зөвлөгөө өгч, хариу захиа бичээрэй.

Сайн байцгаана уу? Найзууд аа

Би энэ улирлаас бүжгийн дугуйланд явж эхэлснийг та нар мэдэж байгаа. Ирэх сард сургуулиудын дунд бүжгийн аварга шалгаруулах тэмцээн болно. Тэр тэмцээнд орохын тулд өдөр болгон бэлтгэл хийгээд, ойрд хичээлээ сайн давтаж чадаагүй. Түүнээс болж сурлагын амжилт маань буурсан. Аав ээж маань чамд бүжгээс илүү хичээл чинь чухал гээд дугуйлангаасаа гарахыг шаардах боллоо.

Би бүжиглэх үнэхээр дуртай. Энэ тэмцээнд орж, өөрийнхөө авьяасыг соримоор байна. Аав ээждээ яаж ойлгуулах вэ? Надад туслаач.

Зөвлөгөө хүссэн: Ангийн найз Хулан

б. Дараах асуултад хариулж бичээрэй.

- Хуланд ямар асуудал тулгарсан байна вэ?
- Тэр асуудал тулгарах болсон шалтгаан нь юу вэ? Бүдүүвчээр харуулаарай.
- Захиагаа яаж эхэлсэн байна вэ?
- Захианы гол хэсэгт юуны тухай бичсэн байна вэ?
- Захианы төгсгөлд юуны тухай бичсэн байна вэ?
- Захиагаа ямар өнгө аясаар бичсэн байна вэ?

2. Учир шалтгааныг тайлбарлан зөвлөсөн захиа бичье.

а. Хуланд бичих хариу захиагаа төлөвлөөрэй.

Асуулт	Хариулт	Бичихдээ юуг анхаарах вэ?
Хэнд хандаж бичих вэ?	Хуланд	Хулангийн зан ааш, сэтгэл зүйн онцлогийг эргэцүүлэн бодно.
Ямар зорилгоор бичих вэ?	Асуудлыг шийдвэрлэхэд тохирсон зөвлөгөө өгөх	- Асуудлаа тодорхойлж, түүнийг шийдвэрлэх ямар арга зам байж болохыг эргэцүүлнэ. - Найзынхаа оронд өөрийгөө тавьж үзээд, юу гэж зөвлөвөл үр дүнтэй байх талаар эргэцүүлэн бодно. - Сонгосон арга чинь Хулангийн зан чанарт тохирох эсэх талаар дахин сайн бодно.
Ямар хэлбэрээр бичих вэ?	Хариу захиа	- Захианы бүтцийг эргэн санана. - Мэндчилгээгээр эхэлнэ. - Захианы зорилгоо бичнэ. - Асуудлыг хэрхэн шийдэж болох арга замуудыг зөвлөнө. - Амжилт хүсэж төгсгөөд, нэрээ бичнэ.

б. Төлөвлөгөөний дагуу найздаа зөвлөсөн захиа бичье. Тэгэхдээ дараах шалгуурт нийцүүлээрэй.

- Үзэл бодлоо тулгалгүй санал болгосон, зөвлөсөн байдлаар бичнэ.
- Өөдрөг, урам зориг өгөхүйц үг хэллэг хэрэглэнэ.
- Хоёрдугаар биед хандаж бичнэ. (та, чи)
- Асуудлыг шийдвэрлэх арга замаа бичнэ. Шаардлагатай хэсэгт учир шалтгаан болон үр дагаврыг тайлбарлаж бичсэн байна.
- Зөв бичих дүрмийн ба найруулгын алдаа гаргахгүй.

в. Туяагийн бичсэн хариу захиаг уншиж ярилцаарай.

Сайн уу? Хулан

Чиний захиаг хүлээн авлаа. Чи бүжгийн тэмцээнд орох хүсэлтэй байгаагаа ээж аавдаа ойлгуулж чадахгүй байгаа юм байна.

Миний бодлоор, чиний сурлагын амжилт буурч байгаад аав ээж чинь санаа зовж, дугуйлангаасаа гар гэсэн байна. Тиймээс сурлагаа сайжруулчихвал ингэж шаардахгүй байх.

Чи зөвхөн бүжгээ л чухалчилж, хичээлээ анхаарахаа больсон байна. Чиний амьдралд хүсэл сонирхол, хичээл сурлага аль аль нь чухал учраас цагаа зөв хуваарилан, хоёуланд нь амжилт гаргахыг зорих хэрэгтэй. Хэрвээ тэгж чадвал аав ээж чинь чамайг ойлгох төдийгүй авьяаслаг, сурлага сайтай охиноороо бахархана гэдэгт эргэлзэхгүй байна.

Удахгүй бүжгийн тэмцээн чинь болох гэж байгаа учир эхлээд бүжиг болон хичээлдээ хоёуланд нь амжилт гаргаж чадна гэдгээ аав ээждээ хэлж ойлгуулаарай. Харин өнөөдрөөс эхлэн хэлсэндээ хүрээрэй. Амжилт хүсье.

Найз Туяагаас чинь

г. Дараах шалгуураар найзынхаа бичсэн захиаг үнэлээрэй.

Сайн ● Дунд ■ Тааруу ▲

№	Шалгуур	Үнэлгээ	Үнэлгээний тайлбар
1	Хуланд тулгарсан асуудлыг тодорхойлж чадсан уу?		
2	Асуудлыг шийдэхэд тохирох арга замыг зөвлөсөн үү?		
3	Шалтгаан, үр дагаврыг тодорхой тайлбарласан уу?		
4	Өөдрөг, урам зориг өгсөн үг хэллэг хэрэглэсэн үү?		
5	Үзэл бодлоо тулгалгүй санал болгож, зөвлөсөн өнгө аясаар бичсэн үү?		
6	Захианы бүтцийн дагуу бичсэн үү?		
7	Зөв бичих дүрмийн болон найруулгын алдаагүй бичсэн үү?		

д. Дунд болон тааруу үнэлгээ өгсөн хэсгүүдээ хэрхэн сайжруулж болох талаар ярилцаж, засаж бичээрэй.

3. Шалтгааныг тодорхой тайлбарлаж, зөвлөсөн захиа бичье.

а. Баяраагийн захиаг уншаад, түүнд тулгарсан асуудлыг тодорхойлно уу.

Сайн байна уу?

Би өчигдөр нийгмийн ухааны хичээл дээр илтгэл тавьсан. Уул нь илтгэлээ бүтэн 14 хоногийн турш их л хичээж бэлтгэсэн. Гэвч ангийнхны өмнө гараад илтгэх гэтэл хамаг бие чичирч сандраад, бичсэн зүйлээ бүгдийг нь хараад уншчихсан.

Багш надад илтгэлээ сайн бэлтгээд, дараагийн хичээл дээр дахин илтгэх боломж олгосон. Би олон хүний өмнө гарахаараа л сандарч, амнаас үг гарахаа больчихдог юм. Энэ дутагдлаа яаж засах вэ? Илтгэлээ яаж өөртөө итгэлтэй танилцуулах вэ? Надад зөвлөгөө өгөөч.

Баяраа

б. Баярааг бусдын өмнө өөртөө итгэлтэй ярьж сурахад нь тохирсон зөвлөгөө өгөөрэй.

в. Захианыхаа бүтцийг дараах дарааллаар төлөвлөнө үү.

- Хэнд хандаж бичих вэ?
- Ямар зорилгоор бичих вэ?
- Зорилгодоо тохирсон мэдээлэл цуглуулах
- Захианы бүтцээ гаргах

Захиагаа яаж эхлэх вэ?

Захианы гол хэсэгт юуны тухай бичих вэ?

Захианы төгсгөлд юуны тухай бичих вэ?

г. Зөвлөсөн захиагаа бичихдээ дараах санааг тусгаарай.

- Найздаа тулгарсан асуудлыг юу гэж бодож байгаагаа
- Олон өдрийн хичээл зүтгэл нь талаар болсныг чи юу гэж бодсоноо
- Найздаа бусдын өмнө итгэлтэй ярьж сурахад юуг онцолж зөвлөмөөр байгаагаа

САНАМЖ

Бичихдээ дараах санамжийг баримтлаарай.

- ✓ Бичихдээ чин сэтгэлийн үгээр бичнэ.
- ✓ Найздаа итгэл төрүүлэхүйц хамгийн чухал үнэн бодитой мэдээлэл ашиглаж, учир шалтгааныг тайлбарлаж бичнэ.
- ✓ Өгсөн зөвлөгөө тань найзын чинь онцлогт тохирсон, хэрэгжүүлж болохуйц байхыг анхаарна.
- ✓ Найзаараа бахархсан, түүнийг дэмжиж магтсан, урам зориг өгсөн гэх мэт өнгө аясаар бичнэ.
- ✓ Захианы бүтцийн дагуу бичнэ.
- ✓ Найруулгын болон зөв бичгийн дүрмийн алдаа гаргалгүй бичнэ.

4. Өргөдлийн агуулга, бүтэц, хэл найруулгыг судалъя.

а. Дараах хоёр өргөдлийг уншаад, утгыг ярилцаарай.

Өргөдөл 1.

*Орхон аймаг дахь Улаан Загалмайн Нийгэмлэгийн захирал
Б.Батжаргал танаа өргөдөл гаргах учир нь*

Батсуурь овогтой Төгсбаяр миний бие Орхон аймгийн 5 дугаар дунд сургуулийн 9 дүгээр ангид сурдаг.

Танай байгууллагаас хэрэгжүүлж буй “Олон Улсын Найрамдал-IV төсөл”-ийн хүрээнд “Хөдөөгийн сургуульд суурилсан ариун цэвэр ба гамшгийн өмнөх бэлтгэл” гэсэн чиглэлээр орон нутгийн сургуулийн сурагчдын эрүүл ахуйн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх, гамшгийн талаарх тэдний ерөнхий мэдлэгийг нэмэгдүүлэн, хариу үйлдэл үзүүлэх дадлага олгох сайн дурын ажилд оролцох хүсэлтэй байна.

Би сургууль, амьдарч буй орчиндоо тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах хүсэлтэй төдийгүй түүгээр дамжуулан, өөрийгөө нээж хөгжүүлэхийг эрмэлздэг. Энэ нь дээрх төслийн зорилго чиглэлтэй нийцэж байгаа бөгөөд дунд сургуулиа төгсөөд, гадаадын их дээд сургуульд тэтгэлэгтэй суралцахад чухал үзүүлэлт болж чадна. Би энэхүү төсөлд хамрагдвал идэвх зүтгэлтэй, хариуцлагатай, чин сэтгэлээсээ хандаж ажиллах болно.

Тиймээс миний зорилго, хүсэл эрмэлзлийг үндэслэн, төслийн сайн дурын ажилтнаар ажиллуулж өгнө үү.

*Өргөдөл гаргасан: Орхон аймгийн Баян-Өндөр сумын
5 дугаар сургуулийн 9в ангийн сурагч Батсуурь овогтой Төгсбаяр
Утас: 95522341*

2015 оны 2 дугаар сарын 16

Өргөдөл 2.

*Чингэлтэй дүүргийн 24 дүгээр сургуулийн
захиргаанд өргөдөл гаргах учир нь*

Бадарч овогтой Ариунзаяа миний бие тус сургуулийн 8б ангид суралцдаг. Чөлөөт цагаараа Монголын Хүүхдийн Ордны төгөлдөр хуурын дугуйланд явдаг.

Би саяхан болсон төгөлдөр хуурчдын улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцон, мөнгөн медаль хүртэн, улмаар энэ сарын 24-29-ний өдрүүдэд Италийн Веска хотод зохион байгуулагдах олон улсын өсвөрийн төгөлдөр хуурчдын тэмцээнд оролцох эрх авсан билээ.


Тиймээс энэ тэмцээнд оролцох боломж олгон, 11-р сарын 21-31-ний өдрийг хүртэл 10 хоногийн чөлөө олгоно уу.

*Өргөдөл гаргасан: ЧД-ийн 24-р сургуулийн
8б ангийн сурагч Б.Ариунзаяа*


2017. 11. 17

б. Өргөдлийн агуулгыг харьцуулаарай.

- Дээрх хоёр өргөдлийг хэнд хандаж бичсэн байна вэ? Нөхөж бичээрэй.



- Өргөдлүүдийг ямар зорилгоор бичсэн байна вэ?
- Өргөдлийн эхлэл гол, төгсгөл хэсэгт юуны тухай бичсэн байна вэ?



- Өргөдөл гаргагч нь өргөдлийн төгсгөлд өөртэй холбоотой ямар, ямар мэдээллийг бичсэн байна вэ?

Өргөдөл 1:

Өргөдөл 2:

- Өмнө хийсэн даалгавраа эргэн санаж, өргөдлийг ямар агуулгатай бичдэг талаар жишээ татан, дүгнэж ярилцаарай.

в. Өргөдлийн бүтцийг судлаарай.

- Өргөдлийн хэсгүүдийг зөв дараалуулан, тоогоор тэмдэглээрэй.

	Өргөдөл бичих болсон учир шалтгаан буюу агуулга
	Явуулагчийн хаяг, албан тушаал, гарын үсэг
	Хүлээн авагч байгууллага, хүний нэр бүхий өргөдлийн толгой
	Он, сар, өдөр

- Өргөдлийн хэмжээ ямар байх ёстой вэ? Хоёр өргөдлийг харьцуулан, дүгнэлт хийгээрэй.

г. Өргөдлийн хэл найруулгыг шинжлээрэй.

- Өргөдлийг ямар өнгө аясаар бичсэн байна вэ? (гуйсан, шаардсан, энгийн хүүрнэсэн, тушаасан, учирласан гэх мэт)
- Энгийн, ойлгомжтой үг хэллэг сонгосон байгаа нь ямар учиртай вэ?
- Өргөдөл гаргах шалтгаан ба хүсэж буй зүйлээ илэрхийлэхдээ гол төлөв ямар холбох үг ашигласныг олж тайлбарлаарай.

д. *Өргөдлийн тухай дараах мэдээллийг уншиж, ярилцаарай.*

Өргөдөл

Хувь хүнээс асуудал шийдэх мэдэл бүхий албан газар, албан тушаалтанд хувийн хүсэлтээ бичин, өргөж барьсан албан бичгийг “өргөдөл” гэнэ. Бичиж байгаа зүйлийн агуулгаас хамааран, албаны үг хэллэгээс гадна мэргэжлийн үг хэллэг, нэр томьёо нэлээд ордог.

Өргөдлийн эхэнд харилцахыг хүссэн албан газар, албан тушаалтны нэрийн ард “танаа” гээд дараах мөрийг голлуулан, “өргөдөл гаргах учир нь” гэж бичсэнийг “өргөдлийн толгой” гэдэг.

Өргөдлийн эхлэл хэсэгт өөрийн (өөрсдийн) тухай товч тодорхой танилцуулаад, дараа нь уг хүсэлтийг шийдэхэд холбогдох зүйлийг бичиж, төгсгөлд юуг хэрхэн шийдүүлэхийг хүсэж байгаагаа бичдэг. Өргөдлийн дор “өргөдөл гаргасан” гээд ажлын болон гэрийн хаяг, овог нэр, он сар, өдөр, шаардлагатай гэж үзвэл утасны дугаараа бичнэ.

Өргөдлийн бүтэц:

- Хүлээн авагч байгууллага, хүний нэр бүхий өргөдлийн толгой
- Өргөдөл бичих болсон учир шалтгаан буюу агуулга
- Явуулагчийн хаяг, албан тушаал, гарын үсэг
- Он, сар, өдөр гэсэн дараалалтай байна.

Өргөдлийн утга агуулга нь янз бүр байдаг бөгөөд бичсэн зүйлийн агуулгаас хамааран хэмжээ нь ямар ч байж болно. Харин өгүүлсэн баримт нь үнэн, дэс дараа сайтай, нуршуу биш, ойлгомжтой, юу хүссэн нь тодорхой байх ёстой.

2. Тогтсон бүтэц, загварын дагуу өргөдөл бичье.

а. *Өргөдөл бичих асуудлаа тодорхойлоорой.*

Танай ангийнхан хичээлээс гадуурх ажлын хүрээнд сурагч, эцэг эхчүүдийн хамтарсан хөгжөөнт тэмцээн зохиохоор болжээ. Тэмцээн зохион байгуулахын тулд сургалтын менежерээсээ спорт заалыг нэг өдөр ашиглах зөвшөөрөл хүсэж өргөдөл бичих болов.

- Өргөдлөө хэнд хандаж, ямар зорилгоор бичихээ тодорхойлоорой.

б. *Өргөдлийн бүтцээ төлөвлөнө үү.*

Өргөдлийн
толгой хэсэг

... сургуулийн сургалтын менежер танаа

Өргөдлийн
агуулга


- эхлэл: өөрийн товч танилцуулга
- гол: тэмцээн зохиох гэж байгаа тухай
- төгсгөл хэсэгт: спорт заалыг нэг өдөр ашиглах эрх хүсэх

Төгсгөл

нэр, хаяг, утас

в. Өргөдлөө бичээрэй.

Өргөдөл бол тогтсон загвартай албан бичиг учраас тодорхой стандартын дагуу бичдэг. Өргөдлийг А4 хэмжээний бичгийн цаасан дээр дараах хэмжээг баримтлан бичнэ.



г. Дээрх асуудлаар бичсэн дараах 2 өргөдлийг шалгуурын дагуу үнэлээрэй.

*Сургалтын менежер Ц.Наранцэцэг танаа
өргөдөл гаргах учир нь:*

Тус сургуулийн 8а ангийн сурагчид жил бүр уламжлал болгон явуулдаг эцэг эх, сурагчдын хамтарсан тэмцээнээ энэ долоо хоногийн бямба гарагт зохион байгуулахаар төлөвлөж байна.

Энэхүү тэмцээн нь гар бөмбөг, сагсан бөмбөг, хөгжөөнт тоглоом гэсэн төрлөөс бүрдэх тул заавал спорт зааланд зохион байгуулах шаардлага тулгараад байна.

Тиймээс бидэнд эцэг эхтэйгээ нэг өдрийг хөгжилтэй өнгөрөөх боломж олгон, сургуулийн спорт зааланд тэмцээн зохион байгуулах зөвшөөрөл олгоно уу.

Өргөдөл гаргасан: Арвайхээр хотын 2-р сургуулийн
8а ангийн сурагч Б.Батжаргал
Утас: 80551221

2017.4.25

*Биеийн тамирын багш Б.Алтангэрэлд:
Асуудлыг өргөдөл ёсоор шийдье.*

*Сургалтын менежер Ц.Наранцэцэг
2017.4.28*

*Сургалтын менежер Ц.Наранцэцэг танаа
өргөдөл гаргах учир нь:*

Хашбат овогтой Жаргалан миний бие тус сургуулийн 86 ангид суралцдаг. Манай ангийнхан энэ долоо хоногийн бямба гарагт эцэг эх, сурагчдын хамтарсан тэмцээн зохион байгуулах гэж байна. Энэхүү тэмцээнийг зохион байгуулахад биеийн тамирын заал шаардлагатай байна.

Тиймээс бидэнд сургуулийн спорт зааланд тэмцээн зохион байгуулах зөвшөөрөл олгоно уу.

Өргөдөл гаргасан: Арвайхээр хотын 2-р сургуулийн
86 ангийн сурагч Х.Жаргалан
2017.4.25

*Сургуулийн биеийн тамирын заалыг
ашиглуулах боломжгүй. Сургалтын
менежер Ц.Наранцэцэг
2017.4.28*

д. Бичсэн өргөдлөө үнэлж сайжруулаарай.

- Шалгуур бүрийн ард тохирох үнэлгээг тавьж, яагаад ийм үнэлгээ өгснөө тодорхой жишээгээр тайлбарлаарай.

Шалгуур	Өргөдөл 1	Өргөдөл 2
Хандаж буй албан байгууллага, албан тушаалтнаа тодорхой бичсэн үү?		
Өөрийн тухай товч танилцуулсан уу?		
Өргөдөл гаргах болсон шалтгаан, нөхцөлөө тодорхой бичсэн үү?		
Хүсэлт гаргасан асуудлыг яаж шийдүүлэхээ тодорхой бичсэн үү?		
Өөрийн овог, нэр, хаяг, утсаа бичсэн үү?		
Өргөдөл гаргасан он, сар, өдрөө бичсэн үү?		
Өргөдлийн стандартыг баримталж, А4 цаасан дээр гараар бичсэн үү?		
Өргөдлийн бүтцийн дагуу догол мөр гаргаж бичсэн үү?		
Албаны өнгө аясаар бичсэн үү?		
Зөв бичих дүрмийн алдаа гаргасан уу?		
Найруулга зүйн алдаа гаргасан уу?		
Үнэлгээ: Сайн ● Дунд ■ Тааруу ▲		

- Хоёр өргөдөлд өгсөн үнэлгээгээ харьцуулан дүгнээрэй.

- Өргөдлийг шийдсэн сургалтын менежерийн цохолтыг уншиж, яагаад тийм шийдвэр гаргасныг баримтаар батлан, тайлбарлаарай.
- Дээрх хоёр өргөдөлд дунд болон тааруу үнэлгээ өгсөн хэсгүүдээ яаж сайжруулж болох талаар ярилцаарай.
- Ярилцсаны дагуу сайжруулж бичээрэй.

3. Бие дааж өргөдөл бичье.

а. Дараах жагсаалтаас өргөдөл бичих асуудлаа сонгоё.



б. Сонгосон асуудлын дагуу бичих өргөдлийг төлөвлөе.

Хэнд хандаж бичих вэ?
Ямар зорилгоор бичих вэ?
Ямар шалтгаан, нөхцөл байдал үүссэн бэ?
Асуудлыг яаж шийдүүлэх вэ?
Өргөдөл гаргасан:

в. Өргөдлөө төлөвлөгөөний дагуу А4 цаасан дээр гараар бичнэ үү. Дараах шалгуурыг баримтлаарай.

- ✓ Өргөдөл бичихдээ стандарт хэмжээний дагуу зайгаа тохируулах
- ✓ Эхлэл, гол, төгсгөл хэсгээ ялган догол мөр гарган бичих
- ✓ Өргөдөл гаргах болсон шалтгаан болон шийдүүлэх гэж байгаа хүсэлтээ тодорхой бичих
- ✓ Өөрийн овог, нэр, хаяг, утсаа бичих
- ✓ Өргөдөл гаргасан он, сар, өдөр
- ✓ Зөв бичих дүрмийн болон найруулгын алдаагүй, гаргацтай бичих

г. Бичсэн өргөдлөө өмнөх шалгуураар үнэлж, сайжруулж бичээрэй.

Өөрийгөө сорьё

1. Дараах мэдээллийг уншиж, даалгаврыг гүйцэтгээрэй.

Эрүүл, аюулгүй хоол хүнсний таван түлхүүр

Яах вэ?	Яагаад?
Цэвэр байлга.	Нүдэнд үзэгдэхгүй, өвчин үүсгэгч бичил биетүүд нь бохир гар, алчуур, хувцас, багаж хэрэгсэл орчноор дамжин, хоол хүнсийг бохирдуулдаг.
Чанаж болгосон болон болгоогүй хүнсийг тус тусад нь хадгал.	Хүнс бэлтгэх, хадгалах явцад түүхий мах, загас, тахиа шувууны мах зэргийг хамт байлгавал тэдгээрийн шүүсэнд агуулагддаг бичил биетүүд холилдож бохирдоно.
Хоол хүнсийг гүйцэд чана.	Хоол хүнсийг гүйцэд чанаснаар бүх аюултай бичил биет устдаг. Хоол хүнсийг 70-аас багагүй хэмд чанаж хэрэглэх нь хамгийн найдвартай байдаг.
Хоол хүнсийг зохих хэмд хадгал.	Бичил биетүүд нь 5-60 хэмд идэвхтэй үржиж, хор ялгаруулдаг учраас хоол хүнсийг тасалгааны хэмд хадгалж болохгүй. Зарим бичил биет нь хөргөгчний хэм (5°C-аас ихгүй)-д ч үржих чадвартай.
Аюулгүй ундны ус, хүнсний түүхий эдийг сонго.	Аливаа хүнсний түүхий эд нь химийн бодист бохирдсон байж болох учир заавал угааж хэрэглэнэ.

а. Дээрх эхийн өгүүлбэрүүдийг “- тулд, -учраас, - болохоор, -улмаар, үүнээс үүдэн, үүний үр дүнд” гэх мэт шалтгааны утгат холбоос ашиглан, найруулж бичээрэй. Жишээ нь:

Нүдэнд үл үзэгдэх өвчин үүсгэх бичил биетүүд бохир гараар дамжин хоол хүнсийг бохируулахаас **сэргийлэхийн тулд** бие зассаны дараа, хоол хүнс бэлдэх болон идэхийн өмнө гараа угаа.

б. Эхийн шалтгаан, үр дагаврын холбоо хамаарлыг илрүүлж, бүдүүвчээр үзүүлээрэй.
в. Дээрх мэдээллийг ашиглан, “Эрүүл аюулгүй хоол хүнс хэрэглэх” зөвлөгөө бичээрэй.

2. Дараах тохиолдлыг уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Сурагч Билгүүн 8-р ангид сурдаг. 10-р сард эрүүл мэндийн шалтгаанаар 7 хоногийн чөлөө авчээ. Энэ хугацаанд сургуулийн хичээлээс гадуурх дугуйлангууд сурагчдаа бүртгэж авсан байв. Билгүүн хичээлдээ ирээд шатрын дугуйланд явах хүсэлтэй байгаагаа багшдаа хэлсэн боловч бүртгэл дууссан, хүүхдийн тоо гүйцсэн тул тус дугуйланд оруулах боломжгүй гэжээ.

а. Хэнд хандаж, ямар асуудлаар өргөдөл гаргахаа төлөвлөөрэй.
б. Төлөвлөгөөний дагуу, тогтсон загварт нийцүүлэн өргөдөл бичээрэй.

Хатуу, зөөлний тэмдгийн дүрмийг давтах

1. Хатуу, зөөлний тэмдгийг ямар үүргээр хэрэглэдгийг эргэн саная.

а. Дараах үгсэд хатуу, зөөлний тэмдэг ямар үүргээр орсныг ажиглаад, тохирох хэсэгт ялгаж бичнэ үү.

эвлэрье, барья, бичье, харья, оролдьё, уулзья, барилдья, тоольё
өмөөрье, харья, үзүүлье, бодьё, оролдьё, баримталья, тусалья,
өрөвдьё, хуучилъя, уншъя, хүндэлье...

Тусгаарлах үүргээр орсон	Зөөлрүүлэх үүргээр орсон
эвлэрье...	барья...

б. Ангилсан үгсээ ажиглаад дараах асуултын дагуу дүгнэлт гаргая.

- Хатуугийн тэмдэг ямар үгэнд, ямар үүргээр орж байна вэ?
- Зөөлний тэмдэг ямар үед тусгаарлах үүрэгтэй, ямар үед зөөлрүүлэх үүрэгтэй орж байна вэ?

2. Зөөлний тэмдэг “и” болох, болохгүй тохиолдлыг дүгнэе.

а. Бүтээврийн нийлц ба үгсийг ажиглаад, зөөлний тэмдэг ямар үед “и” болж байгааг дүрэм болгон бичээрэй. Бичихдээ:

- Бүтээвэр залгаж байгаа үгийн үндсийн зөөлний тэмдгийн өмнөх гийгүүлэгч эгшигт болон заримдаг гийгүүлэгчийн аль болох
- Үгийн үндсэнд залгаж байгаа бүтээвэр ямар үгсээр эхэлж байгааг сайн анхаараарай.

Зөөлний тэмдэг “и” болох тохиолдлууд

Бүтээврийн нийлц	Бүтсэн үг	Дүрэм
барь-мал барь-в барь-гд барь-нгаа	баримал барив баригд барингаа	
захь-цгаа захь-жээ захь-сан	захицгаа захижээ захисан	Зөөлөрсөн заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад “ь” нь “и” болно.
цохь-х тавь-х хумь-х	цохих тавих хумих	
соль-оод харь-аарай боль-ооч	солиод хариарай болиоч	

б. Дараах үгсийг бүтээврээр задалж, холбогдох дүрмийг тайлбарлаарай.

харилаа, тавина, болиорой, барилц, хорих, цохиж, захиад, болих

3. Зөөлний тэмдэг үл солигдох тохиолдлуудыг зөв хэрэглэе.


а. Дараах хэсгээс зөөлний тэмдэг хэвээр байх тохиолдлуудыг ярилцан, жишээ нэмж бичээрэй.

<ul style="list-style-type: none">барьцгаа, сольж, хумьдаг, урьчих	<ul style="list-style-type: none">харья, тавья, хольё, больё, сольё, хумья	<ul style="list-style-type: none">морьгүйДарьбазар
--	--	---

б. Өгүүлбэрүүд дэх тодруулсан үгсийн дүрмийг тайлбарлан ярилцаарай.

- Ач хүү Сумьяаг “Энэ ямар эрдэмтэй аяга юм бэ?” гэж гайхан асуухад: Адьяа өвгөн “Хор **таньдаг** аяга” гэжээ.
- Эрхлэхийг нь **болиулья**. Эв нэгдлийг **дээдэлье**.
- Харьд** суугаа хүүдээ **аминчилж** хэлэх үгээ **хариу захидлаар уламжилъя**.
- Баримтаг** зохиолоос сэдэвлэн, уран сайхны кино хийхээр **зорьж** байгаагаа **танилцууллаа**.

в. Цэгийн оронд хатуу болон зөөлний тэмдгийн тохирохыг нөхөж, холбоо үг үүсгэж бичээрэй.



г. Хатуу болон зөөлний тэмдэг эр үгэнд ямар үүрэгтэй байгааг тайлбарлаарай.


д. Сурагчийн бичсэн захиагууниаад хатуу, зөөлний тэмдгийг буруухэрэглэсэн алдаатай үгсийг олж, засаж бичээрэй. Дүрмийн ямар алдаа гаргасныг тайлбарлаарай.

Сайн байна уу?

Хайрт найз чамдаа хүүхэд шуугиж, инээд цалгисан, шинэ хичээлийн жилийн баярын мэндийг хүргье. Чиний хувьд ирэх жил есдүгээр ангиа төгсөх учир энэ жил их хариуцлагатай байх болно. Тиймээс төлөвлөгөө гарган хуваарын дагуу ажлаа амжуулж сурах нь чухал шүү.

Найздаа сурлагын амжилт, сайн сайхан бүхнийг хүсэе.

Адьяасүрэнгээс чинь

**Эзэмших мэдлэг, чадвар**

Эхэд зохиогчийн ашигласан баримт,
мэдээллийг ялгаж, дүгнэх

Шалтгааны утгатай угсарсан нийлмэл
өгүүлбэрийн бүтсэн аргыг тодорхойлох

Жишээ баримт ашиглаж, дүрслэн
тайлбарлаж бичих

Уншсан эхэд зохиогчийн ашигласан баримт, мэдээллийг ялгаж, дүгнэх


1. Хоёр эхийг харьцуулан уншъя.

а. Телевиз, радиогоор мазаалай баавгайн тухай мэдээ сонсож, нэвтрүүлэг үзэж, сонин сэтгүүлээс энэ амьтны тухай мэдээллийг уншсан байх. Тийм бол дараах хүснэгтийн эхний хоёр баганын асуултад хариулж бичээрэй. Харин сүүлийн “Мэдсэн зүйл” баганыг энэ нэгж хичээлийн төгсгөлд нөхөж бичээрэй.

Миний мэддэг үйл	Мэдэхийг хүсэж байгаа зүйл	Мэдсэн зүйл

б. Дараах эхийг уншихдаа баримтыг ямар ямар хэлбэрээр тоочин бичсэнийг анхаарч уншаарай.

Мазаалай баавгайн тухай баримтууд*



The screenshot shows a Facebook post from the page "Их говийн эзэн Мазаалай баавгай". The post features a photo of a brown bear standing on a rocky outcrop. The text of the post is as follows:

Их говийн эзэн Мазаалай баавгай

Эхлэл

Тухай

Зураг

Нийтлэл

Олон нийт

Таалагдлаа Дагах Хуваалцах ...

Их говийн эзэн Мазаалай баавгай
2015 оны 5-р сарын 27

Мазаалай баавгайн тухай баримтууд:
Мазаалай нь говь цөлд амьдардаг дэлхийн цорын ганц баавгай бөгөөд зөвхөн Монголын говьд байдаг.
Мазаалайг анх 1920-иод оны эхээр баруун Алтайн нурууны Аж Богдод олж тогтоосон түүх бий.
Оросын эрдэмтэд болох Орлов, Соколов нар мазаалайг баавгайн бие даасан зүйл мөн гэж үзэн биологийн шинжлэх ухаанд бүртгүүлсэн.
Дэлхийн баавгай судлалын шинжлэх ухаанд мазаалайг "Ursus Arctos Gobiensis" гэж нэрлэдэг.
1953 онд АИХ -ын тэргүүлэгчдийн тогтоолоор мазаалайг дархан цаазтай амьтдын тоонд оруулж, агнахыг хуулиар хориглосон.
1960-аад оноос Монголын биологийн хүрээлэнгийнхэн мазаалайг анх судалж, тоолж ирсэн түүхтэй. Академич А.Болд нарын хүмүүс

1. Мазаалай нь говь цөлд амьдардаг дэлхийн цорын ганц баавгай бөгөөд зөвхөн Монголын говьд байдаг.
2. Мазаалайг анх 1920-оод оны эхээр баруун Алтайн нурууны Аж Богдод олж тогтоосон түүх бий.

* (https://www.facebook.com/permalink.php?story_fbid=578364742306176&id=578360098973307)

1. Оросын эрдэмтэн Орлов, Соколов нар мазаалайг баавгайн бие даасан зүйл мөн гэж үзэн, биологийн шинжлэх ухаанд бүртгүүлсэн.
 2. Дэлхийн баавгай судлалын шинжлэх ухаанд мазаалайг «Ursus Arctos Gobiensis» гэж нэрлэдэг.
 3. 1953 онд Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор мазаалайг дархан цаазтай амьтдын тоонд оруулж, агнахыг хуулиар хориглосон.
 4. 1960-аад оноос Монголын биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд мазаалайг анх судалж, тоолж ирсэн түүхтэй. Академич А.Болд нарын хүмүүс мазаалайн тоо толгойг гаргах судалгаа хийгээд, “Тэр үед 25-50 толгой мазаалай байжээ.” гэсэн дүгнэлтэд хүрчээ.
 5. Бие төрх, амьдрах байдал нь гүйцэд судлагдаагүй байсан энэ амьтныг 1966 онд анх удаа кино оператор О.Уртнасан кино зурагт авч, улмаар намнан авчирч, музейн үзмэр болгосон.
 6. “Улаан ном”-д бүртгэгдсэн байдлаас мазаалайн тоог харвал 1960-аад онд 15-20, 1970-аад онд 20 гаруй, 1980-аад оны эхээр 25-30, сүүлчээр 50-60 гэж тэмдэглэжээ. 1990 оны эхээр 30 гаруй толгой байсан байна. Мазаалай судлаачдын хамгийн сүүлд гаргасан мэдээгээр одоо 30 хүрэхгүй тоо толгой үлджээ.
 7. Мазаалай бажууны үндэс, зээргэнэ, хармаг жимс болон мэрэгч, хэвлээр явагч амьгад, хорхой шавжаар хооллодог. Түүний иддэг ургамал, шавж байгальд ховордсоноос мазаалай өлсөж үхэх болсон. Түүнийг аврахын тулд янз бүрийн тэжээл орлуулан тавьдаг ч хүний гараар бэлтгэсэн тэжээлд ам хүргэх нь ховор.
 8. Мазаалай угтаа махчин амьтан. Гэвч одоо малчдад бэлчээр нутгаа булаалгаж, цөл рүү шахагдсан учраас идэш тэжээлийнхээ 77 хувийг ургамал, 23 хувийг амьтны гаралтай бүтээгдэхүүнээр залгуулдаг.
 9. Зундаа +46 градус халж, өвөлдөө -34 градус хүртэл хүйтэрдэг газар мазаалай амьдардаг бөгөөд асар их уудам орон зайг эзэлдгээрээ бусад баавгайн зүйлээс ялгардаг.
 10. Холимог идэштэн, том махчин амьтны хувьд говийн ялангуяа баян бүрдийн биоценозид* орон зай, идэш тэжээлийн гинжин холбоонд тодорхой үүрэг гүйцэтгэдэг.
 11. Тоо толгой цөөн боловч ургамлын гаралтай идэш тэжээлээр зонхилон хооллож, ландшафтад* танигдахуйц ул мөр үлдээж, жижиг баян бүрдийг түшиж амьдрах тул экосистемд чухал ач холбогдолтой амьтан.
 12. Хөхтөн амьтдын сэг зэмээр хооллодог тул байгальд ариутгагчийн үүрэг гүйцэтгэдэг. Хөрсний ус ойр газарт малтаж, ус гаргадаг тул хавтгай зэрэг бусад хөхтөн амьтдыг усаар хангахад чухал үүрэгтэй.
 13. Мазаалайг хамгаалахын тулд мазаалайн байршил нутагт хүн мал оруулахгүй байх, байршил, тоо толгойн талаар мэдээлэх, агнаж хороохгүй байх талаар яриа, таниулга хийж ирсэн нь зохих үр дүнгээ өгч, сүүлийн 20 орчим жил зүй бусаар хорогдсон тохиолдол гараагүй байна.
- в. *Дараах асуултад хариулаарай.*
- “Зээргэнэ, бажууна, хармаг” зэрэг үгсийн утгыг эхийн хам бүтцээс таамаглан ярилцаж, монгол хэлний тайлбар толь бичгээс тодруулаарай.

* биоценози - амьд орчин ба тухайн газар онод буй амьтан, ургамал, бичил биетний нэгдэл

* ландшафт - байгаль орчны төрх байдал

- Мазаалайг хамгаалахын тулд хүмүүс юу юу хийж байна вэ? Яагаад хүний гараар бэлтгэсэн тэжээлд ам хүргэдэггүй гэж бодож байна вэ?
 - Эхийг бичсэн аргыг тодорхойлно уу.
2. *Эхэд байгаа баримтуудыг агуулгаар нь бүлэглэнэ үү. Эхэд мазаалайн тухайн хэдэн төрлийн баримт байна вэ?*

2. Тоон мэдээллийг шинжилж, нэгтгэн дүгнэе.

- a. *Мазаалай баавгайн тоо толгой өсөхгүй байгааг дараах хүснэгтэд үзүүлээ. Хүснэгт дэх мэдээллийг боловсруулж, дүгнэлт хийнэ үү.*
- Мазаалайн хорогдсон ижил шалтгааныг ялгаж бүлэглэнэ. Тоо, өнгө, дүрс зэргээр ижил шалтгааныг тэмдэглэвэл тооцоо хийхэд хялбар байх болно.
 - Мазаалайн хорогдсон шалтгааныг төрөлжүүлэн, өгсөн хүснэгтэд бичиж, тус бүрийн бүртгэгдсэн тоо, энэ хүснэгтийн хэд дэх дугаарт байгааг бичнэ.

Мазаалайн хорогдсон шалтгаан*

№	Газрын нэр	Хугацаа	Тоо	Нас, хүйс	Хорогдсон шалтгаан
1	Хуцын шонд	1940 он	1	Тодорхойгүй	Шинжилгээний Оросууд агнасан.
2	Билгэх булаг	1944, өвөл	1	Бамбарууш	Хавханд орсон.
3	Эхийн гол	1949.06 сар	2	Бамбарууштай эвш	Геологийн Оросууд агнасан.
4	Шинэ шонд	1951, хавар	1	Хөгшин	Ичээнийхээ амсар дээр үхсэн.
5	Төмөртийн нуруу	1960-аад он	1	Тодорхойгүй	Худагт унаж үхсэн.
6	Баруун шарга	1960 он	2	Бамбарууштай эвш	Эхийг нь буудаж шархдуулсан.
7	Ямаан ус	1964	1	Бие гүйцсэн	Тодорхойгүй.
8	Цагаан богд	1964	1	Хөгшин мазаалайн сэг	Агуйд байсныг нь үзсэн.
9	Цувлуурын хар уул	1966.10.02	1	Шармаахай	Музейн зориулалтаар үзсэн.
10	Бор хайрхан	1966, хавар	1	Залуу	Өлбөрч үхсэн.
11	Шар хулст		1	Тодорхойгүй	Буудуулж үхсэн.
12	Цагаан богд	1969.04.22	2	Бамбарууштай эвш	Эхийг нь шархдуулж, бамбаруушийг нь авсан.

* https://www.facebook.com/permalink.php?story_fbid=578364742306176&id=578360098973307

13	Цагаан богд	1969.06 сар	1	Шармаахай	Хилийн цэргүүд агнасан.
14	Эхийн гол	1977	1	Бие гүйцсэн	Жолооч Шийрэвжанцан агнасан.
15	Ланзатын ор, Сухайн боомын худаг	1982	1	Бие гүйцсэн	Худагт унаж үхсэнийг Ц.Зэсэнхүү авчирч өгсөн.
16	Элгэний булаг	1983.06.15	2	Ихэр бамбарууш	Хилийн цэргүүд эхээс нь салгаж аваад буцааж тавьсан.
17	Хөтөл ус	1984.04 сар	1	Бамбарууш	Хоёр хоногийн дараа тавьсан.
18	Өлзий билгэх	1985.08.14	2	Эвш	Ноцолдож нэгийгээ барьсан.
19	Зам билгэх	1986	1	Тодорхойгүй	Манааны цэрэг буудаж алсан.
20	Хөтөл ус	1989	1	3-4 настай	Тодорхойгүй.
21	Баруун тооройн булаг	2011.05.21	1	Бие гүйцсэн, эр	Хөгширч үхсэн.
22	Хөндлөн хар	2012.07 сар	1	Бие гүйцсэн мазаалайн сэг	Тодорхойгүй.
23	Алтан тэвш	2013.05.23	1	Бие гүйцсэн эвш	Ноцолдож нэгийгээ барьсан.

Мазаалайн хорогдсон шалтгааныг нэгтгэх хүснэгт

	Хорогдсон шалтгаан	Бүртгэгдсэн тоо	Дугаар
1	Хөгширч үхсэн	2	8, 21
2			
3			
4			
5			
6			
7			
	Нийт	23	

б. Нэгтгэсэн хүснэгт дэх мэдээллийг графикаар харуулна уу.

в. Мэдээллийг нэгтгэсэн хүснэгтэд тулгуурлан, мазаалайн хорогдсон шалтгааныг дүгнэж бичнэ үү.

Мазаалай баавгайн хорогдож байгаа шалтгааныг харуулсан 23 баримтаас үзэхэд 47.8 хувийг нь,, шалтгаанаар үхсэн тохиолдол тус бүр 8.7 хувь, өлбөрч үхсэн хувийг эзэлж байна. Харин үхсэн шалтгаан нь тодорхойгүй тохиолдол хувь байна. Эндээс үзэхэд, мазаалайн тоо толгой хорогдоход их байгаа нь харагдаж байна.

3. Эхийн утга санааг ойлгож, ярилцъя.

1. Зохиолч, сэтгүүлч Ж.Мягмарсүрэнгийн амьтдын тухай бичсэн олон өгүүлэл байдаг. Эдгээрээс уншсан бол ярилцана уу.
2. “Халамцуухан мазаалай” өгүүллгийг уншихдаа мазаалайн тухай баримт, тайлбарыг уран сайхны аргаар бичсэнийг анхаараарай.

Халамцуухан мазаалай

Мазаалайн эм нь эвш, бамбарууш нь аламцаг гэсэн сонин нэртэй. Хоёр жил болж байж төрдөг. Тэгэхдээ голдуу ихэрлэдэг юм гэсэн. Агуй хонгил, хулсан ширэнгэ, сухайн төгөл доогуур үүр ноохойгоо засна. Өвөл тэндээ ичдэг. Сүүдэр олохгүй бол хулс зэгс овоолж овоохой босгочихдог. Өдрийн халууныг овоохойдоо хэвтэн өнгөрөөж, үдшээс үүр цайтал гөрөөлнө. Мазаалай устаж байгаа амьтан. Шүднээсээ олонгүй баавгай үлдсэн гэж эрдэмтэд тооцоолжээ.

Говийн байнгын үзэгдэл их ган, ундаалдаг ус булгийг нь ширгээдэг. Тэр ангаж үхнэ. Зарим жил тэндхийн хөрснөөс зээргэнэ ч цухуйхгүй. Тэр яс мэрсээр байгаад өлбөрч үхдэг. Тэд ийнхүү ядарч зүдэрч амьдарч байгаа билээ. Гэвч уруудах тутам нүүрээ буруулдаг нь орчлонгийн жам. Ядахдаа хэдий чинээ цөөрнө, тэдний доторх тэнэгийн тоо төдий чинээ өсдөг нь бүр харамсалтай. Мазаалай цөөхөн. Тийм атлаа говьд хааяа нэг тааралдахаараа бие биеэ барьж иднэ гээч. Салгалалдан архиралдаж бие биенээ айлгах гэж байдгаараа ярзайлдан орилолддог. Тэгээд л ноцолдчихно. Нэг нь дийлж, нөгөөдөх нь дийлдэх нь мэдээж. Дийлдсэн нь биеэ суллан сарвуугаа өргөн гөлөлзөж бууж өгдөг. Яг энэ мөчид уг амьтдад байгалиас заяасан нэг хууль үйлчлэх ёстой юм. Бууж өгснийгөө өршөөж, захиргаандаа авах. Махчид ихэвчлэн хүзүүгээ тавьж өгч бууж өгдөг. Мазаалай ч мөн тэгнэ. Гэвч энэ хууль мазаалайд хамаагүй. ...Уруудахад бурууддагийн нэг жишээ энэ.

Бас эм баавгай үр зулзагандаа хатуурхана гэж жигтэйхэн. Аламцгаа хоосон хаячхаад хэдэн хоногоор хамаагүй тэнээд алга болчихно. Явж явж ирээд, зулзагаа хөхүүлнэ гэж байхгүй. Салтаандаа хөхөө дараад суучихна. Аламцаг хэчнээн орилсон ч аргадахгүй, харин алгадаж унагадаг аж. Хөөрхий, хүүхэд нь нойрон дунд нь хулгайгаар мөөм үлгэнэ. Шувуун дэлэнт эхэд сүү байхгүй. Өөрөө үргэлж өлөн явах юм чинь юугаараа ч сүүших вэ?

Говийн баавгай их унтамхай. Тэгэхээс ч аргагүй. Цөлийн мансуурсан халуунд өөр юу хийх билээ? Их ган нүүрлэж, идэш тэжээлгүй болбол зунаар ичээлнэ. Урдуудахад унтаж идэх гэж хүмүүс бие биеэ хэлдэг. Энэ үг баавгайд ч тохирмоор санагдана.

Мазаалай намар болохоор хармагийн жимс их иднэ. Говийн жимс тун исгэлэн. Бараг мөчир дээрээ бэлэн болчихсон дарс л гэсэн үг. Мазаалай өлөн элгэн дээрээ хармаг идсээр байгаад согтчихдог байна. Согтуурч мансуурах нь сайхан мэт “санагдах” тул хүн архинд ордогтой адил хармагт орчихно. Тэр мөнхийн согтуу найгана. Үе үехэн энэхүү одой баавгай хоёр гараараа цээжээ уран, овоохойгоо тойрон гүйж яваа харагддаг гэнэ. Говийн анчид дурандаж, “Энэ жил хармаг их гарч дээ, мазаалай “согтчихжээ” гэж ярилцдаг


аж. Халамцуу мазаалай тархиа шааж, өөрөө өөртөө агсам тавина. Бас нохой харвал чулуу шидэж дөвчгөнөнө. Тэгснээ учиргүй их орилж уйлдаг аж. Элчилгүй их элсэн цөлд балран сөнөж буй тавиландаа бачимдан давчиддаг ч байж мэдэх юм...

(Ж.Мягмарсүрэн)

а. Дараах асуултад хариулж, даалгаврыг гүйцэтгээрэй.

- Эхийн эхлэл, гол төгсгөл хэсэгт юу юуны тухай өгүүлсэн байна вэ?
- Зохиолч мазаалайн амьдралын ”хүнд” нөхцөлийг яаж дүрсэлсэн бэ?
- Мазаалайн тоо, толгой нэмэгдэхгүй байгаа ямар ямар шалтгааныг онцлон өгүүлсэн байна вэ?

б. Эхийн гол санааг тодорхойлно уу. Эхэд өгүүлэгдэж байгаа мазаалай нь хүн, юмстай хэрхэн холбогдож байна вэ?



в. Дараах өгүүлбэрийн аль нь зохиогчийн мэдрэмж сэтгэгдэл, аль нь дүгнэлт, аль нь үзэл бодлыг илэрхийлсэн бэ? Тэмдэглээрэй (+). Ийм жишээг эхээс нэмж олоод, хүснэгтийг үргэлжлүүлнэ үү.

Өгүүлбэр	Мэдрэмж сэтгэгдэл	Дүгнэлт	Үзэл бодол
Тэд ийнхүү ядарч зүдэрч амьдарч байгаа билээ. Гэвч уруудах тутам нүүрээ буруулдаг нь орчлонгийн жам.			
Мазаалай амьдрахад улам л хүнд болсоор байгаа мэт санагдана. Ядахдаа хэдий чинээ цөөрнө, тэдний доторх тэнэгийн тоо төдий чинээ өсдөг нь бүр харамсалтай.			
Уруудахад бурууддагийн нэг жишээ энэ.			
Хөөрхий, хүүхэд нь нойрон дунд нь хулгайгаар мөөм үлгэнэ. Шувуун дэлэнт эхэд сүү байхгүй. Өөрөө үргэлж өлөн явах юм чинь юугаараа ч сүүших вэ?			
...Урдуудахад унтаж идэх гэж хүмүүс бие биеэ хэлдэг. Энэ үг баавгайд ч тохирмоор санагдана.			
Элчилгүй их элсэн цөлд балран сөнөж буй тавиландаа бачимдан давчиддаг ч байж мэдэх юм.			

- г. “Халамцуухан мазаалай” эхэд уран дүрслэлийг цөөнгүй ашиглажээ. Зохиогч маш халуун гэдгийг “зээргэнэ ч цухуйхгүй” (говь цөлд ургадаг, бүдүүн голтой бутлаг ургамал), маш цөөхөн тоотойг “шүднээсээ олонгүй”, ямар ч сүүгүй гэдгийг “шувуун дэлэнт эх” (шувуунд дэлэн байдаггүй) гэж тус тус дүрсэлжээ. Тэгвэл та нар “маш халуун”, “маш цөөхөн”, “ямар ч сүүгүй” гэдгийг дүрсэлж бичнэ үү. Үлгэрлэвэл:

Дүрсэлсэн зүйл	Зохиогчийн сонгосон үг, дүрслэл	Та нарын сонгосон үг, дүрслэл
<ul style="list-style-type: none"> • Маш халуун (зундаа +46С) • Маш цөөхөн 	<ul style="list-style-type: none"> • Зарим жил тэндхийн хөрснөөс зээргэнэ ч цухуйхгүй. • Шүднээсээ олонгүй баавгай үлдсэн... 	<ul style="list-style-type: none"> • •

- д. Дараах өгүүлбэрт онцолсон үг хэллэг ямар уран дүрслэлээр бүтсэнийг тодорхойлж, учрыг тайлбарлана уу. Дараа нь эхээс өөр уран дүрслэл бүхий жишээ хоёроос доошгүйг олж, тайлбарлаарай.

Жишээ нь:” **Халамцуу** мазаалай **тархиа шааж**, өөрөө өөртөө **агсам тавина**. Бас нохой харвал чулуу шидэж **дөвчгөнөнө**”- Архи уусан хүний гаргадаг муу араншинг исгэлэн хармаг их идсэн мазаалайд шилжүүлэн дүрсэлсэн.

Хүншүүлэл:

Хүнд байдаг шинж чанарыг амьтан, амьгүй зүйлд шилжүүлэх дүрслэх хэрэглүүр.

Шүднээсээ олонгүй баавгай үлдсэн гэж эрдэмтэд тоцоолжээ.

Адилтгал:

Үгийг үндсэн утгаар нь бус, өөр төстэй үзэгдлийг дүрслэхэд утга шилжүүлэн дүрслэх хэрэглүүр.

Хөөрхий, **хүүхэд нь** нойрон дунд нь хулгайгаар мөөм үлгэнэ.

Шувуун **дэлэнт** эхэд сүү байхгүй.

Төлөөлөл:

Нэгийг нөгөөгөөр орлуулан, утга шилжүүлэх дүрслэх хэрэглүүр.

Халамцуу мазаалай тархиа шааж өөрөө өөртөө **агсам тавина**. Бас нохой харвал чулуу шидэж **дөвчгөнөнө**.

- е. Эхийн төгсгөлд зохиогчийн “Элчилгүй их элсэн цөлд балран сөнөж буй тавиландаа бачимдан давчиддаг ч байж мэдэх юм.” гэсэн таамаглал дүгнэлтийг эргэцүүлэн бодоорой.

- Дараах гурван шийдлээс өөрийн бодолтой тохирч байгааг сонгож, үндэслэлээ гаргаарай. Ийм байдалд хүрэхгүйн тулд бид юу хийх вэ?


Шийдэл 1. Санал нийлж байна. Яагаад гэвэл

Шийдэл 2. Санал нийлэхгүй байна. Яагаад гэвэл

Шийдэл 3. Эргэлзэж байна. Яагаад гэвэл

4. Энгийн тоочсон ба дүрслэн бичсэн эхийг харьцуулан шинжилье.

- а. Мазаалайн тухай унисан хоёр эхийн ижил ба ялгаатай талыг эргэцүүлж бодъё. Дараа нь саналаа ярилцаарай.



- б. Хоёр эхдийн дүрслэлийг харьцуулснаа дүгнэж бичье.


- Хоёр эхэд мазаалай баавгайн нэршил, тоо толгой, амьдардаг газар, идэш тэжээл, авир араншин, хорогддог шалтгаан зэргийг яаж дүрсэлсэн бэ? Доорх хүснэгтийг зурж, тохирох дүрслэлийг түүж бичнэ үү.

Асуулт	“Мазаалай баавгайн тухай баримтууд”	“Халамцуухан мазаалай”
Нэршил		
Тоо толгой		
Амьдардаг газар		
Идэш тэжээл		
Араншин		
Хорогддог шалтгаан		

в. Хүснэгт дэх мэдээллийг нэгтгэн дүгнэж бичээрэй.

г. Хоёр эхэд өгүүлсэн зүйлийг харьцуулан тайлбарлаж бичээрэй. Үлгэрлэвэл:

"Мазаалай баавгайн тухай баримт" эхийн 8 дугаарт тэдгээрийн тоо толгой 30 хүрэхгүй байгааг он, оноор нь тоочсон бол "Халамцуухан мазаалай" эхэд "шүднээсээ олонгүй" гэж дүрсэлжээ.



д. Мазаалайн тухай хоёр эхийг уншаад, ямар сэтгэгдэл төрөв? Хүний үзэл бодол, хандлага төлөвшил ялгаатай учир аливаа зүйлийн талаар хүн бүрийн сэтгэгдэл адил байдаггүй. Хоёр эхийг уншаад, төрсөн сэтгэгдлээ бичээрэй.

Бичихдээ мазаалайн талаар сэтгэлд үлдсэн зүйл, эхэд өгүүлсэн зүйлсийн холбоо хамаарал, мэдрэмж, сэтгэгдэл гээд санаанд орсон зүйлээ бичээрэй. Хоёр эхээс гадна өөр эх сурвалжаас авсан мэдээллээс ч оруулж болно. Эдгээрийн дэс дарааллыг бодонгоо нэгтгэн дүгнэж, зөвхөн өөрт төрсөн сэтгэгдлээ бичихийг зөвлөж байна.



Шалтгааны утгатай угсарсан нийлмэл өгүүлбэрийн бүтээн аргыг тодорхойлох

1. Шалтгааны утгатай нийлмэл өгүүлбэрийн тухай ойлголттой болъё.

Дараах хоёр өгүүлбэрийг ажиглаад, асуултад хариулна уу.

А. Мазаалай угтаа махчин амьтан.

Б. Гэвч [мазаалай] одоо малчдад бэлчээр нутгаа булаалгаж, цөл рүү шахагдсан учраас идэш тэжээлийнх нь 77 хувь ургамал, 23 хувь амьтны гаралтай болсон.

- Хоёр өгүүлбэрт тус бүр хэдэн санаа илэрч байна вэ?
- Хоёр дахь өгүүлбэрийг хоёр энгийн өгүүлбэр болгон бичнэ үү.
- Энэ хоёр өгүүлбэрийн аль нь голлож, аль нь түүнд захирагдсан байна вэ?
- Энэ өгүүлбэрт “учраас” гэдэг холбох үг ямар үүрэгтэй байна вэ?
- Угсарсан нийлмэл үгтэй ижил шинж байна уу?

2. Шалтгааны утгатай нийлмэл өгүүлбэрийг найруулж бичье.

а. Дараах өгүүлбэрийг энгийн өгүүлбэр болгон задалж, дээрх байдлаар харуулна уу. Холбох хэрэглүүрийг олж бичээрэй. Үлгэрлэвэл:

Гэвч [мазаалай] одоо малчдад бэлчээр нутгаа булаалгаж, цөл рүү шахагдсан.

учраас

[Мазаалайн] идэш тэжээлийнх нь 77 хувь ургамал, 23 хувь амьтны гаралтай болсон.

- Түүний иддэг ургамал, шавж байгальд ховордсоноос мазаалай өлсөж үхэх болсон.
- Их ган нүүрлэж, идэш тэжээлгүй болбол зунаар ичээлнэ.
- Мазаалай өлөн элгэн дээрээ хармаг идсээр байгаад согтчихдог байна.
- Түүнийг аврахын тулд янз бүрийн тэжээл орлуулан тавьдаг.
- Гэвч нэгэнт цадсан тул түүнийгээ умартан өөр тийшээ тэнэн алга болчихно.
- Тэр яс мэрсээр байгаад өлбөрч үхдэг.

Шалтгааны утгатай холбох хэрэглүүр:

- Үг: учраас, тул, тулд, учир, улмаас, бол,
- Нөхцөл: -тал⁴, -бал⁴, -вал⁴, -нгуут², -нгаа⁴, -аад⁴ ...

Шалтгааны утгатай өгүүлбэр

Нийлмэл өгүүлбэрт үйл явдал дараалж болоход аль нэг нь илүү гол үүрэгтэй байдаг. Эхний үйл явдал нь дараагийн үйл явдал бүтэхийн үндэс болж, төгс бус өгүүлэхүүнээр илэрсэн өгүүлбэрийг шалтгааны утгатай өгүүлбэр гэнэ. Ийм өгүүлбэр нь ямар учраас?, юуны учир?, яаж?, яахлаар?, яавал?, яасанд?, яаснаас?, юу гэж?, юуны тул? гэх зэрэг асуултад хариулагдана. Жишээ нь:

Сүүдэр хараад сүхээ барина

Сүүлээ хараад соёогоо харуулна.

Энэ хэлцэд байгаа хоёр өгүүлбэрийн аль аль нь хардах, хэрцгий авиртай гэсэн утгатай бөгөөд үйлийн урьдчилан холбох “- аад” нөхцөл нь дараах үйл буюу “сүхээ барих”, “соёогоо харуулах” гэсэн үйл бүтэх шалтгааны утга болно.

Ишиг эврээ ургахлаар эхийгээ мөргөнө

Ус эргээ нурахлаар гадагш урсана.

Энэ хэлцэд байгаа хоёр өгүүлбэр нь бусдын ач тусыг боддоггүй, ачлалгүй гэсэн утгатай бөгөөд дагалдан холбох “-хлаар” нөхцөл нь “эхийгээ мөргөх”, “гадагш урсах” гэсэн үйл бүтэх шалтгааны утга болж байна.

б. *Хэсэг бүрд байгаа өгүүлбэрүүдийг холбож, шалтгааны утгатай болгон найруулж бичээрэй. Зарим үгийг хасах, нэмэх, өөрчлөх зэргээр найруулгыг анхаарах хэрэгтэй.*

- Мазаалай устаж байгаа амьтан. Шүднээсээ олонгүй баавгай үлдсэн гэж эрдэмтэд тоцоолжээ.
- Шувуун дэлэнт эхэд сүү байхгүй. Өөрөө үргэлж өлөн явах юм чинь юугаараа ч сүүших вэ?
- Говийн байнгын үзэгдэл их ган ундаалдаг ус булгийг нь ширгээдэг. Тэр ангаж үхнэ.
- Зарим жил тэндхийн хөрснөөс зээргэнэ ч цухуйхгүй. Тэр яс мэрсээр байгаад өлбөрч үхдэг.

в. *Нийлмэл өгүүлбэрүүд хэрхэн холбогдсоныг ажиглаж, шалтгааны утга ямар хэлбэрээр илэрснийг тайлбарлаарай.*

Усан дуслыг хураавал сав дүүрнэ

Уран үгийг цуглуулбал мэргэн болно.

Ишиг эврээ ургахлаар эхийгээ мөргөнө

Ус эргээ нурахлаар гадагш урсана.

Уулнаас ирсэн хар торгыг

Урагдахаар нь оёж болдоггүй

(Мөс)

Шидийг олоод нисэхийг шахав

Шидэмсээр боолгоод үхэхийг шахав

(Үлээсэн гүзээ)

Ус гаталсан хойно онгоц хэрэггүй
Өвчин эдгэрсэн хойно эмч хэрэггүй

Эх нь булингартай бол
Адаг нь булингартай

Будаач будаач гэхээр сахлаа будав.

Уулын чулуу унавал уруугаа хол өнхөрнө.

Улсын тэргүүн алдвал учрах ял хүндэрнэ.

2. *Хэсэг бүрийн өгүүлбэрийн байрыг сольж, утгыг алдагдуулахгүй найруулж бичнэ үү. Ямар өөрчлөлт гарсан бэ? Үлгэрлэвэл:*

Үндсэн эх	Байрыг нь сольж найруулсан хувилбар
[Мазаалай] малчдад бэлчээр нутгаа булаалгаж, цөл рүү шахагдсан учраас идэш тэжээлийнх нь 77 хувийг ургамал, 23 хувийг амьтны гаралтай идэш эзлэх болжээ.	Мазаалайн идэш тэжээлийн 77 хувийг ургамал, 23 хувийг амьтны гаралтай идэш эзлэх болсон нь малчдад бэлчээр нутгаа булаалгаж, цөл рүү шахагдсантай холбоотой.

- Түүнийг аврахын тулд янз бүрийн тэжээл орлуулан тавьдаг ч... ам хүргэх нь ховор.
- Хэдэн өдөр явтал хошуу нутгийн хил ойр тул төд удалгүй харийн хошуунд оржээ. (Ц.Д)
- Болд сайн зарцаасаа салж, адууны жижгийг танихгүй, тэр өвөл баахан зуд болсон боловч Болдын нутаг өн тавиун учир харь хошуудаас олон нүүдэлчин ирж, нутагласан тул адуунаас ганц хоёрыг алдсаар арав гаруй тоонд хүрсэн ба бас тав зургаан үхэр алджээ. (Ц.Д)
- Хоньчин Найдангийн аав Зоригт бол ...захирагч Сүрэнгийн балмад дээрэнгүйг үзэн яддаг ба үргэлж хурц мэргэн үгээр мохоодог байсан учир захирагч Сүрэн ихээхэн хорсдог, занан зүхдэг байжээ. (Д.Ц)

3. Найруулгын алдааг таньж, засъя.

- а. *Дараах өгүүлбэрт учир зүйн ямар алдаа гарсныг олж, тайлбарлана уу.*

Хатсан навчис сэржигнэн унахад намрын хонгор салхи үлээнэ.

Хувцсаа дасгах журмаар нимгэлэх ба биеийн тамирын дасгал, хөдөлгөөнт тоглоомыг хийхэд чөлөөтэй хөдөлж болохоор хувцас өмсөнө.

- б. *Эхийн найруулгыг сайжруулан бичнэ үү.*

- Найруулгын алдаатай болон алдааг зассан өгүүлбэрийг харьцуулан ажиглаад юуг, яаж зассаны учрыг тайлбарлана уу. Үлгэрлэвэл: “Олон тооны зөгий нэгэн үүрэнд бүл үүсгэн амьдардаг.” Энэ өгүүлбэрт “тооны” гэсэн үг илүүдсэн учир хасаж найруулсан.

Эх өгүүлбэр	Зассан хувилбар
Олон тооны зөгий нэгэн үүрэнд бүл үүсгэн амьдардаг.	Олон зөгий нэг үүрэнд бүл үүсгэн амьдардаг.
Хатан зөгий зуны улиралд үүрнийхээ зургаан талт хонхорцогт өндөг гарган, нэгээс нөгөөд шилжин явж өнгөрөөнө.	Хатан зөгий үүрнийхээ зургаан талт хонхорцгийн нэгээс нөгөөд дамжин өндөглөж, зуны улирлыг өнгөрөөнө.
Зөгийн бүлийн нөгөө хэсгийг эрэгчин зөгий эзлэх ба нэг бүлийн дотор хэдэн арваад байдаг.	Зөгийн бүлийн нөгөө хэсэг болох эрэгчин зөгий нэг бүлд хэдэн арваараа байдаг.
Хатан зөгийд үр тогтоох үүргийг эрэгчин зөгий гүйцэтгэнэ.	Эрэгчин зөгий хатан зөгийд үр тогтооно.
Цэцгийн шүүс зөгийн шүлстэй нийлэн, бал болон хувирна.	Цэцгийн шүүс, зөгийн шүлстэй нийлэн бал болно.

- в. Дараах эхийн өгүүлбэр бүрийн найруулгыг хянаж, шаардлагатай өгүүлбэрийн алдааг дээрх маягаар засаж найруулна уу. Бичихдээ эхийн учир зүйн дарааллыг сайтар бодоорой.

Зөгийн бүлийн дотроос хамгийн том нь хатан зөгий. Хатан зөгий нь өндөглөдөг ганц зөгий юм. Ажилчин зөгий гэдэг нь үржлийн эрхтэн нь дутуу хөгжсөн эмэгчин зөгий юм. Ажилчин зөгийнүүд үүрээ хамгаалах, өндөг авгалдайг асрамжлах, тэжээл бэлтгэх, үүр барих үүрэг гүйцэтгэнэ. Эрэгчин зөгийнүүд биеэр хатан зөгийнөөс бэсрэг, ажилчин зөгийнөөс бадриун байхын дээр толгойныхоо дагзанд хүрсэн том нүдтэй байна. Эрэгчин зөгий тэжээл бэлтгэх, өндөг, авгалдайг асрамжлахад үл оролцоно. Ажилчин зөгий цэцгээс цэцэгт дамжин нисэх зуураа цэцгийн амттайхан шүүсийг хошуугаараа сорон цуглуулж, улаан хоолойн өргөссөн хэсэг болох ходоодондоо хуримтлуулна. Үүрнийхээ хүрэлцэн ирсэн зөгий энэхүү балыг үүрийн хонхорцгуудад шахан хийдэг.

- г. Дээрх хоёр үйл ажиллагаагаар засаж сайжруулсан өгүүлбэрүүдээ нэгтгэн “Балт зөгий” нэртэй эх болгон найруулж бичээрэй. Учир шалтгааны холбоотой өгүүлбэрүүдийг нэгтгэн, нийлмэл өгүүлбэр болгон найруулна уу. Үлгэрлэвэл:

1. Хатан зөгий нь өндөглөдөг ганц зөгий юм.	<p><i>Нийлүүлж найруулсан хувилбар:</i></p> <p>Хатан зөгий нь өндөглөдөг ганц зөгий тул үүрнийхээ зургаан талт хонхорцгийн нэгээс нөгөөд дамжин өндөглөж, зуны улирлыг өнгөрөөнө.</p>
2. Хатан зөгий үүрнийхээ зургаан талт хонхорцгийн нэгээс нөгөөд дамжин өндөглөж, зуны улирлыг өнгөрөөнө.	

Жишээ баримт ашиглаж, дүрслэн тайлбарлаж бичих

1. Баримт ашиглан, тайлбарлаж бичье.

- Өөрсдийн нутаг орондоо байдаг ховордсон аль нэг ан амьтны тухай бичнэ үү. Эсвэл тухайн нутгийн нэрийг гаргадаг чухал амьтан ч байж болно.
- Бичихдээ дараах шаардлагыг харгалзан бичээрэй.

1. Хэнд зориулсан нь тодорхой байх
2. Сонгосон амьтны онцлог шинж (нэршил, тоо толгой, амьдардаг газар, идэш тэжээл, авир араншин, ховордсон шалтгаан, эсвэл ашиг тус) зэргийг тодорхой харуулсан байх
3. Сонгосон амьтны талаар 6-7 баримт, жишээ оруулсан байх
4. “учраас, тул”, “иймээс”, “ийм учраас” зэрэг холбоос үг хэрэглэсэн байх
5. Мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодлоо илэрхийлсэн байх

а. Бичих даалгаврыг дараах алхмаар гүйцэтгээрэй.

Алхам 1. Сэдэв сонгох. Нутагтаа байдаг ан амьтан, жигүүртэн шувуудаас нэгийг сонгоно уу. Нэг бол ховордсон, эсвэл танай нутгийн онцлогийг харуулдаг амьтан байвал нэн сайн.

- ✓ Бичих сэдэв буюу эхийн нэр нь бичих зүйлийн агуулга, хүрээ хэмжээг тогтооно. Өөрөөр хэлбэл бичих, бичихгүй зүйлийг ялган тунгаах хэмжүүр болно гэсэн үг. “Мазаалай хамгаалахад миний оролцоо” гэсэн сэдвээр бичихдээ мазаалай бол ховор амьтан, мазаалайг хамгаалах хэрэгтэй, түүнийг хамгаалахын тулд ийм тийм зүйл хийх ёстой гэх мэтээр бичвэл агуулга нь сэдэвтээ тохирохгүйд хүрнэ. Харин мазаалайг хамгаалах үйл ажиллагаанд өөрөө оролцож, юу юу хийсэн, эсвэл юу хийх, ингэснээр юунд хүрсэн, цаашид юу хийх талаар бичвэл сэдэвтээ тохирох болно.
- ✓ Бичиж болох амьтдын талаар бодож, аль нэгийг нь сонгож, дараа нь яг ямар асуудлаар бичихээ сайн бодож шийдээрэй. Жишээ нь: мазаалайн тухай бичнэ гэвэл “Мазаалай бол ховор амьтан”, “Мазаалайг хамгаалъя”, “Мазаалайн тоо толгой нэмэгддэггүйн учир” гэх мэтээр сэдвийг нарийвчлан тогтоно.
- ✓ **Алхам 2.** Зохион бичих төлөвлөгөө гаргах. Сэдвийг ойлгосны дараа бичих төлөвлөгөөг гаргах хэрэгтэй. Төлөвлөгөө нь цуглуулсан мэдээллийг ангилж бүлэглэх, дэс дараалал, уялдаа холбоотой байх, зарим санааг давхардуулахгүй, эсвэл орхихгүй байхад тустай. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэгт ямар мэдээллийг оруулахаа төлөвлөнө. Төлөвлөгөөг асуултаар, түлхүүр үгээр, богино өгүүлбэрээр бичиж болно.

Гол хэсэг:

Гол санааг гаргах
удиртгал, ерөнхий
хэсэг

Эхлэл хэсэг:


Сэдвийн агуулгыг
бүрэн гүйцэд
гаргасан хэсэг

Төгсөл хэсэг:

Бичсэнээ нэгтгэн
дүгнэсэн хэсэг

Алхам 3. Сонгосон сэдвээр судалгаа хийж, мэдээлэл цуглуулаарай.

- ✓ Бичих сэдвийн талаар ном, сурах бичиг, сонин, сэтгүүл, толь бичиг, интернэтийн мэдээллийн сан зэргээс унших; радио сонсох, телевизийн нэвтрүүлэг үзэх, орон нутгийн музей үзэх, энэ талаар мэдэх хүнээс асууж лавлах зэргээр мэдээлэл цуглуулна. Ийнхүү мэдээллийг эрж хайж, цуглуулах явцдаа бичихэд хэрэг болох чухал хэсгийг товч бичих, бүдүүвчээр зурах зэргээр тэмдэглэх хэрэгтэй. Мөн өөрт төрсөн сэтгэгдлийг товч тэмдэглэж болно. Мөн уг зүйлийг баталж, нотолсон үг, өгүүлбэр, тоо баримт зэргийг эхээс шууд хуулж авах хэрэгтэй.



Алхам 4. Цуглуулсан мэдээллээ ангилж бүлэглээрэй. Энэ шатанд бичих санаагаа цэгцэлнэ.


- ✓ Цуглуулсан мэдээллээс гол чухлыг нь ялгах, дэс дараалалд оруулахад туслах олон арга байдаг. Эдгээр нь эхийн бүтцийг гаргах, бичих зүйлээ цэгцлэхэд тусалдаг. Үүний тулд дараах хүснэгтийг ашиглаж болно.

Төлөвлөгөө	Холбогдох мэдээллийн гол санаа
Эхлэл	
Гол хэсэг	
Төгсгөл	

- ✓ Бас оюуны зураглал хийж болно. Та нарын уншсан хоёр эх дэх мазаалайн тухай мэдээллийг бүлэглэн үзүүлье. Цуглуулсан мэдээллээ энэ аргаар бүлэглэж болно. Мэдээллийг юуг үндэслэн, яаж бүлэглэсэн талаар ярилцаарай. (115 дугаар хуудасны зургаас харна уу.)

Алхам 5. Төлөвлөсний дагуу бичээрэй. Энэ нь та нарын зохион бичлэгийн эхний ноорог болно.

- ✓ Эхийн эхлэл, төгсгөл болон гол хэсэгт ямар ямар санаа гаргахаар төлөвлөсөн, түүний дагуу санаагаа цаасан дээр шууд буулгаарай. Мөн тухайн хэсэгт холбогдох баримтыг оруулаарай. Энэ үед зөв бичгийн дүрмийн алдаа, бичгийн хэв зэрэгтээ санаа зовох шаардлагагүй, гол нь санаагаа илэрхийлэхэд анхаарах хэрэгтэй.
- ✓ Бичсэнээ уншиж, санаагаа гаргаж чадсан эсэхийг хянаад, сайжруулах шаардлагатай хэсгийг бусад хүмүүст үзүүлж, зөвлөгөө аваарай. Дараа нь бичсэнээ уншиж, мартсан, буруу зүйл байгаа эсэхийг шалгаад нэмж, засаж бичиж болно.



- Алхам 6.** Зохиосон эхийг сайжруулж, сийрүүлэн бичээрэй. Бусдын өгсөн зөвлөгөөнөөс чухал гэж үзсэн санааг авч, эхийг сайжруулаарай.
- ✓ Зөв бичих дүрмийн алдаа болон найруулгын алдааг хянаж, засаарай.
 - ✓ Засахдаа үг, бүтээвэр, үсэг нэмэх, хасах, солих, шилжүүлэх зэргийг тэмдэглэдэг тусгай тэмдэглэгээ ашиглаарай.
 - ✓ Эхийг цэвэр цаасан дээр эсвэл дэвтэртээ сийрүүлэн бичихдээ алдаа мадаг гаргахгүй байх хэрэгтэй. Эхийн утга санаанд тохирсон зураг, бүдүүвч зэргээр баяжуулж болно.

2. Сурагчийн бичсэн эхийг үнэлье.

а. Сурагчийн бичсэн “Мазаалайг хамгаалахад миний оролцоо” эхийг дараах шалгуураар үнэлээрэй.

- Сурагч, мазаалайг хамгаалах үйл ажиллагаанд яаж оролцсон байна вэ? Үүнийг тайлбарласан хэсэг байна уу?
- Мазаалайг яагаад, ямар учраас хамгаалах шаардлагатай вэ? Үүнийг нотлох баримт, тайлбар байна уу?
- Мазаалайг сурталчлан таниулах шаардлагатай гэдгийг тайлбарласан уу?
- Бичигч мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодлоо илэрхийлсэн үү?

Мазаалай бол дэлхийд ховордсон амьтан

Мазаалайн тухай бичье гээд бодтол санаанд юу ч орсонгүй. Яагаад Хятадын Сычуань мужид байдаг хулсны баавгай, Арктикийн цагаан баавгайн тухай мэддэг атлаа зөвхөн манай говьд л байдаг, “Улаан ном”-д орсон мазаалайн тухай мэддэггүй билээ? Энэ үед өөрийгөө их л голж байсан ч “Монголоо мэддэггүй монгол” гэдгээ ойлгосондоо л баярлаж байлаа.

Бид биологийн хичээлээр сүүгээр бойжигч, мөлхөгч, хоёр нутагтны тухай ганц нэг хэлэх юмтай атлаа мазаалайн тухай ховор амьтан гэдгээс өөр төсөөлөлгүй. Газар зүйн хичээлээр “Дэлхийн дархан цаазтай газар”-ыг судалсан атлаа өөрийнхөө улсын дархан цаазтай газрын тухай, хаагуур ямар амьтан, ургамал тархсан байдгийг огт мэдээгүй явж байгаа нь үнэхээр харамсалтай байгаа биз.

Хятад улс пандагаа устаж үгүй болохоос нь өмнө аварч чадсан. Тэр бүү хэл 2008 онд хулсны баавгайг Бээжингийн олимпын бэлгэ тэмдэг болгож, дэлхий нийтэд таниулж чадсан. Ховордсон ан амьтны төлөөлөл болсон энэ амьтан “хөгжил баясал, хайр энхрийлэл”-ийг бэлгэдсэн.

Тэгвэл бид яагаад Ази тивийн аварга шалгаруулах аль нэгэн тэмцээн уралдаан зохион байгуулахдаа мазаалайг бэлгэ тэмдэг болгож болохгүй гэж?

БНХАУ-ын алдарт зураач Ша Ма Ла И манай оронд ирээд уран зургийн галерейд үзэсгэлэн гаргасныг би сайн санаж байна. Нийт 65 бүтээлийнх нь 50 гаруй нь “Панда”-ийн зураг байсан бөгөөд “Ховордсон ан амьтдыг хайрлан хамгаалах сэтгэлийг уран бүтээлээрээ дамжуулан хүргүүлдэг. Би хожим мазаалайн зургаар уран бүтээлийн үзэсгэлэнгээ гаргах болно” гэж сэтгүүлчдэд ярилцлага өгсөн байсан. Эх орны маань ховор амьтныг гадны зураач зураад, үзэсгэлэнгээ гаргачихвал ичгэвтэр юм болох биз.

Ер нь мазаалайн тухай таниулж чадах гол хүмүүс бол зохиолч, эрдэмтэн, судлаач, уран бүтээлч, хөгжмийн зохиолч, зураач нар юм. Тэд мазаалайн тухай бүтээл туурвиж болно. Бид ч зүгээр сууж болохгүй мазаалайг хамгаалах үйл ажиллагаанд чадлынхаа хэрээр оролцох боломжтой. Шинэ жилийн баяраар “Улаан ном”-д орсон амьтдын дүр бүтээж, бүжиглүүлж болно. Дүрслэх урлаг, технологийн хичээлээр ховор амьтдыг зуруулж, баг хийлгэж болно. Хүүхдүүд бид чинь хийж бүтээсэн зүйлээ илүү сайн ойлгож, бас хайрлаж чаддаг билээ. Энэ бүхэн мазаалайн тухай мэдлэгтэй болж, түүнийг хайрлан хамгаалах үндэс болно. Цөөхөн үлдсэн энэ амьтан монгол хүн бүрийн хайраар тэжээгдэн өсөж үржсин, олон болох цаг тун удахгүй биз ээ.

(Сурагч Г. Түвшинжаргал)

Өөрийгөө сорьё.

а. Дараах хоёр эхийг уншаад, даалгаврыг гүйцэтгэнэ үү.

Вансэмбэрүү (1)

Вансэмбэрүү нь ихэвчлэн гурван мянган метрээс дээш өндөрт уулын таг, цармын хад асганд хосоороо ургадаг. Манай улсын Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулсаар маш ховор тархжээ.

Энэ цэцэг нь 15 см-ээс нэг метр хүртэл өндөр ургадаг. Цэцэг нь бүдүүн иштэй, захаараа олон хурц шүдлэгтэй, том цагаан дэлбээ бүхий цоморлогийн голд зөөлөн бүлээн, хүрэн толгойтой, голч нь 10-15 см. Өөр хоорондоо 10-20 метрийн зайтай хосоор ургадаг агаад энэ нууцыг одоо болтол тайлаагүй байна.

Вансэмбэрүү цэцгийг монголчууд уулын орой дээр ургадаг учраас “тэнгэрийн задын цэцэг” хэмээн сүслэн шүтэх нь бий. Эрж хайсан хүн бүрд үзэгддэггүй, үзэгдэх хүндээ л үзэгддэг гэх яриа ч байдаг. Хос вансэмбэрүүг харсан хүн аз жаргалтай амьдардаг гэж домогт өгүүлдэг.

Эрт цагт оточ маарамбууд түүнийг түүж, эмийн сор болгон тунгаар хэмжиж, өвчин эмгэгт шаналагсдыг эмнэн тэнхрүүлдэг байжээ. Орчин цагт хорт хавдар, уушгины өвчин, ханиад томууны эм бэлтгэх гэж их хэмжээгээр түүснээс ховордсон тул Монголын “Улаан ном”-д оруулжээ. Энэ цэцгийн үрийг гадагш гаргахыг хориглосон байдаг аж.

Вансэмбэрүү (2)

Аглагхан ойн зах сийрээд
Орой нь халзрах уулын тагт
Ариухан горхины эх шургаад
Авиа нь тасрах асганы шилд
Төөлөөд үзвэл бие чацуу
Тоолоод үзвэл нас чацуу
Үзэсгэлэнт хоёр вансэмбэрүү
Үүд хоймрын зайтай ургажээ.



Уранхан цоморлогийг нь илээд үзвэл
Унаганы уруул шиг зөөлөн байлаа.
Хүрэнхэн цоморлогийг нь илээд үзвэл
Хүүгийн минь зулай шиг бүлээн байлаа.
Өвөг дээдэс маань энэ цэцгийг
Өнө эртэд олсон гэнэм
Алжаасан бие эдгээдэг чадлыг нь
Аль хэзээнээс мэдсэн гэнэм. ...

(Б.Явуухулан)

б. “тун”, “зад” гэсэн хоёр үгийн утгыг “Монгол хэлний тайлбар толь”-оос тодруулаарай.

в. Хоёр эхэд юуны тухай өгүүлснийг тохирох хэсэгт ялган бичнэ үү.

	Вансэмбэрүү (1)	Вансэмбэрүү (2)
Ургадаг газар	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Онцлог шинж	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Ач холбогдол	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

г. Хоёр эхийг дараах асуултаар шинжилж, тохирох жишээг түүж бичнэ үү.

	Вансэмбэрүү (1)	Вансэмбэрүү (2)
Эхэд ямар баримт байна вэ?		
Зохиогчийн сэтгэл хөдлөл илэрсэн ямар хэсэг байна вэ?		
Эхэд ямар уран дүрслэл байна вэ?		
Ямар тайлбар, мэдээлэл байна вэ?		

д. Дээрх шинжилгээнд үндэслэн, хоёр эхийг харьцуулан дүгнэж бичээрэй. (зорилго, хэв маяг, үг сонголт, уран дүрслэл, баримт нотолгоо)

е. Вансэмбэрүү (2) эхээс дараах уран дүрслэлд тохирох жишээг олж бичнэ үү.

- адилтгал -
- тойруулал -
- хүншүүлэл -
- ...

ё. Эхээс шалтгааны утгатай холбох үг, нөхцөлөөр холбогдсон нийлмэл өгүүлбэрийг олж бичээд, ямар аргаар холбогдсоныг нь тайлбарлаарай.

а. холбох үгээр:

б. холбох нөхцөлөөр:

ж. “учраас, учир, тулд, улмаас, боловч” зэрэг холбох үгээс тохирохыг сонгон “Эрт цагт оточ маарамбууд түүнийг түүж, эмийн сор болгон тунгаар хэмжиж, өвчин эмгэгт шаналагсдыг эмнэн тэнхрүүлдэг байжээ.” гэсэн өгүүлбэрийг шалтгааны утгатай нийлмэл өгүүлбэр болгон хувирган найруулна уу.

з. “и” даалгаварт байгаа өгүүлбэрийг шалтгааны утгатай холбох үг, нөхцөлөөр холбон найруулж, нийлмэл өгүүлбэр болгоорой.

и. Эхний эхийн төгсгөлд “Энэ цэцгийн үрийг гадагш гаргахыг хориглосон байдаг аж.” гэжээ. Энэхүү цэцгийн үрийг гадагш гаргахыг хориглосны учрыг эргэцүүлэн бодоод, тайлбарлаж бичнэ үү.

VII ИЛТГЭЛ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ



Эзэмших мэдлэг, чадвар



Баримт мэдээлэл ашиглан, үр дүнтэй илтгэх



Асуудал дэвшүүлэн баталж, нотолж тайлбарлаж ярих




Баримт мэдээлэл ашиглан, үр дүнтэй илтгэх

1. Илтгэл, илтгэх чадварын талаар санал бодлоо солилцъя.

а. Дараах асуултын дагуу санал бодлоо бичиж, ярилцаарай.

- Та нарын мэдэх ямар ямар уран илтгэгч хүмүүс байдаг вэ? Тэр хүмүүст байдаг онцлог шинж юу вэ?
- Бид ярих чадварыг яагаад эзэмших ёстой вэ?
- Харилцан яриа, ганцаар ярианы ялгаа, онцлог юу вэ?
- Бусдын өмнө ярихад ямар нэг айдас, бэрхшээл тулгардаг уу? Тоочин бичээрэй.

б. Өмнөх ангидaa илтгэл тавьж байсан туршлага, бусдын илтгэл яриаг сонсож байснаа эргэн санаж, илтгэлийн тухай дараах асуултын дагуу санал бодлоо солилцоорой.



в. Саналаа солилцож, бодлоо цэгцлэн, дээрх асуултад хариулж бичнэ үү.

2. Илтгэл танилцуулах тухай ойлголтоо нэгтгэе.

а. Илтгэлийн тухай дараах мэдээллийг уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Илтгэх гэдэг нь зөвхөн уран илтгэгч, улс төрчидтэй холбоотой зүйл биш. Сурч боловсорч, ажил мэргэжил эрхэлж, хүмүүстэй харилцаж байгаа хүн бүрд тодорхой асуудлаар үг хэлэх, мэдээлэл хийх асуудал тулгарч байдаг. Энэ нь биднээс илтгэх чадвартай байхыг шаарддаг.

Илтгэх урлаг гэдэг нь ярих урлаг бөгөөд зөв сайхан ярьж чаддаг байхыг чухалчилдаг. Илтгэл гэдэг нь хүн өөрийн санаа бодол, үзэл баримтлалаа зорилго чиглэлтэйгээр бусадтай харилцан солилцох арга хэрэгсэл юм.



Илтгэлээ бэлтгэх

- Тухайн сэдвийг сонгосон шалтгаанаа олох
- Илтгэлийн зорилго тодорхойлох
- Хүрэх үр дүнгээ тооцох
- Бусдад яаж нөлөөлж, ямар үр дүн гараасай гэж хүсэж байгаагаа тодорхойлох
- Тухайн илтгэлийн сэдэв, зорилготой холбоотой олон төрлийн мэдээлэл цуглуулж судлан, тэдгээрээс чухал хэрэгцээтэй мэдээллээ нэгтгэн, дүгнэлт гаргах
- Сэдвийн дагуу асуудал дэвшүүлж, түүний талаарх мэдээлэл, үр дүнгээ ойлгомжтой, товч тодорхой боловсруулж чадвал сайн илтгэл болж чадна.



Илтгэлээ танилцуулах

- Илтгэлтэй холбоотой чухал мэдээллээ товч багтаасан танилцуулга хийх
- Танилцуулга хийхдээ сонсогчдын анхаарал, сонирхлыг татах зураг, хүснэгт, диаграмм, тулгуур үг зэргийг ашиглах
- Илтгэхийн өмнө илтгэл болон танилцуулгаа өөрийн болгож, олон дахин ярьж бэлтгэх
- Илтгэхдээ өөртөө итгэлтэй, товч тодорхой, шийдэмгий ярих
- Дуу хоолойны өндөр намыг тохируулан, сонсогчид руугаа хандан, тохирсон дохио зангаа хэрэглэн ярих
- Бусдын санаа бодлыг хүлээцтэй сонсож, асуултад сандралгүй хариулах

- Илтгэл, илтгэх чадвартай холбоотой мэдээллийг өөрийн бодолтой харьцуулж, ижил ба ялгаатай талыг гаргаарай.
- Илтгэлээ амжилттай танилцуулахын тулд хийх зүйлээ төлөвлөөрэй.

б. *Илтгэх чадварын тухай өгүүлсэн цэцэн үгсийн утга санааг тайлбарлан бичиж, ярилцаарай.*

Эхлээд мэндэлж сур, дараа нь ярьж дад, эцэст нь илтгэж чад.

Монгол ардын цэцэн үг

Юугаараа баян, түүгээрээ дайлна. Юу ч байхгүй бол яриагаараа дайлна.

Орос ардын цэцэн үг

Мэдлэг ухаан хоёр дээр суурилсан хөдөлмөр бол илтгэх урлаг мөн.

Эртний Ромын цэцэн үг

Найрагч байх нь заяаных Илтгэгч болох нь зүтгэлийнх

Эртний Ромын цэцэн үг

3. Илтгэлийнхээ сэдвийг сонгоё.

“Бид чөлөөт цагаа хэр зэрэг үр дүнтэй өнгөрүүлдэг вэ?” гэсэн сэдвээр хамтран илтгэл бэлтгэе.

а. “Бид чөлөөт цагаа хэр зэрэг үр дүнтэй өнгөрүүлдэг вэ? гэсэн сэдвийг эргэцүүлэн бодож дараах асуултад хариулаарай.

- Бидэнд тулгамдаж байгаа асуудлыг дэвшүүлсэн байна уу?
- Энэ сэдэв нь сонсогчдын (ангийнхны) сонирхлыг татаж чадах уу?
- Энэ талаар мэдээлэл цуглуулах боломж хангалттай байна уу?
- Энэ сэдвийг судалсан нь бидэнд ямар ач холбогдолтой вэ?

б. Оновчтой сэдэв сонгож чадсан эсэхээ ярилцаарай.

4. Илтгэлийнхээ зорилгыг тодорхойлъё.

Илтгэлийн зорилго гэдэг нь тухайн сэдвийг судалсны эцэст хүрэх үр дүн юм.

а. Дараах илтгэлийн зорилгыг тодорхойлохын тулд асуултад хариулаарай.

Илтгэлийн сэдэв: Бид чөлөөт цагаа хэр зэрэг үр дүнтэй өнгөрөөдөг вэ?

Энэ сэдвийг судалснаар бид юуг мэдэж авах вэ?

Мэдэж авсан зүйлээс ямар үр дүн гарах вэ?

б. Хариултуудаа нэгтгэн, дараах өгүүлбэрийг гүйцээж, зорилгоо тодорхойлъё.

..... судалж мэдсэнээр

..... үр дүнд хүрнэ.

- Зорилгоо хэрхэн тодорхойлсноо ярилцаарай.
- Хамгийн оновчтой тодорхойлсон зорилгыг сонгоорой.

САНАМЖ

Ямар ч сэдэв байсан үндсэн зорилго нь сонсогчдын сэтгэлийг сэргээх, шинэ зүйлийг мэдээлэх, итгүүлэн сэнхрүүлэх, уриалан дуудах явдал бөгөөд агуулга нь утга төгөлдөр байх ёстой. Ярианы үндсэн зорилго бол сонсогчдод хүлээн авах, асууж сонирхох, харилцан ярилцах тэмүүллийг бий болгодог.

Илтгэлийн сэдвээ сонгож, зорилгоо тодорхойлохдоо сонсогчийнхоо нас, хүйс, мэдлэг боловсрол, ажил мэргэжил, ярих сэдвийн талаарх мэдлэг, юу мэдэхийг хүсэж байгааг тодорхойлох нь чухал.

5. Илтгэлтэй холбоотой баримт мэдээлэл цуглуулъя.

а. “Чөлөөт цагаа хэр зэрэг үр дүнтэй өнгөрөөдөг вэ?” сэдвээр мэдээлэл цуглуулах аргаа хэрхэн төлөвлөснийг ярилцаарай.



б. Ярилцсанаа дараах асуултын дагуу хүснэгтэд нэгтгэн бичээрэй.

- Ямар эх сурвалжаас мэдээлэл цуглуулахаар төлөвлөсөн байна вэ?
- Мэдээллээ ямар аргаар цуглуулахаар төлөвлөсөн байна вэ?

№	Эх сурвалж (хэнээс?, хаанаас?)	Ямар аргаар (яаж?)
1		
2	Интернэт	Түлхүүр үгээр хайх
3		
4		

САНАМЖ

Мэдээллээ юунаас яаж цуглуулах вэ?

1. Сонгосон сэдвийн тухай ном, сонин, сэтгүүлд хэрхэн бичсэнийг уншиж судлах
2. Тухайн сэдвээр кино, нэвтрүүлэг үзэж гэмдэглэл хөтлөх
3. Сэдэвтэй холбоотой түлхүүр үгээр интернэтээс мэдээлэл хайх
4. Сэдэвтэй холбоотой асуулт боловсруулж, эцэг эх, найз нөхөд гэх мэт хүмүүстэй ярилцаж, санал бодлыг сонсох
5. Цуглуулсан мэдээллээс өөрт хэрэгцээтэй хэсгүүдийг ялган тэмдэглэх
6. Холбогдох зураг, график, хүснэгт цуглуулах

в. Дараах мэдээллүүдээс илтгэлд ашиглаж болох чухал баримтыг ялгаарай.

“Бид өсвөр үеийнхэн” цахим санал асуулгын үр дүнгээс

1. Чөлөөт цагаа хаана өнгөрөөдөг вэ?



Сургууль дээрээ

2. Чөлөөт цагаа хэнтэй өнгөрөөдөг вэ?



Ганцаараа 27%



Гэртээ



Найзуудтайгаа 48%



Дугуйланд



Гэр бүл ба бусад 25%

3. Чөлөөт цагаараа юу хийдэг вэ?

Судалгаанд оролцогч хүүхдүүдийн 17% нь чөлөөт цагаараа интернэт ашигладаг бол 10% нь спортоор хичээллэдэг гэсэн хариулт өгчээ. Эмэгтэй хүүхдүүд ихэвчлэн гэртээ интернэтээр аялж, ертөнцийн сонин хачин сонирхож цагийг өнгөрүүлдэг бол эрэгтэй хүүхдүүдийн хувьд спортоор хичээллэн, чөлөөт цагаа өнгөрүүлдэг гэж хариулсан байна.

Хүүхдүүд санхүүгийн бэрхшээлээс үүдэн, олон нийтийн үйлчилгээний төлбөртэй газруудаар үйлчлүүлэх, цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх боломжгүй учраас ихэнхдээ гудамж талбайгаар хэсүүчлэн, гадуур дэмий сэлгүүцдэг байдал ажиглагдаж байна. Энэ нь чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжтой газар нэн шаардлагатай илрэл юм.

Судалгааны дэлгэрэнгүйг дараах холбоосоор орж үзээрэй
<http://child.gov.mn/wp-content/uploads/2017/01>.

Нийслэлийн хэмжээнд 2015 оны байдлаар өсвөр насныханд чиглэсэн чөлөөт цаг өнгөрүүлэх 389 газар, талбай, төв байдаг гэсэн бүртгэл бий. Тодруулбал, усан спортын төв 18, чийрэгжүүлэх клуб 37, хүүхдийн зуслан 22, спорт цогцолбор 22, сургалтын төв 50, үзвэр үйлчилгээний газар 44, кино театр 7, мөсөн гулгуур 23, спорт талбай 134, өдөр өнжүүлэх 50 байдаг байна.

Нийслэлд 13-18 насны 53700 хүүхэд байгаа бөгөөд тэдний 30 хувь нь л дээрх газар, төвүүдээр чөлөөт цагаа өнгөрөөдөг гэсэн судалгаа байгаа юм.

(www.news.mn)

Хүүхдийн чөлөөт цаг

... Хүүхдийн хүсэл мөрөөдөл, зорилгодоо хүрэх замыг заан тодорхойлох гол зүйлсийн нэг бол чөлөөт цагаа өнгөрөөж буй байдал юм. Чөлөөт цаг бол завтай сул өнгөрөөх хугацаа биш өөрийгөө боловсруулж аливааг таньж мэдэхэд зориулагдсан хугацаа байх ёстой. Хүүхэд насандаа цаг хугацааг сул чөлөөтэй ашиггүй өнгөрөөх нь насан туршдаа харамсал дагуулах явдалд ч хүргэж болдог. Цаг хугацааг зөв зохистой өнгөрөөж гэмээ нь юугаар ч сольшгүй үнэт зүйл болно.

(Б.Батзаяа)

“Чөлөөт цаг буюу шүдний өвчин” нийтлэлээс

ЕБС-ийн дунд ангийн сурагчдын дунд явуулсан судалгаанд хүүхдүүд өдрийн 4-5 цагийг сургууль дээрээ, үлдсэн цагаа гэртээ, харин хувийн сургуульд суралцдаг сурагчдын хувьд сургууль дээрээ 7-8 цагийг, гэртээ үлдсэн цагаа өнгөрөөдөг гэж хариулжээ.

Цагдаагийн академийн багш нарын хийсэн судалгаагаар гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны сурагчдын 95% нь хичээлээс гадуур ямар нэгэн дугуйлан, сонгон суралцах хичээлд хамрагдаж байгаагүй гэнэ.

Эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ авьяас чадварыг нээн илрүүлэх, тэдний чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэхийн тулд дугуйланд хамруулах хүсэлтэй байдаг ч, ихэнх дугуйлан, секц өндөр төлбөртэй учраас тэр бүр өгч чаддаггүй. Сурагчид чөлөөт цагаа өнгөрөөх газаргүй учир эцэг эхийгээ байхгүйд найз нөхөдтэйгөө нийлж, гадуур сэлгүүцэх нь их байдгаас гэмт хэрэгт холбогдож, улмаар сурлага, хүмүүжлийн доголдолтой болох эрсдэлтэй.

2. Эцэг эхчүүдтэй дараах асуултын дагуу ярилцаж, мэдээлэл цуглуулаарай.

Асуулт	Хариулт
Хүүхдүүд чөлөөт цагаа ихэвчлэн хаана өнгөрөөж байна вэ?	
Чөлөөт цагаа хэнтэй өнгөрөөж байна вэ?	
Хүүхдүүд чөлөөт цагаараа юу хийж байна вэ?	
Хүүхдүүд чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрөөж чадаж байна уу?	

д. Ангийн найзуудаасаа дараах асуултаар судалгаа аваарай.

8-р ангийн сурагчдаас авах асуулга

Зорилго: Сурагчид чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлдэг талаар мэдээлэл авах

Судалгаанд оролцогчийн хүйс:

А. Чи чөлөөт цагаа ихэвчлэн хэнтэй өнгөрүүлдэг вэ?

1. найзуудтайгаа
2. ганцаараа
3. гэр бүлийнхэнтэйгээ
4. бусад

Б. Чөлөөт цагаа хаана өнгөрүүлдэг вэ?

1. сургууль дээр
2. гэртээ
3. дугуйланд
4. гадуур
5. бусад

В. Чи чөлөөт цагаараа ихэвчлэн юу хийдэг вэ? 2 хариулт сонгоорой.

1. Найзуудтайгаа уулздаг
2. Гэрийн ажил хийдэг
3. Даалгавраа хийдэг
4. Телевиз үздэг
5. Интернэтэд ордог
6. Спортоор хичээллэдэг
7. Дугуйланд явдаг
8. Тоглодог
9. Ном уншдаг
10. бусад

Г. Чи чөлөөт цагаа хэр зэрэг үр дүнтэй өнгөрөөж чаддаг вэ? Хариултаа сонгож шалтгааныг бичээрэй.

1. маш үр дүнтэй
2. ихэвчлэн үр дүнтэй
3. заримдаа үр дүнтэй
4. бараг үр дүнгүй

Шалтгаан:

Судалгаанд оролцсонд баярлалаа.

4. Цуглуулсан мэдээллээ цэгцэлж, нэгтгэн дүгнэе.

Цуглуулсан мэдээллээ нэгтгэж, дүгнэлт гаргахын тулд яах вэ?

1. Илтгэлийн зорилготой холбоотой асуултууд гаргана.
2. Цуглуулсан мэдээллээс тэдгээр асуулт бүрд холбогдох мэдээллүүдийг түүж бүлэглэнэ.
3. Бүлэглэсэн мэдээлэлд давтагдсан санааг нэгтгэнэ.
4. Нэгтгэсэн мэдээлэлдээ үндэслэн, дүгнэлт гаргана.
5. Дүгнэлтэд үндэслэн, цаашид асуудлыг шийдвэрлэх арга замын талаар санал дэвшүүлнэ.

а. Цуглуулсан мэдээллээс дараах асуултад холбогдох мэдээллүүдийг бүлэглэж цэгцлээрэй.

Асуулт	Мэдээлэл судалгаанд	Эцэг эхчүүд	Хүүхдүүд өөрсдөө
Хүүхдүүд чөлөөт цагаа ихэвчлэн хаана өнгөрөөж байна вэ?			
Хүүхдүүд чөлөөт цагаа ихэвчлэн хэнтэй өнгөрөөж байна вэ?			
Хүүхдүүд чөлөөт цагаараа юу хийж байна вэ?			
Чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлж чадахгүй байгаагийн шалтгаан юу вэ?			

б. Бүлэглэсэн мэдээллээ нэгтгэж, дүгнэлт гаргаарай.

- Асуулт бүрээр бүлэглэсэн мэдээллийг нэгтгэн гол саналуудад дүгнэлт гаргана.
Мэдээллүүдээс харахад: зүйл нийтлэг байна. Мөн байна гэж үзжээ.
Үүнээс хүүхдүүд чөлөөт цагаа
өнгөрөөж байна гэж дүгнэж байна.
- Дүгнэлтэд үндэслэн, цаашид үр дүнг сайжруулах ямар алхам хийж болох талаар санал дэвшүүлнэ. Жишээ нь:
Дээрх дүгнэлтэд үндэслэн, хүүхдүүд бид чөлөөт цагаа илүү үр дүнтэй өнгөрүүлэх дараах саналыг дэвшүүлж байна.
 1. Бид өөрсдөө хэрэгтэй.
 2. Эцэг эхчүүд ийм боломж олгох хэрэгтэй.
 3. Сургуулиас нөхцөл бүрдүүлэх хэрэгтэй.
- Хүүхэд бүр өөрийн чөлөөт цагаа өнгөрүүлж буй байдалд дүгнэлт хийж, цаашид илүү үр дүнтэй өнгөрүүлэх талаар төлөвлөгөө гаргана.

1. Илтгэлийн танилцуулга бэлтгэе.

Илтгэлийн танилцуулгыг яаж бэлтгэх вэ?

Танилцуулгаа power point программ дээр бэлтгэнэ.

1. Илтгэлийн зорилго
2. Асуулгын асуулт бүрээс гарсан үр дүн тус бүрд 1 нүүр
3. Дүгнэлт
4. Санал гэсэн нүүр бэлтгэнэ.

Тавигдах шаардлага

1. Товч тодорхой гол мэдээллээ бичих
2. Хэт олон биш 6-8 нүүр байхаар төлөвлөх
3. Сонсогчдод ойлгомжтой байх, сонирхлыг татах үүднээс мэдээллээ зураг, хүснэгт, бүдүүвч, графикаар илэрхийлэх

- а. Дээрх шаардлагын дагуу танилцуулгаа хэрхэн бэлтгэхээ төлөвлөөрэй.
 - Хэдэн нүүр танилцуулга бэлтгэх
 - Нүүр бүр дээр юуны тухай мэдээлэл байх
 - Мэдээллээ ямар хэлбэрээр илэрхийлэхээ төлөвлөх
- б. Төлөвлөгөөний дагуу илтгэлийн танилцуулгаа power point программ дээр хийж гүйцэтгээрэй. Мэдээлэл технологийн хичээлээр сурсан мэдлэгээ ашиглаарай.
- в. Бэлтгэсэн танилцуулгаа дараах шалгуураар үнэлээрэй.

№	Шалгуур	Тэмдэглэл
1	Илтгэлийн агуулгыг бүрэн багтаасан байна уу?	
2	Мэдээллээ оновчтой аргаар илэрхийлсэн байна уу?	
3	Энгийн ойлгомжтой, товч байж чадаж байна уу?	
4	Сонирхол татах, зураг, хүснэгт, график, бүдүүвч гэх мэтийг оновчтой ашигласан байна уу?	

- г. Илтгэлийн танилцуулгыг сайжруулах саналаа жишээ баримттайгаар хэлээрэй.

2. Илтгэлээ найзууддаа танилцуулья.

Яаж өөртөө итгэлтэй ярьж илтгэх вэ?

1. Илтгэлээ маш сайн бэлтгэж, өөрийн болгосон байна.
2. Өөртөө итгэлтэй, тод чанга, зогсоц, хэмнэлтэй, шийдэмгий ярина.
3. Дэлгэцээр харуулж буй мэдээллээ цөөн үгээр тодорхой тайлбарлаж ярина.
4. Нарийн учир шалтгаантай зүйлийг дэлгэрүүлэн тайлбарлаж ярина.
5. Дууныхаа өндөр намыг тохируулан, сонсогчид руугаа хандан ярина. Тохирсон дохио зангаа хэрэглэнэ.
6. Сул үг хэрэглэхээс зайлсхийгээрэй.

5. Илтгэлийг сонсож, санал бодлоо солилцох



Илтгэл хэлэлцүүлэх үед сонсогчид өөрийн үзэл бодлыг илэрхийлэх хэрэгтэй байдаг. Үүний тулд илтгэлийг анхаарч, өөрийн үзэл бодолтой харьцуулан сонсох нь чухал.

а. Илтгэлийг анхаарч сонсьё.

Сонсох явцдаа

- Сэдвийн талаарх үзэл бодлоо дүгнээрэй.
- Илтгэгчээс тодруулж асуумаар зүйлээ тэмдэглээрэй.
- Юуг санал болгон хэлэхийг хүсэж байгаагаа тодорхой болгож, шаардлагатай зүйлийг тэмдэглээрэй.
- Илтгэгч болон танилцуулгыг анхаарч, ойлгож байгаагаа толгойгоо дохих зэргээр илэрхийлж сонсоорой.

б. Илтгэлийн талаар ярилцаж, саналаа солилцъё.

Сонссоны дараа




- Тодруулах зүйлээ эелдгээр асуугаарай.
- Саналаа үндэслэлтэй хэлээрэй.

в. Баг болж, дараах асуултын дагуу илтгэлийн тухай ярилцъя.

- Энэхүү илтгэлд юуны тухай ярьсан бэ?
- Хамгийн чухал санаа нь юу байсан бэ?
- Илтгэлд дэвшүүлсэн, чамайг итгэхэд хүргэсэн гол санаа нь юу байсан бэ?
- Илтгэлийн агуулга, үр дүнгийн талаар чи юу гэж бодож байна вэ?
- Илтгэгч илтгэлийнхээ агуулгыг ойлгомжтой ярьж чадсан уу? Ярих чадварыг нь хэрхэн үнэлж байна вэ?
- Илтгэлд орхигдсон, зайлшгүй тусгах өөр санаа үлдсэн үү?

Өөрийгөө сорьё.

а. Дараах сэдвээс аль нэгийг эсвэл өөрийн сонирхсон сэдвийг сонгоорой.

Телевиз бидний амьдралд ямар нөлөөтэй вэ?	Бид гар утсыг ямар зорилгоор хэрэглэж байна вэ?
	
Бид ямар ном уншдаг вэ?	Чиний сонгосон сэдвийн нэр
	?

б. Сонгосон сэдвээ дараах шалгуураар үнэлээрэй.

Шалгуур	Тийм	Үгүй
Бидэнд тулгамдаж байгаа асуудлыг дэвшүүлсэн байна уу?		
Энэ сэдэв нь сонсогчдын сонирхлыг татаж чадах уу?		
Энэ талаар мэдээлэл цуглуулах боломж хэр байна вэ?		
Энэ сэдвийг судлах нь бидэнд ач холбогдолтой юу?		

в. Дээрх шалгуурт нийцэхгүй бол тохирох өөр сэдэв сонгоорой.

г. Хүснэгт дэх асуултад хариулж, илтгэлийн зорилгоо тодорхойлоорой.

Энэ сэдвийг судалснаар бид юуг мэдэж авах вэ?	
Мэдэж авсан зүйлээс ямар үр дүн гарах вэ?	
Зорилго:	
.....	

д. Илтгэлтэй холбоотой мэдээллээ ямар эх сурвалжаас ямар аргаар цуглуулахаа төлөвлөөрэй.

е. Төлөвлөгөөний дагуу мэдээллээ цуглуулаарай.

ё. Цуглуулсан мэдээллээ бүлэглэн нэгтгэж, дүгнэлт гаргаарай.

ж. Илтгэлийн танилцуулгаа өмнө үзсэн шаардлагад нийцүүлэн хийгээрэй.

з. Илтгэлээ танилцуулаарай.

и. Илтгэлийн талаар санал бодлоо солилцоорой.

**Эзэмших мэдлэг, чадвар**

Эхэд дэвшүүлсэн асуудал, шалтгаан, үр дагаврын холбоо хамаарлыг тодорхойлж загварчлах

Асуудлыг жишээ баримтаар баталж уялдаа холбоотой тайлбарлаж бичих

Өгүүлбэр зүйд холбогдох дүрмийг зөв хэрэглэх

Эхэд дэвшүүлсэн асуудал, шалтгаан, үр дагаврын холбоо хамаарлыг тодорхойлж загварчлах

1. Эхийг уншиж, шалтгаан, үр дагаврыг ялгая.

а. Дараах эхэд өгүүлэгдэж байгаа зүйлийн шалтгаан ба үр дагаврын талаар эргэцүүлж, өмнөх мэдлэгээ сэргээнэ үү.

Цэвэр агаар яагаад хэрэгтэй вэ?


(1) Цэвэр агаар бол эрүүл явах үндэс юм.

(2) Агаар нь хүний бие махбодыг хүчилтөрөгчөөр хангаж, бодисын солилцоо, биеийн дулааныг зохицуулдаг.

Хүн хоол хүнсгүйгээр нэлээд хэд хоног амьдарч, усгүйгээр хэдэн цаг байж чаддаг бол агааргүйгээр хэдхэн хором л амьд байж чадна.




б. Дээрх эх дэх өгүүлбэрийн аль нь үр дагавар, аль нь түүний шалтгааныг илэрхийлсэн бэ? Ярилцаад, холбоо хамаарлыг нь зураглан үзүүлнэ үү.



- в. “Агаарын бохирдол ба эрүүл мэнд” эхэд дэвшүүлсэн асуудал, түүний шалтгаан, үр дагаврыг олж уншъя. Үүний тулд дараах эхэд асуудлыг яаж илэрхийлснийг анхаарч уншаарай.

Агаарын бохирдол ба эрүүл мэнд

Улаанбаатар хот нь өвлийн улиралд агаарын бохирдлын хэмжээгээр дэлхийд дээгүүр орж байгаа нь иргэн бүрийн санааг зовоож байна. Улаанбаатар хотод хүн амын төвлөрөл, үйлдвэр, авто машин, гэр хорооллын тоо нэмэгдэж байгаагаас агаарын бохирдол хоёр дахин нэмэгдэж, иргэдийн эрүүл мэндэд сөргөөр¹ нөлөөлөх хэмжээнд байна.



Судлаач Б.Бурмаа, Н.Сайжаа² нар Улаанбаатар хотын агаар дахь тоос, хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу ислийн агууламж нь хүүхдийн гуурсан хоолойн цочмог болон архаг үрэвсэл, уушгины үрэвслийн нэг шалтгаан болж буйг судлан тогтоожээ. Хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлж байгаа нөлөөллийг судлан үзэхэд уушгины багтаамж багасах, артерийн бага даралт хэвийн бус болох, судасны цохилт цөөрөх, зүрхний булчин агших, зүрхний цохилт олшрох, цөөрөх зэрэг өөрчлөлт илэрсэн байна. Энэ бүхнээс Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах нь өнөөдрийн хувьд хамгийн тулгамдсан асуудлын нэг болсныг харуулж байна.

Агаарын бохирдол гэж юу вэ?

Агаарын бүтэц, шинж чанар өөрчлөгдөх буюу атмосферийн агаар мандалд ялгарч байгаа хатуу, шингэн, хийн хольц, биологийн биетийг агаарын бохирдол гэдэг. Агаарын бохирдол үүсгэдэг хоёр эх үүсвэр байна. Нэг нь галт уул дэлбэрэх, уулын чулуулаг элэгдэх, ургамал хэт их цэцэглэх (хогийн ургамал гэж нэрлэдэг шарилж, лууль), түймрийн утаа зэрэг байгалийн хүчин зүйлээс үүдэлтэй бол нөгөө нь хүний үйл ажиллагаатай шууд холбоотой.


Нийслэлийн агаарын бохирдлын эх үүсвэрийн талаарх судалгаанаас авч үзвэл:

- Гэр хорооллын яндангийн утаа 80 хувийг
- Дулааны цахилгаан станцын утаа 5-6 хувийг
- Авто машины утаа, угаарын хий 10 хувийг
- Бусад эх үүсвэрээс ялгарч буй утаа, тоосжилт 4 хувийг тус тус эзэлж байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлын гол эх үүсвэр болох түүхий нүүрсний хэрэглээ нь жилд 5,9 сая тонн бөгөөд үүнээс гэр хороололд 10 хувийг нь хэрэглэж байгаа боловч агаарт ялгаруулж байгаа бохирдлын 80 хувийг эзэлж байна.

Агаарын бохирдол хүний эрүүл мэндэд ямар сөрөг нөлөө үзүүлдэг вэ?

Агаарт хуримтлагдсан хар тугалга нь хүний бараг бүх эрхтэн, тогтолцоонд сөрөг нөлөө үзүүлдэг, орчныг бохирдуулагч хортой бодис юм. Энэ нь мэдрэл, бөөр,



1. ДЭМБ-ын судалгаагаар

2. Б.Бурмаа (1998, 2001), Н.Сайжаа (1992, 2004)

цус бүтээх, нөхөн үржихүйн тогтолцоонд нөлөөлж, хүүхдийн өсөлтийг удаашруулдаг. Хар тугалгыг мэдрэлийн хор гэж нэрлэдэг бөгөөд хүүхдийн тархины хөгжлийг саатуулах аюултай.



Агаарын бохирдлоос эрүүл мэндээ яаж хамгаалах вэ?

Амны хаалт хэрэглэж хэвших. Өвөл амны хаалт байнга хэрэглэж хэвшсэнээр агаарын бохирдлоос тодорхой хэмжээнд өөрийгөө хамгаална. Ялангуяа, агаарын бохирдол хамгийн их байдаг өглөө, оройд, мөн дулаан гэрээс гарах үед амны хаалт зүүж байх хэрэгтэй.

Илчлэг сайтай хоол хүнс хэрэглэх. Илчлэг сайтай хоол хүнс хэрэглэж, дархлаа сайтай байх нь элдэв өвчин тусахаас сэргийлнэ. Насанд хүрсэн хүн хоолныхоо дараа өдөр бүр С витамин ууж байвал уушгины өвчлөлөөс сэргийлэх нэг арга болно.

Агаар цэвэршүүлэх төхөөрөмж тавих. Гэртээ болон ажлын байранд агаар цэвэршүүлдэг олон төрлийн аппарат, төхөөрөмжөөс сонгон авч хэрэглэж болно.

Анги танхимын агаарыг байнга сэлгэн, цэвэршүүлж байх. Олон хүний амьсгал, тоос шороо, бүгчим байдал зэргээс өрөөний агаар бохирддог.

Гэр орны цэвэрлэгээнд анхаарах. Гэртээ цэвэр агаар оруулах, чийгтэй цэвэрлэгээ хийх, гэр хорооллын айлууд хог болон муу усаа зориулалтын саванд хийх, ил бие засахгүй байх хэрэгтэй. Өвлийн улиралд цонхоо онгойлгох боломжгүй бол тасалгааны агаар чийгшүүлэгч ажиллуулж болно.

2. Эхийн утга санааг ойлгож, ярилцъя.

Дараах асуултын дагуу эхийн агуулгыг ярилцана уу.

- Эхэд ямар асуудал дэвшүүлсэн бэ?
- Асуудал ямар ямар шалтгааны улмаас үүсэж байна вэ?
- Агаарын бохирдол хүний эрүүл мэндэд ямар сөрөг нөлөө үзүүлдэг вэ?
- Асуудлыг шийдэх ямар ямар арга замыг санал болгосон байна вэ?

3. Эхийн бүтэц, агуулгад задлал хийж, нэгтгэн дүгнэе.

а. Дараах асуултад хариулаарай.

- Эхэд судлаач Б.Бурмаа нарын судалгааг ямар зорилгоор ашигласан бэ?
- Асуудлын шалтгааныг тайлбарлахдаа ямар баримт ашигласан байна вэ?
- Яагаад “... түүхий нүүрсний хэрэглээ нь жилд 5,9 сая тонн бөгөөд үүнээс гэр хороололд 10 хувийг нь хэрэглэж байгаа боловч агаарт ялгаруулж байгаа бохирдлын 80 хувийг эзэлж байна.” гэсний учрыг юу гэж бодож байна вэ?

б. Асуудал дэвшүүлсэн эх мөн үү? Дараах тодорхойлолтыг уншаад, дүгнэлт гаргаарай.

Асуудал дэвшүүлсэн аль ч эхэд дэвшүүлэн тавьж буй асуудлын үүсэх шалтгаан, түүнээс гарах үр дагаврыг таамаглаж, шийдвэрлэх арга замыг тодорхойлсон байдаг.

3. Эхэд задлал хийж, асуудлын шалтгаан, үр дагаврыг ялгаж уншъя.

- а. Эхийг дахин уншиж, дараах асуудлын хоорондын уялдаа холбоог ярилцана уу.
- Эхийг олон нийтэд зориулж бичсэн гэдгийг батлах ямар ямар баримт байна вэ? Гурваас доошгүй жишээгээр тайлбарлаарай.
 - Эхэд ашигласан мэргэжлийн үг хэллэг, нэр томъёог түүж бичнэ үү.
- б. Агаарын бохирдол ба түүний шалтгаан, үр дагаврын холбоо хамаарлыг харуулсан зургийг ажиглаарай.
- Эхийн агуулга ба зургийг харьцуулан ярилцана уу.
 - Энэ гинжин холбоо цаашид яаж үргэлжилж болохыг эргэцүүлж бодоорой. Өөрөөр хэлбэл, агаарын бохирдлоос шалтгаалсан өвчлөл нэмэгдсэн (сөрөг үр дагавар) нь өөр ямар үр дагавар дагуулж болохыг тайлбарлана уу.
 - Энэ гинжин холбоог цааш нь үргэлжлүүлэн зурж, товч тайлбар бичээрэй.



Асуудлыг жишээ баримтаар баталж уялдаа холбоотой тайлбарлаж бичих

Бичихдээ дараах шаардлагыг харгалзан бичээрэй.

- Хэнд зориулсан нь тодорхой байх
- Сонгосон сэдвийн хүрээнд бичих
- Баримт, жишээ оруулсан байх
- “учраас, тул”, “иймээс”, “ийм учраас” зэрэг холбох үг хэрэглэсэн байх
- Мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодлоо илэрхийлсэн байх


1. Бичих алхмын дагуу ажиллая.

Алхам 1. Бичих сэдвээ зөв ойлгох, олох. Байгаль, нийгэмд тулгамдаж байгаа олон асуудлаас аль нэгийг нь сонгоно уу. Хэрэв танд тусгайлан сонгосон сэдэв байхгүй бол дараах сэдвээс сонгож болно.


- Усны хомсдол
- Үерхэл нөхөрлөл
- Цахим хэрэглээ
- Ой модны хэрэглээ
- Цөлжилт
- Цаг агаарын өөрчлөлт
- Хөрсний бохирдол

Алхам 2. Бичих төлөвлөгөө нарийвчлан гаргах


Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэгт ямар мэдээллийг оруулахаа төлөвлөнө.



Алхам 3. Бичих асуудлыг судалж, холбогдох баримт, мэдээлэл цуглуулаарай.



Алхам 4. Цуглуулсан баримт, мэдээллээ бүлэглэж, эхийн хэсгүүдэд алийг нь байрлуулахаа шийдээрэй. Эдгээрийн уялдаа холбоог дараах маягаар зураглаж болно.



- Цаасны голд дэвшүүлсэн асуудлыг бичнэ. Цөөн үг, богино өгүүлбэрээр бичиж болно.
- Асуудлыг үүсгэж байгаа шалтгаан ба үр дагавар, шийдвэрлэх санааг тус тусад нь бичнэ. Асуудлын шалтгаан, үр дагаврыг аль болохыг өргөжүүлэхийг хичээх хэрэгтэй.
- Бичсэн зүйлийн холбоо хамаарлыг эргэцүүлж, шууд холбоотой гэж үзвэл хооронд нь шугамаар холбож бас болно.
- Ижил төстэй мэдээллийг нэгтгэж, дүгнэлт хийгээрэй.

Алхам 5. Төлөвлөгөөний дагуу бичээрэй. Дээрх зураглал нь санаагаа шууд бичихэд хөтөч болно.

- Эхлэл хэсэгт дэвшүүлсэн асуудлаа тодорхойлж, юу юуг үндэслэснээ тайлбарлаж бичнэ.
- Гол хэсэгт энэ асуудал юу юунаас бий болсон, эдгээрээс ямар үр дагавар гарахыг таамаглаж бичнэ.
- Төгсгөл хэсэгт асуудлыг шийдвэрлэх ямар ямар арга замыг санал болгож байгаагаа бичнэ.

Алхам 6. Бусдад уншуулж, зөвлөгөө аваарай.

- Бичиж дуусаад, ангийнхаа хэн нэгэнд уншуулж, эсвэл өөрөө уншиж өгч, сайжруулах санал, зөвлөгөөг нь аваарай. Гэрийнхээ хэн нэгнээс ч зөвлөгөө авч болно.

Алхам 7. Зохиосон эхийн хэл найруулгыг засаж бичээрэй. Бусдын өгсөн зөвлөгөөг тусган бичнэ. Мөн зөв бичгийн дүрмийн болон найруулгын алдааг дахин хянаж, засна.

Алхам 8. Эхийг эцэслэн бичээрэй. Эхийг цэвэр цаасан дээр, эсвэл дэвтэр дээрээ сийрүүлэн бичнэ. Эхийн утгыг тодруулсан зураг, бүдүүвч зэргээр баяжуулж болно.

Өгүүлбэр зүйд холбогдох дүрмийг зөв хэрэглэх

а. Дараах нийлмэл үгсийг том ба жижиж үсгээр эхлэн бичсэнийг ажиглаад дүгнэлт гаргаарай.

Нэгдсэн Үндэстний байгууллага, Дэлхийн Байгаль Хамгаалах Сан, Монгол Улс, Оросын Холбооны Улс, монгол хүн, хятад цай, орос гурил, Оросын газар нутаг, Монголын тамирчид, Нийслэлийн боловсролын газар, Баянзүрх дүүрэг, Баян-Өндөр сумын дунд сургууль, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам, Шинжлэх Ухааны Академи, Хэл зохиолын хүрээлэн, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль, Орхон аймгийн Баян-Өндөр сум, Боловсролын хүрээлэн, монголчууд, япончууд, Европ тив, Зүүн Өмнөд Ази

б. Дараах өгүүлбэрт таслал ямар үүрэгтэйг ярилцаарай.

Тогоо цай чанав.

Тогоо, цай чанав.

Бид хоёр сонин ном уншлаа.

Бид, хоёр сонин ном уншлаа

Бид, хоёр сонин, ном уншлаа

Мөнх хөх тэнгэртээ залбиран мөргөв.

Мөнх, хөх тэнгэртээ залбиран мөргөв.

в. Хос үгээс тохирохыг цэгийн оронд сонгож бичнэ үү. Бичихдээ том үсэг, цэг тэмдгийг зөв хэрэглээрэй.

- Нөхөд өө/нөхдөө: ажлаа амжилттай дуусгасанд баяр хүргэе.
- Сурагчид аа/сурагчдаа: Амжилт гаргасан магтя.
- Зочид оо/зочдоо: Эрхэм хүндтэй хоймроо залж, “Хүндэт” хэмээн баяр наадмыг эхлүүлэв.


г. Хүснэгтэд байгаа мэдээллийг ашиглан асуух өгүүлбэрүүд зохиож бичээрэй. Ямар асуух үгийг олон хэрэглэснийхээ учрыг тайлбарлаарай.

Даваа	Шатрын дугуйлан хичээллэдэг учраас Цэлмэгт хамгийн чухал бөгөөд хариуцлагатай өдөр байдаг.
Мягмар	Сургуулийн дунд насныхан нийгмийн тустай сайн үйлсийн төлөөх аянд нэгддэг өдөр.
Лхагва	8а бүлгийн сурагчид хамгийн олон цагийн хичээлд суудаг.
Пүрэв	Ангийн хурал хийнэ.
Баасан	Сургуулийн орчин болон анги танхимд их цэвэрлэгээ хийдэг хуваарьт өдөр.

д. Аль үгийг бичихэд амаргүй байна? Ярилцаарай.

	Үг	Жишээ	Дүрэм
Асуух үг	бэ? вэ?	Ямар олон хав ...?, Яасан өргөн гол ...? Хэн юм ...? Хэдэн он ...? Хэн хэлэх ...? Яасан байх нь ...?	м, л, н, в-ээр төгссөн үгэнд “бэ”, бусад тохиолдолд “вэ” асуух үгийг бичнэ.
	уу? үү? юу? юү?	Явсан ...?, ирсэн ...? Хонь ..., ямаа ...? Малгай ..., бээлий ...?	Урт хос эгшгээр төгссөн үгэнд “юу, юү”, бусад тохиолдол “уу, үү” асуух үгийг эгшиг зохицох ёсыг баримтлан, өмнөх үгээс салангид бичнэ.
Батлах үг	л, ч, шүү	Сайн ... явж байна. Өвс ... их ургажээ. Яг одоо хөдөлнө ...	“л, ч, шүү” батлах үгийг өмнөх үгээс салангид бичнэ.
	даа, дээ, доо дөө	авна ... ирнэ ... очно ... өгнө ...	“даа, дээ, доо, дөө” батлах үгийг эгшиг зохицох ёсыг баримтлан, өмнөх үгээс салангид бичнэ.
Дуудах үг	аа, ээ, оо, өө	Багш аа, хүүхдүүд ээ, нөхөд өө, охид оо	Дуудах үгийг эгшиг зохицох ёсыг баримтлан, өмнөх үгээс нь салангид бичнэ.
Идэвхгүй нөхцөл	-(а)сан ⁴ -(а)даг ⁴	Их л зовж явсан сан, өгсөн дөг.	

е. Цуваа цэгийг эх, өгүүлбэрт хэрэглэх дүрмийг тохирох жишигтэй нь харгалзуулаарай.



Өгүүлбэр төгсөөгүй буюу өгүүлбэрийн дунд орхисон үгийн оронд цуваа цэг бичнэ.	Ертөнц эргэсээр л...
Өгүүлэгч этгээдийн ээрч түгдэрсэн хэсэгт цуваа цэг бичнэ.	“...үгийн гол буюу үндсэн утга нь тэр үгийн бүхий л санаа, утгыг хэлхэн холбосон байдаг...”
Эш татаж бичихдээ орхисон эсвэл тасалж авсан хэсгийг тэмдэглэхэд цуваа цэг бичнэ.	Би хэзээ..., хэзээ ч тэгж хэлээгүй.
Үг, өгүүлбэр төгссөн хэдий ч бичигч, өгүүлэгч хэлэх гэсэн санаагаа бүрэн гүйцэд гаргаагүй дутуу орхисон бол төгсгөлд нь цуваа цэг бичнэ.	Харанхуйд лам багш ихэд айн “чи Ундрахын...” гэж чичирхийлсэн дуугаар хэлэв. (Л.Б)

1. Эхийг уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.**Ус хамгийн их нууц агуулсан шингэн***Яагаад усыг чандмань эрдэнэ гэдэг вэ?*

Ус нь бие махбодын 70-80 хувийг эзэлнэ. Уураг тархины 90 хувийг бүрдүүлнэ. Бие махбодын бүх эсийг сэргээж, энергиэр тэтгэнэ. Хүч тамирыг сэргээж, ядаргааг тайлна. Цангааг хамгийн сайн тайлна. Хөдөлмөрлөх чадварыг дээшлүүлж, анхаарлын төвлөрлийг сайжруулна. Бүх төрлийн хүнсний зүйлийн хамгийн их уусгагч болно. Хамгийн шилдэг эм болдог. Усыг хэзээ, ямар хэмжээгээр уухаа тохируулбал илүүдэл жингүй, гоолиг байна. Хөгшрөх явцыг хянаж, арьсыг эрүүл, толигор байлгана. Харшил, багтрааг анагаах хамгийн ердийн арга болно. Мэдээжийн ийм их “хүч чадал” усанд байдаг учраас түүнийг эрдэнэтэй зүйрлэхээс өөр яах билээ.

Тэгвэл ус ямар бүтэцтэй бол?

Ус л бол ус гэж ойлговол буруу. Харин зөв бүтэцтэй ус л биед шим тэжээлийг хүргэж чаддаг онцлогтой болохыг ХХI зууны зааг дээр эрдэмтэд тогтоогоод байна. Бүтцийн хувьд байгаль дэлхийд 140 гаруй төрлийн ус, 200 гаруй төрлийн мөс байдаг аж. Эдгээрээс байгалийн гайхамшигт зүй тогтлын дагуу үр удмаа хэвлийдээ тээж байгаа эхийн эхсийн ус, эрүүл хүний эсийн цитоплазмын ус хоёр хамгийн зөв бүтэцтэй байдгийг эрдэмтэд тогтоожээ. Зөв бүтэцтэй усны молекулын бүтэц нь зөв зургаан талст хэлбэртэй байдаг ажээ. Ийм бүтэцтэй усны биоэнергийг шингээх чадвар хамгийн сайн бөгөөд шим тэжээлийг эсийн түвшинд хүргэдэг байна.

Хүн яагаад өвддөг вэ?

Сүүлийн гучаад жил усны физиологийн үүргийг судалж буй эрдэмтдийн дүгнэлтээс үзвэл:

1. *Бие сульдах.* Тархины цусан хангамж нь эсэд хэрэгцээтэй усыг өгч чадахгүй бол толгой өвдөж, бие сульдаж эхэлнэ. Тархины эсүүдийн байнгын ажиллагааны явцад үүссэн бодисын солилцооны хаягдал, хорт нэгдлүүдийг байнга зайлуулж байх шаардлагатай. Энэ үүргийг ус гүйцэтгэнэ.
2. *Ядрах.* Бие махбодод хоол бус ус нь энергийн эх үүсвэр болдог байна. Хоол боловсрох явцад хоол хүнс нь уснаас энерги авдаг тул үүнд гайхах хэрэггүй.
3. *Таргалах.* Илүүдэл жин нь даралт ихсэх, зүрхний гажиг, чихрийн шижин, цус, цөсний хүүдий, үений үрэвсэл зэрэг олон төрлийн өвчний эх үүсвэр болдог байна. Ус нь хүний бие дэх өөх тосны зүйлийг задалдаг. Хэрэв ус дутагдвал өөх задрахгүй, илүүдэл жин болж хуримтлагдана.
4. *Өвдөх, хавдартай болох.* Толгой, үе мөч өвдөх зэрэг аливаа өвдөлтийг тухайн эрхтний эсээс өгч байгаа “Би үхэх гэж байна” гэдэг дохио хэмээн

1. эрдэмтэд үзэж байна. Хэрэв энэ үед усны дутагдлыг нөхөхгүй бол бодисын солилцооны гажуудал даамжирсаар өвчин үүсэх, архагших, улмаар эрүүл эс хавдрын эс болон хувирах нөхцөл болдог.

Унасан газар, угаасан ус ямар нөлөөтэй вэ?

Монголчууд “Унасан газар, угаасан ус” хэмээн төрсөн нутаг усаа шүтдэг. Насны доройтол, сүлд хийморио сэргээхийн тулд төрсөн гэрийнхээ буурин дээр хөрвөөдөг. “Эхтэй хүн үхдэггүй” хэмээн алс холын аян, хүнд хүчир албанд явахдаа эхийнхээ усыг замбаа, ётонд шингээн, сахиусандаа нандигнан авч явдаг. Өвдөж зовсон хамгийн хүнд үед түүнээсээ хүртэж, сэргэдэг байжээ.

Харин энэ бүхэн нь бидний амьдарч буй орчин, амь мандал (биосфер) энергийн шингээлттэй холбоотой болохыг орчин үеийн шинжлэх ухааны судалгаагаар ХХI зууны босгон дээр нотолсон юм. Байгаль дахь түмэн бодисын дундаас ус хамгийн их био энерги шингээдэг нэгдэл юм байна. Биоэнерги шингээнэ гэдэг нь тодорхой давтамжтай цахилгаан соронзон долгионтой хэлбэлзэж байна гэсэн үг. Ийм учраас эхийн үрээ гэсэн санаа бодол үр хүүхдэд дамждаг, төрсөн нутгийн энерги хүмүүний биеийг сэргээн цэнэглэдэг ажээ.

Ийнхүү ус нь зөвхөн ундааслыг тайлагч, идэж уусан зүйлийг зөөвөрлөдөг бүс үнэхээр биологийн идэвхт нэгдэл болох нь сүүлийн хориод жилд эрдэмтэн судлаачдын бүтээлээс тодорхой харагдаж байна. (Ж.Алимаа)

а. Дараах асуултад хариулж, ярилцана уу.

- Яагаад усыг чандмань эрдэнэ гэдэг вэ?
- Ус хүний эрүүл мэндэд ямар ач тустай вэ?
- Усны ач холбогдлыг эхэд байгаа баримтыг ашиглан тайлбарлана уу.
- Эмнэлгийн тусламж, тарилгын шингэний хэмжээ өссөн үзүүлэлт юуг харуулах вэ?
- “Эхтэй хүн үхдэггүй” гэсэн хэлцийн учрыг тайлбарлана уу.
- Усны ач холбогдол ба усны нөөцийн хомсдол хоёрыг эргэцүүлэн, дүгнэлт гаргана уу.
- Усны нөөцийг хамгаалж, зөв хэрэглэх талаар цаашид юу хийх хэрэгтэй вэ?

б. Эхэд байгаа баримтуудыг бүлэглээрэй. Эдгээрийг ямар зорилгоор ашигласан бэ?



- в. Эхийн дөрвөн хэсэг тус бүрийг дахин анхааралтай уншаад, тус бүрийн гол санааг нэг өгүүлбэрт багтаан бичээрэй.
- Усыг эрдэнэтэй зүйрлэхэд хүргэсэн хүч юутай холбоотой вэ?
 - Яагаад “Ус л бол ус” гэж ойлгох нь буруу вэ?
 - Усны хүний биед гүйцэтгэдэг дөрвөн үүрэг юу вэ?
 - Монголчууд унасан газар, угаасан усаа яагаад шүтдэг вэ?
- г. Эхийн гурав дахь хэсэгт ус дутагдсанаас үүдэх үр дагавар ба тэдгээрийн шалтгааныг тайлбарласан байна. Дараах хүснэгтэд тохирох хэсгийг эхээс ялган бичнэ үү. Дараа нь эдгээрийг нэг өгүүлбэрт багтаан дүгнэн тайлбарлаж бичнэ үү.

	Үр дагавар (Шалтгаанаас үүдэн бий болсон зүйл)	Шалтгаан (Аливаа зүйл бий болох нөхцөл)	Дүгнэлт
1			
2			
3			
4			

- д. “Ийнхүү ус нь зөвхөн ундааслыг тайлагч, идэж уусан зүйлийг зөөвөрлөдөг бус үнэхээр биологийн идэвхт нэгдэл болох нь сүүлийн хориод жилд хийсэн эрдэмтэн судлаачдын бүтээлээс тодорхой харагдаж байна.” гэсэн дүгнэлтэд бичигчийн илэрхийлсэн гол санаа, хандлагыг тодорхойлно уу.
- е. Эхэд “цитоплазм, молекул, био энерги, физиологи, клиник, биосфер, энерги” зэрэг гадаад үг ямар үүрэгтэйг тайлбарлаарай.

Дараах хэл зүйн даалгаврыг гүйцэтгэнэ үү.

- а. Дараах нийлмэл үгсийн бүтээн аргыг ажиглаад угсарсан ба зэрэгцсэн нийлмэл үгийг ялгаж бичнэ үү.

хүч тамир, үр удам, зүрхний гажиг, үе мөч, өөх тос, чихрийн шижин, шим тэжээл, бодисын солилцоо, зүй тогтол, сүлд хийморь, сэргээн цэнэглэх, цусан хангамж, хорт нэгдэл, цөсний хүүдий, үр хүүхэд

- б. Дээрх эхийн хэсэг бүрээс нэг нэг шалтгааны утгатай өгүүлбэр олж, хоёр өгүүлбэр ямар аргаар холбогдсоныг тайлбарлана уу.
- в. Дараах өгүүлбэрийн утга санааг алдуулахгүйгээр байрыг нь сольж бичнэ үү. Өгүүлбэрт онцолсон холбох хэрэглүүр яаж өөрчлөгдөж байгааг тайлбарлаарай.
- Усыг хэзээ, ямар хэмжээгээр уухаа тохируулбал илүүдэл жингүй, гоолиг байна.
 - Мэдээжийн ийм их “хүч чадал” усанд байдаг учраас түүнийг эрдэнэтэй зүйрлэхээс өөр яах билээ.


- Тархины цусан хангамж нь эсэд хэрэгцээтэй усыг өгч чадахгүй **бол** толгой өвдөж, бие сульдаж эхэлнэ.

Хоёр зүйл зарааны талаарх мэдээллийг харьцуулаад, дүгнэж бичнэ үү.

Асуулт	Столичкийн замба зараа	Хималайн Алтайн шинэ салбар зараа
Сүүлний үе	Сүүлний үе тус бүр дөрвөн эгнээ цагираглаж тогтсон хайрстай.	Сүүлний үе тус бүр гурван эгнээ цагираглаж тогтсон хайрстай.
Дээд уруул	Дээд уруулын хайрсны тоо ихэвчлэн 14 байдаг.	Дээд уруулын хайрсны тоо ихэвчлэн 11-16 байдаг.
Дээд уруулын хайрсны тоо	Нүднээс арагш орших дээд уруулын хайрсны тоо ихэвчлэн 7-9 байдаг.	Нүднээс арагш орших дээд уруулын хайрсны тоо ихэвчлэн 6-8 байдаг.
Сүүл	Сүүл харьцангуй урт.	Сүүл харьцангуй богино.
Сүүлний хайрсны цагираг	Сүүлний хайрсны цагиргийн нийт тоо 153-157 байдаг.	Сүүлний хайрсны цагиргийн нийт тоо 113-140 байдаг.
Дүгнэлт		

2. Эхийг уншихдаа зохиогч мэдрэмж, сэтгэл хөдлөлөө оруулж бичсэнийг анхаарч уншаарай.

Цам харай



Тогоруу гэдэн гэдэн алхана. Газар цөмлөчих вий гэж ийнхүү гэтэж явдаг гэж хүмүүс дооглодог юм. Усны шувуу гэх боловч ихэвчлэн тал, хээр нутагт тааралддаг. Үүр ноохойд нь дөхөж очиход гүйж ирээд, далавчаа дэвсэн тонголзон бөхөлзөж, ая тал засах нь зөөлөн сэтгэлт хүнийг зүг чигээ өөрчлөхөөс аргагүйд хүргэдэг. Ихэвчлэн хоёр өндөг гаргана. Монголчууд үр хүүхдэдээ "Шувууны үүрэнд сүүдрээ бүү хүргэ. Эх нь тоохоо больж, хүүхдүүд нь харангадаж үхдэг"

гэж сургадаг бөлгөө. Басхүү тогорууны үүрийг нь сандаачиж, өндгийг нь няцалбал төмөр дөрөө сэтэртэл хараадаг гэдэг.

Тогоруу ихэвчлэн ургамлын гаралтай зүйлээр хооллох боловч шавж, авгалдайг ч бас иднэ. Намар тариа боловсрох үед тариан түрүүгээр хооллох нь ихэснэ. Тариан талбай үтрэм бараадаж, хэдэн зуугаараа цуглардаг юм.

Өдрийн аагим халуун эхлэхэд шонгийн модны сүүдэрт эцэг эх шувуу хоёр бор дэгдээхийн хамт сүүдэр даган цувраад жагсчихсан байгаа харагддаг. Хэд хоногийн халуунд чив чимээгүй байснаа гэнэтхэн нэг өдөр агаарт

эргэлдэн ганганалдаж эхлэхэд “Тогорууны бөгс хатчихжээ, тэнгэрээс хур дуудаад эхэллээ, ашгүй борооших байгаа” гэцгээдэг сэн. Үнэхээр маргаашаас нь бороо орж эхэлнэ дээ. Үүнийг бороо дөхөхөөр агаар дахь чийг дуслын хэмжээ ихсэж, газар байснаас тэнгэрт байсан нь хамаагүй сэрүүхэн болдогтой холбон тайлбарлаж болох юм.

Хөдөөний хүүхдүүд, сүрэглэн алхах тогорууг харж

Тогоруу сайхан

Тоодог муухай

Тогоруу, тогоруу

Цам харай, цам харай гэж хашхиралддаг. Үүнийг сонсоод тогоруунууд үнэхээр хөдөлгөөнд ороод явчих шиг санагддаг. Далавчаа дэвж гэдэлзэж годолзож гүйгээд л. Тэгэхдээ энэ нь хүүхдүүдийн үгэнд онгирууд цам харайгаад байгаа юм биш. Өөр лүү нь харж хашхиралдаад байхад ямар ч амьтад түгшүүр төрж үймэлдэлгүй яах вэ дээ.

Харин жинхэнэ цам харайх нь өөр учиртай явдал юм. Тогоруунууд хавар ирснийхээ дараа... олноороо цугларч, эр нь эм шувуудаа бүжигт урих мэт элэн халих хөдөлгөөн хийж, нисэх, гүйх хоёрыг хослуулан бүжихийг цам харайх гэдэг. Цам харайх бүжиг хоёр гурван хоног үргэлжлэх бөгөөд энэхүү “гаанц”-аас тарахдаа ижил ханиа олцгоож, хос хосоороо хорвоогийн зүг зүг тийш нисэн одоцгоодог юм.

(Ж. Мянгарсүрэн)

а. Дараах үгсийн утгыг тайлбарлаарай.

цам	<input type="text"/>
ноохой	<input type="text"/>
“гаанц”	<input type="text"/>

б. Эхийг уншаад, дараах асуултад хариулж бичээрэй.

- Хүмүүс яагаад тогорууны үүр ноохойд ойртож чадалгүй буцдаг вэ?
- Монголчууд яагаад үр хүүхдэдээ “Шувууны үүрэнд сүүдрээ бүү хүргэ. Эх нь тоохоо больж, хүүхдүүд нь харангадаж үхдэг” гэж сургадаг вэ?
- “Тогорууны үүрийг нь сандаачиж, өндгийг нь няцалбал төмөр дөрөө сэтгэртэл хараадаг” гэж хэлдгийн учрыг ярилцана уу.
- Бороо орохын өмнөх өдөр олон тогоруу агаарт эргэлдэн ганганалдаж эхэлдгийг зохиогч “агаар дахь чийг дуслын хэмжээ ихсэж, газар байснаас тэнгэрт байсан нь хамаагүй сэрүүхэн болдогтой холбон тайлбарлаж болох юм” гэсэнтэй санал нийлж байна уу?

в. Эхийг дараах асуултаар задлан шинжлээрэй.

- Цогцолбор бүрээс гол санаа илэрхийлсэн өгүүлбэрийг олж, тэмдэглээрэй.
- Цогцолбор бүр дэх гол санааг ямар ямар баримтаар баталж, дэлгэрүүлсэн байна вэ?


- Эхийн агуулгыг товч зураглаарай.

г. Зохиогчийн мэдрэмж, сэтгэгдэл, дүгнэлт, үзэл бодлыг илэрхийлсэн өгүүлбэрийг ялгаж тэмдэглээрэй. (✓)

Өгүүлбэр	Мэдрэмж сэтгэгдэл	Дүгнэлт	Үзэл бодол
...ая тал засах нь зөөлөн сэтгэлт хүнийг зүг чигээ өөрчлөхөөс аргагүйд хүргэдэг.			
...агаар дахь чийг дуслын хэмжээ ихсэж, газар байснаас тэнгэрт байсан нь хамаагүй сэрүүхэн болдогтой холбон тайлбарлаж болох юм.			
Тэгэхдээ энэ нь хүүхдүүдийн үгэнд онгилоод цам харайгаад байгаа юм биш. Өөр лүү нь харж хашхиралдаад байхад ямар ч амьтад түгшүүр төрж үймэлдэлгүй яах вэ дээ.			
...эр нь эм шувуудаа бүжигт урих мэт элэн халих хөдөлгөөн хийж, нисэх, гүйх хоёрыг хослуулан бүжихийг цам харайх гэдэг.			

д. Эхэд “цам харайх” гэсэн үгийн утгыг ямар аргаар тайлбарласан байна вэ? Ярилцаарай.

е. Дараах гурван өгүүлбэрийн аль нь загварт тохирох вэ?



- ✓ Тогорууны үүрийг нь сандаачиж, өндгийг нь няцалбал төмөр дөрөө сэтэргэл хараадаг.
- ✓ Өөр рүү нь харж хашхиралдаад байхад ямар ч амьтад түгшүүр төрж үймэлдэлгүй яах вэ дээ?
- ✓ Үүр ноохойд нь дөхөж очиход гүйж ирээд, далавчаа дэвсэн тонголзон бөхөлзөж, ая тал засах нь зөөлөн сэтгэлт хүнийг зүг чигээ өөрчлөхөөс аргагүйд хүргэдэг.

ё. Дараах өгүүлбэрүүдийг шалтгааны утгатай нийлмэл өгүүлбэр болгон найруулж бичнэ үү. Шалтгааны утгатай холбох үг, холбох нөхцөлөөс сонгон, боломжтой бүх хувилбараар найруулж бичээрэй.

- ✓ Тогоруу гэдэн гэдэн алхана. Газар цөмлөчих вий гэж ийнхүү гэтэж явдаг гэж хүмүүс дооглодог юм.
- ✓ Намар тариа боловсрох үед тариан түрүүгээр хооллох нь ихэснэ. Тариан талбай үтрэм бараадаж, хэдэн зуугаараа цуглардаг юм.

3. Эхийг уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Хуульч Сандаг

Хуульч Сандаг бол ХҮШ зууны сүүлч, XIX зууны эхэн үед Түшээт хан аймаг (одоогийн Дорноговь аймгийн Сайхандулаан, Дундговийн Баянжаргалан сум)-т амьдарч байжээ. Тэрээр аливаа юмыг цэцэн цэлмэг, яруу сайхнаар зүйрлэн хэлдэг, билиг оюунтай хүн байсан учраас “Хуульч Сандаг” хэмээн алдаршжээ. Хуучин цагт монгол хэлэнд үлгэр ярихыг “хууль ярих”, үг хэл уран цэцэн хүнийг “хуульч” гэж нэрлэдэг байв.

Сандаг нь цээжээр шүлэглэн зохиодог гоц авьяастай яруу найрагч тул Монголын уран зохиолын “үг” хэмээх өвөрмөц зохиолын хөгжилд их хувь нэмэр оруулсан гэж судлаачид үздэг. Түүний бүтээл ард түмний дунд өргөн дэлгэрснээс гадна цөөнгүй гар бичмэл нь Дорноговь, Завхан, Ховд, Дорнод аймгийн нутгаас олджээ.

- a. Эхээс шалтгааны утгат өгүүлбэрийг олж, дараагийн өгүүлбэртэй юугаар холбогдсоныг тайлбарлана уу.
- б. Хуульч Сандагийн “Хайлаад урсаж буй цасны хэлсэн үг” шүлгийг гүйцээж бичээрэй.

Нөхөх үгс: “өвлийн, өргөн, цантуулж, сонин, хунгарлаж, хавтгай, урагдлаа, гуниг, идэр, халуун”

..... хүйтний ачтайд
Өөрийн биеийн элбэгт
..... талыг бүтээгээд
Өвсний толгойг.....
Өөтэй газрыг
Өөхтэй малыг үхүүлж байхад
Үнэхээрбайж билээ
Хаврын сар ч гарлаа
.....тал ч харлалаа
Хамаг бие ч
Харинтөрлөө
Ирсэн шигээ буцъя гэхнээ
..... нас буурч
Энд байзная гэхнээ
Энэ салхийг яах вэ.

- в. Зохиогчийн сэтгэл хөдлөлөө оруулж бичсэн хэсгийг ялган бичээрэй.
- г. Эхээс уран дүрслэл бүхий хэсгийг ялгаж, яаж дүрсэлснийг тодорхойлно уу.
- д. Шүлэг бүхэлдээ ямар уран дүрслэлээр бүтсэн байна вэ? Жишээгээр тайлбарлаарай.
- е. Шүлэгт өгүүлэгдэж буй юмсын шалтгаан, үр дагаврыг бүдүүвчээр үзүүлээрэй.
- ё. Шалтгааны утгат нийлмэл өгүүлбэр ямар аргаар холбогдсоныг тайлбарлана уу.

Барс цагт босохгүй бол өдрийн ажил алдана
Багадаа эрдэм сурахгүй бол насны явдал хоцорно.

Нарны гэрэл хурц болоход үүлгүй бол нэн сайн
Насны багад эрдэм сурахад залхуугүй бол нэн сайн

ӨӨРИЙГӨӨ ШАЛГАХ ХУУДАС

	Маш сайн ойлгосон	Давтана	Дахин судална
Унших			
Эхээс дүрслэлийг ялган таньж сурсан уу?			
Хэлцийг ялгаж, утга, уран дүрслэлийг тайлбарлаж сурсан уу?			
Чухал баримт, мэдээллийг эхээс ялгаж сурсан уу?			
Мэдээлэн тайлбарласан эхийг таньж, онцлогийг нь тайлбарлаж сурсан уу?			
Шалтгаан, үр дагаврын холбоо хамаарлыг тодорхойлж сурсан уу?			
Баримт ба мэдээллийг нэгтгэн дүгнэж сурсан уу?			
Дэвшүүлсэн асуудал, түүний шалтгаан, үр дагаврын холбоо хамаарлыг тайлбарлаж сурсан уу?			
Бичих			
Хэлцийг ашиглан, эх зохион бичиж сурсан уу?			
Үзсэн, харсан, сонссон зүйлээсээ төрсөн сэтгэгдэл, мэдрэмжээ ялгарахаар илэрхийлж сурсан уу?			
Хүн, юм, үзэгдэл, үйл явцыг мэдээлэн тайлбарлаж бичиж сурсан уу?			
Зөвлөгөө бичихдээ учир шалтгаан, үр дагаврын холбоо хамаарлыг тодорхой гаргаж сурсан уу?			
Тогтсон загварын дагуу өргөдөл бичиж сурсан уу?			
Баримт ба дүрслэлийг харьцуулан дүгнэж бичиж сурсан уу?			
Цуглуулсан баримтаа нэгтгэн, тайлбарлаж сурсан уу?			
Асуудлыг тайлбарлан бичиж сурсан уу?			
Ярих			
Бусдын өмнө мэдээ, танилцуулга хийж сурсан уу?			
Бусдад зөвлөгөө өгч сурсан уу?			
Илтгэл тавихад бэлтгэж сурсан уу?			
Сонсогчоо мэдэрч үр дүнтэй илтгэж сурсан уу?			
Хэл зүй, дүрэм			
Нутгийн аялгууны үгийг таньж, зөв хэрэглэж сурсан уу?			
Угсарсан нийлмэл үгийг таньж, утгыг тайлбарлаж сурсан уу?			
Гадаад үгийг зөв бичиж, зөв хэрэглэж сурсан уу?			
Шалтгааны утгатай угсарсан нийлмэл өгүүлбэрийн бүтсэн аргыг тодорхойлж сурсан уу?			
Хагуу, зөөлний тэмдгийн дүрмийг зөв хэрэглэж сурсан уу?			
Балархай эгшгийн дүрмийг зөв хэрэглэж сурсан уу?			
Өгүүлбэр зүйд холбогдох дүрмийг зөв хэрэглэж сурсан уу?			

НУТГИЙН АЯЛГУУНЫ ҮГИЙН ТАЙЛБАР

альк (ойрд)– аль
амаршалаха (буриад)– мэндлэх
асарт (өвөр монгол) – байр, сууц
бишмэд (халимаг) – эрэгтэй хүн өмсдөг дээл
годоһо (буриад) – гутал – бод малын арьсыг элдэж хийсэн бойтог маягийн гутал
госн (ойрд) – гутал
готовол (ойрд-баяд) – гутал, хөлийн өмсгөл
дамбаалаө (казак) – Казак эрчүүдийн өмсдөг хилэн өмд
дуулаһаар (буриад)- сонссоор
дуһаһаар (буриад) – дуссаар
дүүргэхэ (ойрд, буриад) - төгсөх
ёвсув (ойрд) - явъя
иркүлэ (ойрд)– ирвэл
күмэн (ойрд) - хүн
күүндэдэх (ойрд) – хүндлэх
зон (буриад) – ард олон, улс, ард түмэн
маага (ойрд -урианхай) – Урианхайчуудын өмсдөг гутал
маяг (ойрд -урианхай) – дотуур өмсдөг богино өмд
санатн (ойрд) – санаарай, та
сөөхий (халх) – элдсэн арьсаар хийсэн бойтог гутал
соо ~ зосоо (буриад) - дотор
суутан (ойрд) – сууна уу, та
сэсэн (буриад) – цэцэн
тангачи (ойрд) – олон түмэн, ард түмэн
тоокуу (ойрд-торгууд) – ширэн ултай, эсгий толгойтой, оймсон гутал
тоонто (буриад) – төрсөн газар
тооровч (буриад) – малгай
тохонта (ойрд) – уугуул нутаг, уугуул нутгийн хүн
төгссөнөөс аваад (өвөр монгол) – төгссөнөөс хойш
тэдэнһүр (ойрд- торгууд) – түүгээр
ужмаг (өвөр монгол- ордос) – Эхнэр хүн дээлийнхээ гадуур өмсдөг ханцуйгүй
богино цээживч
һуугты – сууна уу, та
һургуули (буриад) - сургууль
хайшан гэхэб та (буриад) – яах вэ, та
харний (халимаг) – уулзъя,учиръя
хөөрөлдэхэ (буриад) – ярилцах
уулжаадуй (өвөр монгол) – уулзаагүй
хүчиртэй юу (өвөр монгол) – хэцүү, бэрх үү
хэлчэх (өвөр монгол) – хэлэлцэх, ярилцах
цэгдэг (ойрд) – тэрлэг дээлийн гадуур өмсдөг ууж
шаавар (өвөр монгол - урад) – хагас түрийтэй шаахай
шигшрэг – хазаарын зуузайд тав, таваар хэлхсэн гонзгой төмөр.
Шигэр шигэр гэж дуугарна. Шигшрэгийн ай болно.
эдэнһүр(ойрд- торгууд) – үүгээр
яганайт (ойрд) – яах вэ, та